



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-10
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11-115

Хууль, тогтоолын төсөл эцэслэн батлах /Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан	
1. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл/	12-13
2. Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах асуудал /Гүргэлжилнэ/	13-14
3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилгох тухай асуудал	14-41
4. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.18-ны өдөр ирүүлсэн/	41-49
5. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 7 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	49-76
6. Ерөнхий сайдын мэдээлэл: Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжэрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар, стандартыг сайжруулах талаар	76-115

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 21-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Жавхлан, Б.Пүрэвдорж, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Ганхуяг, Ц.Сэргэлэн, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн;

Тасалсан: Ц.Анандбазар, С.Батболд, Ж.Батсуурь, Х.Нямбаатар;

Хоцорсон: С.Амарсайхан – 1 цаг 07 минут, Т.Аубакир – 41 минут, Ж.Бат-Эрдэнэ – 27 минут, Х.Болорчулуун – 20 минут, С.Ганбаатар – 16 минут, Ш.Раднаасэд – 25 минут, Б.Энх-Амгалан – 37 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг.Хууль, тогтоолын төсөл эцэслэн батлах /Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу Хууль, тогтоолын төсөл эцэслэн батлах санал хураалтыг явуулав.

Г.Занданшатар: Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 8

Бүгд: 44

81.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 8
Бүгд: 44
81.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 4
Бүгд: 44
90.9 хувийн саналаар хууль батлагдлаа.

Г.Занданшатар: Холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 11
Бүгд: 44
75.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Г.Занданшатар: Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 0
Бүгд: 44
100 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах асуудал /үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Г.Занданшатар: Хянан шалгах түр хорооны саналаар, “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголтын эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлаас гаргах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 5

Бүгд: 44

75.0 хувийн саналаар санал дэмжигдсэн тул тогтоол батлагдсанд тооцов.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.8-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны асуудлаарх хяналт шалгалтын түр хороог татан буугдсанд тооцов.

Уг асуудлыг 10 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч С.Эрдэнэбат, нэр дэвшигч Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга Б.Алтанхуяг, Монголын шинжлэх ухааны байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Т.Баясгалан, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын Нэгдсэн холбооны Ерөнхийлөгч, “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн захирал Ш.Зоригоо, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Гэрэлмаа, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимийн дэргэдэх Бизнесийн академийн чиглүүлэгч багш, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрдмийн зөвлөлийн гишүүн Н.Одонгуа, Нийгмийн бодлогын байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч, судлаач Л.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ц.Туваан, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, Д.Сарангэрэл, Ч.Ундрам, Б.Саранчимэг, Д.Батлут, Ж.Чинбүрэн нарын тавьсан асуултад Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин, нэр дэвшигч Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч С.Эрдэнэбат, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн

холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Гэрэлмаа, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын Нэгдсэн холбооны Ерөнхийлөгч, “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн захирал Ш.Зориггоо нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан саналыг нууц санал хураалтаар явуулав.

Г.Занданшатар: Сүхбаатарын Эрдэнэбатыг Даатгуулагчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 20
Бүгд: 50
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Баасангийн Алтанхуягийг Даатгуулагчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 19
Бүгд: 50
62.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Түдэвийн Баясгаланг Даатгуулагчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжээгүй Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 30
Бүгд: 50
40.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Г.Занданшатар: Шагдарын Зориггоог Ажил олгогчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжээгүй Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 33
Бүгд: 50
34.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Г.Занданшатар: Жамсрангийн Гэрэлмааг Ажил олгогчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 17
Бүгд: 50
66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Нэмэхээгийн Одонгуаг Ажил олгогчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 15
Бүгд: 50
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /11:41/

Уг асуудлыг 11 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.18-ны өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ч.Ундрам, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /12:02/

Уг асуудлыг 12 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 7 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Д.Тунгалаг, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ж.Төмөрхуяг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн төслийн менежер Б.Алтанцэцэг, “Тохирлын үнэлгээний байгууллагын хөгжлийн төв” төрийн бус байгууллагын захирал Л.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Ганбаатар, Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Г.Мөнхцэцэг, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын ахлах шинжээч Д.Тунгалаг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн төслийн менежер Б.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Б.Саранчимэг, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 14

Бүгд: 42

66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 10 минут үргэлжилж, 13 цаг 20 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 09 минутад эхлэв.

Зургаа.Ерөнхий сайдын мэдээлэл: Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар, стандартыг сайжруулах талаар

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга М.Баяраа, Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Г.Баярсайхан, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Ч.Батзориг, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Адьяасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, референт Ж.Монголжингоо нар байлцав.

Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар стандартыг сайжруулах талаар мэдээлэл хийв.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Ч.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга М.Баяраа, Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Г.Баярсайхан, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Ч.Батзориг, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Адъяасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар стандартыг сайжруулах талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямаас 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоолын төсөл татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо. /15:53/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Бусад.“Манлайлагч эмэгтэйчүүдийн оролцоо” олон улсын хуралд оролцож буй төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Нийслэлийн Баянзүрх дүүргийн 35 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн урилгаар Говьсүмбэр аймгийн 1 дүгээр сургуулийн 11 дүгээр ангийн багш, сурагчид, “Эм интернэйшнл” ХХК-ийн хамт олон, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 11-ийн А ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Амарсайхан нарын урилгаар Төв аймгийн Баяндэлгэр сумын бөхийн холбооны гишүүд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 55 минут үргэлжилж, 73 гишүүнээс 52 гишүүн хүрэлцэн ирж, 71.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 09 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Ирц бүрдсэн учир Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Гишүүд суудалдаа сууцгаая.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Нийт 3 төсөл байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах асуудал үргэлжилнэ.

Гуравдугаарт, “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батална.

Дөрөвдүгээрт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал хэлэлцэнэ.

Тавдугаарт, Органик бүтээгдэхүүний хуулийн шинэчилсэн

найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар, стандартыг сайжруулах асуудлаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Манай эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл энэ асуудлаар асуулга тавьсан байгаа. Тэгээд үүнийг хамтатгаад сонсож болох байх гэж бодож байна.

Ингээд Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Ингээд санал хураалт явуулна.

Бүртгэлийн санал хураалт явуулна. Суудалдаа сууцгаасныг шалгаж бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

Ширнэнбандийн Адьшаа, Д.Батлут, Б.Баттөмөр, Б.Бейсен, Н.Ганибал, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ж.Сүхбаатар, О.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, С.Чинбүрэн, Б.Энхбаяр, Нямаагийн Энхболд нарын гишүүд бүртгэлд ороогүй байна.

Саяын бүртгэлийн санал хураалтад оролцсонгүй. Б.Саранчимэг гишүүн. Х.Болорчулуун сайд яасан юм.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батална.

Дараа нь манай Цэвэгдоржийн Туваан, Жигжидийн Батжаргал. Хэн хэн гишүүд билээ, санаачилсан нөгөө Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын

шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг эцэслэн батална. Ийм гурван төсөл батлах юм байгаа юм.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Хууль, тогтоолын төсөл эцэслэн батлах /Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл/

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу долоо хоногийн Баасан гаргийн 10.00 цагаас нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна гэж заасан.

Энэ дэгийн дагуу санал хураалт явуулна.

Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал бол хууль батлах гэж байгаа. Үндсэн хуулийн тайлбар номд бичсэн тодорхойлолтоор “...бүрэн эрх гэдэг бол эрх үүргийн цогц нэгдэл юм.” гэж байгаа юм.

Тэгэхээр хууль батлах үүрэгтэй гэсэн ийм агуулгаар тайлбарласан байна лээ. Б.Чимид гуай болон Н.Лүндэндорж гуай нар.

Ингээд санал хураалт явуулъя.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн бүрэн эрх гэдгийг хүмүүс, гишүүд өөрөөр ойлгоод байдаг. “Бүрэн эрх” гэдэг бол “бүрэн” гэсэн утгаараа “эрх, үүргийн цогц нэгдэл” гэж байгаа. “Үүрэг” нь бол бас “хууль батлах үүрэгтэй” гэж байгаа.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Их Хурлын дарга аа, сая миний кноп дээр жоохон техникийн саатал гарлаа. Тэгээд эсрэг гарчихлаа. Би уг нь дэмжсэн байгаа юм. Дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Даваажанцангийн Сарангэрэл гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Д.Сарангэрэл гишүүний саналаар хүчингүйд тооцох санал хураалт явъя. /алх цохив/

81.8 хувийн саналаар санал хураалт дэмжигдлээ.

Санал хураалт дэмжигдсэн учраас дахиж санал хураалт явуулна.

36 дээр Одонгийн Цогтгэрэл гишүүн, Ц.Туваан гишүүн. Дараа нь Засгийн газраас төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгал бол эрүүл мэндийн шимтгэл суутган төлөх хуулийн төслүүд чинь батлагдана шүү дээ.

Дамбын Батлут гишүүн яагаад хоцроод байна. Санал хураалт явуулж байхад. Дамбын Батлут гишүүн. Энэ Гочоогийн Ганболд гишүүнийг дуудъя. Сая эсрэг гараад байна тэгвэл.

Эцэслэн батлах гэж байгаа байхгүй юу. Эцэслэн батлах гэж байгаа учраас. 39-өөр эцэслэн батална.

Тогмидын Доржханд гишүүн. Санг компани болгож байгаа юм. Тусгай сангуудыг чинь компани болгож, компанийг чинь олон нийтийг хяналттай болгоно шүү дээ. Дараа нь.

Нөгөө тусгай сангууд чинь болохгүй байгаа учраас үүнийг чинь л өөрчилж байгаа шүү дээ. Тийм ээ. Агуулга нь ийм л хууль гэж ойлгож байна.

Хоёр.Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг танилцуулах асуудал /үргэлжлэл/

Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хянан шалгах үүрэг бүхий түр хорооны

Ингээд саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас хуулийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. /алх цохив/

Холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Энэ дээр чинь О.Цогтбаатар гишүүний санаа явж байгаа шүү дээ.

33 гишүүн дэмжиж, тогтоол эцэслэн батлагдлаа. /алх цохив/

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

44 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар энэ хуулийн төсөл батлагдлаа. /алх цохив/

Дараагийн асуудалд орёе.

санал, дүгнэлтийг танилцуулах асуудал үргэлжилнэ.

Тайлангаа танилцуулчихсан. Тийм ээ. Дуусчихсан. Одоо Хянан шалгах түр

хорооны тайлан болон санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Хянан шалгах түр хорооноос “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголтын эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлаас гаргах шаардлагатай гэж үзсэн тул Хянан шалгах түр хорооны саналаар санал хураалт явуулна.

Хянан шалгах түр хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Ер нь Хөгжлийн банкны бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх, актив, пассивын удирдлагыг сайжруулах, хараат бус мэргэжлийн удирдлагатай болох энэ тэр гэсэн тийм зарчмын чиглэл болгож байгаа ийм санал гэж ойлгогдсон.

Ингээд Хянан шалгах түр хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

Гурав. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудал хэлэлцэнэ.

Нэр дэвшигчийн талаар гаргасан Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа танилцуулна.

39 гишүүн дэмжиж, 88.6 хувийн саналаар тогтоолын төсөл гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Ингэхээр чинь тогтоол батлагдсан уу? Б.Баттөмөр гишүүн ээ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ээ. Тэгээд санал дэмжигдсэн учраас тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын төслийнхөө найруулгыг эцэслэн гаргаарай.

Ингээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 56.8-д Түр хороо тайлан, санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулснаар уг хороог татан буугдсанд тооцно гэж заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны асуудлаарх хяналт шалгалтын түр хороог татан буугдсанд тооцлоо. /алх цохив/

Тогтоолын төсөл батлагдсан. Хянан шалгах түр хороо татан буугдсанд тооцлоо.

Эцсийн найруулгыг чуулганаар хэлэлцэж батлах ёстой. Эцэслэн батлахыг нь.

Ингээд дараагийн асуудалд орёе.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 14.1.3 дахь хэсгийг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос тус холбооны Ерөнхийлөгч С.Эрдэнэбат, Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга Б.Алтанхуяг, Шинжлэх Ухааны Академийн Хэл, зохиолын хүрээлэнгийн секторын эрхлэгч, шинжлэх ухааны байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Т.Баясгалан, ажил олгогчийг төлөөлсөн гишүүнд Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооноос Монголын Хувийн Хэвшлийн Эрүүл Мэндийн Байгууллагын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч, “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн захирал Ш.Зоригоо, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Гэрэлмаа, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимаас тус танхимын дэргэдэх Бизнес академийн чиглүүлэгч багш, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрдмийн зөвлөлийн гишүүн Н.Одонгуа нарыг Улсын Их Хуралд санал болгосон.

Байнгын хороо Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 14.1.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123, 126 дугаар зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.8 дахь хэсэгт заасны дагуу Эрүүл мэндийн

даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, турш, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Л.Мөнх-Эрдэнийг томилох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дэмжиж томилсон.

Хараат бус шинжээч нэр дэвшигчтэй ирүүлсэн баримт бичигтэй танилцаж нэр дэвшигчтэй ганцаарчилсан ярилцлага хийж, гаргасан дүгнэлтдээ нэр дэвшигчийн сонсголын үеэр танилцуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэгт заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, сонсголын тайлан гаргасан.

Тус тайланг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ц.Идэрбат Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан бөгөөд сонсголын тайланд даатгуулагчийг төлөөлсөн гишүүн, нэр дэвшигч С.Эрдэнэбат, Б.Алтанхуяг, Х.Баясгалан, ажил олгогчийг төлөөлсөн гишүүн, нэр дэвшигч Ж.Гэрэлмаа, Н.Одонгуа нарыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагч болон ажил олгогчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан.

Ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр нэр дэвшигч Ш.Зоригоог эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хувийн байгууллагад тодорхой албан тушаал хашдаг нь тусламж, үйлчилгээ авдаг байгууллагад тодорхой даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, төлөөлөн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөл байж болохгүй

гэсэн зарчмыг үндэслэн уг албан тушаалд тавигдах шаардлага хангаагүй гэсэн дүгнэлтийг тусгажээ.

Цаашид Монголын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохдоо Үндэсний зөвлөл нь санхүү, эрүүл мэндийн, эдийн засгийн нарийн судалгаа, тооцоонд үндэслэн мэргэжлийн шийдвэр гаргадгийг харгалзан үйлдвэрчний эвлэлд олон жил ажилласан үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл гэхээс илүү нийт даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрүүл мэндийн салбарын эдийн засгийн асуудлаар мэргэшсэн мэдлэг, ур чадвартай хүнийг дэвшүүлэхийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай талаар зөвлөмж хүргүүлсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нэр дэвшигчдээс эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээний чанар, хяналтын тогтолцооны талаар, Үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах боломжийг судалсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг шаардлагагүй эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх асуудал их байгаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний үр ашгийг бууруулж байгааг дурдаад, Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг хэрхэн хангаж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Монголын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос өмнөх Үндэсний зөвлөлд гишүүнээр ажиллаж байх хугацаанд олон алдаатай шийдвэрүүд гарч байсан бөгөөд нэр дэвшиж байгаа Монголын үйлдвэрчний холбооны Ерөнхийлөгч тус

Үндэсний зөвлөлд сонгогдвол хэрхэн ажиллах төлөвлөгөөтэй байгаа талаар асуулт асууж, хариулт авсан.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлж, даатгуулагчид үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, үндэсний зөвлөлийн дэргэдэх техникийн хороог яаралтай байгуулах, эргэх холбоотой ажиллах талаар,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа улсын эмнэлгийн ачааллыг бууруулах чиглэлээр хувийн эмнэлгүүдээ дэмжих, эмнэлгүүдийн шаардлагагүй хэвтэн эмчлүүлэгчдийн зардлын иргэнээс гарах хувийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн талаар,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир шинээр томилогдох Үндэсний зөвлөлийн гишүүд бусдын нөлөөнд авталгүй бие даасан, хараат бус шийдвэр гаргах, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэрүүдийг олон нийтэд сайтар сурталчлан таниулах, магадлан итгэмжлэгдээгүй сувиллууд даатгалын сангаас их хэмжээний санхүүжилт авч байгаад хяналт тавих, уг асуудлыг Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны дараа жилийн тайланд тусган танилцуулах талаар,

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нэр дэвшигчдийг бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлээд, эх орондоо эмчлэгдэх боломжгүй өвчнөө бусад улс оронд эмчлүүлээд ирсэн иргэддээ Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас тодорхой зардлыг олгодог болох талаар, хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөлийн

үед шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын үйл ажиллагааны доголдолтой нөхцөл байдлын талаар, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, сувилагчдын ажлын ачаалал болон тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх талаар анхаарч ажиллах саналаа тус тус хэлсэн болно.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигч С.Эрдэнэбат, Б.Алтанхуяг, ажил олгогчийг төлөөлсөн гишүүн нэр дэвшигч Ж.Гэрэлмаа, Н.Одонгуа нарыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, даатгуулагчийг төлөөлсөн гишүүн, нэр дэвшсэн Т.Баясгалан, ажил олгогчийг төлөөлсөн гишүүн, нэр дэвшсэн Ш.Зоригоо нарыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагч болон ажил олгогчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшсэн нэр дэвшигчийн танилцуулга, хараат бус шинжээчийн дүгнэлт, сонсголын тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлт, эрх бүхий албан тушаалтны санал болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Б.Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Нэр дэвшигч Сүхбаатарын Эрдэнэбат Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч, нэр дэвшигч Баасангийн Алтанхуяг Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга, Түдэвийн Баясгалан Монголын шинжлэх ухааны байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга,

Энэ Үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүн нэр дэвшүүлсэн байна.

Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимаас нэр дэвшүүлсэн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлсэн.

Шагдарын Зоригоо Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын Нэгдсэн холбооны Ерөнхийлөгч, “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн захирал, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Жамсрангийн Гэрэлмаа, Монголын Үндэсний

Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимийн дэргэдэх Бизнесийн академийн чиглүүлэгч багш, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрдмийн зөвлөлийн гишүүн Нэмэхээгийн Одонгуа, шинжээч, Нийгмийн бодлогын байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч, судлаач Лувсангийн Мөнх-Эрдэнэ.

Одоо Буланы Бейсен гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг нэг явж байгаа.

Б.Бейсен: Та бүгдэд өглөөний мэнд хүргэе.

Энэ нэр дэвшигч нарыг дэмжиж байна. Ерөнхийдөө. Нэр дэвшигчид дэмжигдээд батлагдчихвал Та бүгдээс асуух асуулт байна.

Эрүүл мэндийн даатгалын шалгуур үзүүлэлтүүд байж байна. Улсын эмнэлэг, сумдын эмнэлэг, хувийн эмнэлгүүдийн.

Энэ нь арай өндөр. Үүгээрээ бас оноог нь хасчихдаг. Жишээлбэл, рентген аппарат, MRI, компьютер томограф байхгүй гэдэг шалтгаанаар уушгины хатгаа, бусад өвчтөнүүдийг ингээд шалгуур үзүүлэлт тогтоочихсон.

Гэтэл үүнийг сум, хувийн эмнэлгүүдийн, зарим өрхийн эмнэлгүүдийн түвшинд хангах ямар ч боломж байхгүй шүү дээ. Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа.

Гэтэл үүгээр эмчилгээ хийгээд төсвөө зарчихдаг. Шалгуур үзүүлэлтийн юугаар ингээд хасчхаад байна. Төсвийн. Үүнийг яаж шийдэх вэ та нар. Нэгдүгээрт.

Жишээлбэл, Баян-Өлгийд сая хувийн эмнэлэг дээр нэг MRI аппарат тавьсан байна. 500 мянган төгрөгийн төлбөртэй. MRI-д харуулахгүй бол тэгээд нөгөө нэхэмжлэлээ хассан байх юм.

Одоо 10-аас 30 сая хүртэл хасаж байна шүү дээ. Хувийн эмнэлгүүдийн төсвөөс зарчихсан юмыг. Үүнийг яаж шийдэх вэ?

Хоёрдугаарт, хөнгөлөлттэй эмийн талаар.

Хөнгөлөлттэй эм гээд 580 эм байгаа. Та бүгд судлаад үзээрэй. Энэ чинь 200 хэдхэн эм байгаа. Нэг эм гэхэд олон кодтой. Үүгээрээ бас цаана нь бизнес явагдаж байгаа юм биш биз гэдэг асуудал байж байна.

Яах вэ доз нь өөр байж болно. Доз нь ижилхэн мөртлөө өөр кодтой эмүүд орж ирж байгаа.

Хөдөөгийн ард иргэд энэ хөнгөлөлттэй эмийг авч чадахгүй юм. Малчин ард иргэд. Үүнийг яаж шийдэх вэ. Дахиж хуралдаанд оруулаад үүнийг шийдэх үү? Эрүүл мэндийн яамтай хамтарч байгаад энэ асуудлыг шийдэхгүй бол хөнгөлөлттэй эмийг ерөөсөө авч чадахгүй байна. Энэ талаар ямар бодлого баримталж байна?

Хоёрдугаарт, одоо гүйцэтгэлийн санхүүжилтээр хангах боломж тун муу байна. Харин сумдын эмнэлэг, өрхийн эмнэлгүүдийн санхүүжилтийг хүн амын тоогоор хоёр дахин нэмсэн. Түүгээр л байж байна.

Хөдөөгийн эмнэлгүүд ерөөсөө зөвхөн цалин авсан, хоосон байж байгаа улсууд байж байна. Аппарат, тоног төхөөрөмжийн дутагдалтай байж байна. Эмч, ажилчдын цалинг нэмэх асуудал

дээр ер нь сүлжээгээ хоёр дахин нэмэхгүй бол цалин авч чадахгүй байна.

Одоо хотын эмнэлгүүдээр ч гэсэн асрагч, сувилагч, эмч нар их дутагдалтай болж байна. Зарим эмнэлгүүд дээр 30, 40 сувилагч дутагдалтай байж байна. Эмч, эмнэлгийн ажилтан тултал нь гарч байна.

Энэ асуудлыг Эрүүл мэндийн яамтай хамтарч байгаа та бүгд шийдэх л асуудал гэж ярьж байна.

Тэгэхгүй бол эрүүл мэндийн салбарын ажилчдын ихэнх нь цалингийн зээлтэй, цалин бага, одоогийн инфляцын өндөр түвшин, өргөн хэрэглээний бараа, бензин шатахуун, эмийн үнийг дийлэхгүй байна шүү дээ. Үүнийг цаашдаа яаж шийдэх вэ?

Эрүүл мэндийн даатгалын зөвлөл үүнийг цааш нь шийдэх ёстой гэж бодож байна. Энэ талаар хариулт авъя.

Г.Занданшатар: Та хэнээс асуусан бэ? С.Чинзориг сайдаас асуухгүй л дээ энэ чинь. Нэр дэвшигчээс юм уу, Байнгын хорооноос асууж болно. Байнгын хорооны дарга хариулж болно. П.Анужин дарга хариулах уу?

Та наад асуудлаараа жичдээ асуулт юм уу, асуулга. Энэ С.Чинзориг сайдад хандаж асуулт тавь. Бүр шаардлагатай бол сонсгол хийж болно.

Дэгд байхгүй учраас хариулах боломж алга. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Үндэсний зөвлөлд орох гишүүдийг дэмжиж байна.

Тэгээд Та бүхэн сонгогдож дэмжигдээд очвол маш чухал шийдвэрүүдийг гаргана. Эрүүл мэндийн

даатгалын үндэсний зөвлөлийн дугаартай тогтоолууд байгаа.

Тэгэхээр энэ маш чухал шийдвэр. Тэгэхээр энэ шийдвэрүүд дээрээ маш тийм амьдралтай сайн судалгаатай ийм шийдвэрүүдийг гаргаарай. Тэгэхгүй бол энэ шийдвэрүүд чинь гараад яг анхан шатан дээр, ялангуяа хөдөө орон нутгийн эмнэлгүүд дээр очоод биелэгдэх боломжгүй ийм амьдралаас тасархай шийдвэрүүд бас гарсан байдаг шүү.

Тэгэхээр энэ дээр сайн анхаарч ажиллахыг хүсэж байна.

Дээрээс нь, сая Б.Бейсен гишүүн бас яриад байна. Би ч бас хэлдэг. Энэ орон нутгийн. Одоо бид 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа ээлжит бусаар хуралдаад энэ Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулсан юм.

Тэгээд энэ дотор тэр эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд оруулчихсан. Мэдээж энэ дэвшил. Тэгэхдээ энэ сумын, ялангуяа хөдөө орон нутгийн сумд дээр энэ асуудал жоохон хүнд байгаа. Би тэр үед нь үүнийг шилжилтийн зохицуулалттай явуулахгүй юм уу гээд.

Тэгэхээр С.Чинзориг сайдтай бас нэлээн ярилцаж, ойлголцож, энэ асуудал дээр шийдэл гаргахыг хайж байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн нэлээн дэмжиж, иргэдийнхээ талд. Ялангуяа тэр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч байгаа тэр хөдөө орон нутагт алслагдсан хүмүүсийнхээ талд шийдвэр гаргаарай гэж ингэж хүсье.

Дээрээс нь, одоо жишээлэх юм бол 25 километр дотор артерийн даралт ихсэх

өвчнөөр, одоо даралт ихсэлтээр дуудлага өгөх онош байхгүй. Тэгээд мэдээж хүн дуудлага өгөхөөр сумын эмч нар очно. Тэгээд хүрч ирээд худлаа юу тавьдаг. Өөр өвчний онош тавьж ингэж явдаг.

Тэгэхээр сумдын эмч нарыг гэхэд л албан ёсоор ингээд худлаа бүрдүүлэлт, гүйцэтгэл худлаа бичих тал руу нь ингээд шахаж байгаа л гэсэн үг.

Тэгэхээр энэ энэ зүйлүүдийг маш сайн анхаараарай.

Дээрээс нь **e-hospital** программ ороод овоо жигдрэлдээ ороод явж байсан чинь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага санхүүжилтээ татаад асуудал үүсчихлээ. Сая орон нутгаар явж байхад санхүүгийн программууд гацалттай болж ирж байна.

Тэгэхээр энэ дээр юу хэлж байна гэхээр тэд нар гүйцэтгэл бичиж санхүүжилт авах боломж нь ингээд муудаж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр та хэд бас ямар гаргалгаа гарч ажиллах вэ? Үүнийгээ сайн анхаарч ажиллаарай.

Дээрээс нь энэ юу үнэгүй эм гээд. Одоо бид нар бас нэлээн шахаж байгаад энэ “**NOVARTIS**”-ын эмүүдээс 20 гаруйн нэр төрлийн эмийг оруулж ирээд. Сая орон нутагт явж байхад 15 нэр төрлийн үнэгүй эмүүд сумд алдаг оног очсон байна.

Тэгэхээр энэ асуудлыг нэлээн өргөжүүлэх шаардлагатай. Юу гэхээр зарим сумд эмч нар нь үзээд оношоо бичээд үнэгүй эмээр үйлчилгээгээ явуулж байна. Ихэнх сумд. Бараг 100-ны 90 хувьд нь энэ үйлчилгээ очоогүй явж байна.

Тэгэхээр иймэрхүү гарсан шийдвэрүүд дээр бас нэлээн анхаарч ажиллаарай.

Дээрээс нь Үйлдвэрчний эвлэлийн хүмүүс орж байгаа учраас энэ сумын эмнэлгийн хүмүүсийн цалин хангамжтай холбоотой асуудал дээр дуугарч байгаарай. Ялангуяа тэр дотор төрийн үйлчилгээний албан тушаалтнууд маш хүнд ажил хийдэг. Маш бага цалинтай ийм хүмүүс байгаа.

Тэгэхээр тэр хүмүүсийн ажиллах нөхцөл, цалин хөлсөн дээр нь зөв шийд гаргаж байгаарай гэж хүсье.

Г.Занданшатар: Санал юм даа. Тийм ээ. Түрүүчийнхийг ч гэсэн үгд тооцлоо.

Ер нь яах вэ, сумын эмч нарын холбоог төлөөлсөн Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Гэрэлмаа санал бодлоо хариулах уу? 89.

Ж.Гэрэлмаа: Ц.Туваан гишүүний саналыг хүлээн авлаа.

Тэгэхээр ялангуяа эндээс харахад бид эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн асуудлыг сум, хөдөө орон нутагтаа илүү сайн хүргэх тал дээр бодлогын арга хэмжээ авах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Тэрийг бид тарифын зөрүүгээр, мөн бодит судалгаа хийх замаар, тэгээд даатгал, гэрээ байгуулахдаа эмийн сангуудтай тодорхой хэмжээний гэрээний зохицуулалтаар зохицуулах боломжтой зүйлс харагдаж байна гэж ойлголоо.

Тийм учраас яг асуудал хэлэлцэх үед энэ байр суурийг баримталж ажиллана.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Тэгэхээр манайд хамгийн тулгамдсан юм бол энэ нийгмийн эрүүл мэндийн асуудал байгаа юм. Хүн амыг өвчилсөн хойно нь биш өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгох энэ том бодлого, зорилтыг хэрэгжүүлэх асуудал зөвхөн эрүүл мэндийн салбарын төдийгүй Монгол төрийн бодлого, нийт ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага бидний үүрэг байх ёстой юм.

Тэгэхээр энэ талын авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол ахиц дэвшил гарахаасаа илүү дандаа ухралттай явж байгаа юм.

Би сая материалтай танилцахад хэлэлцүүлгийн явцад тэр сонсголын явцад олон гишүүд асуусан байна.

Тэгэхээр би тодорхой жишээ хэлье. Иргэд маань өөрсдийнхөө эрүүл мэндийг хамгаалж бэхжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлж, өөрийнхөө биеийг, өөрийгөө эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх энэ үйл ажиллагааг хийж байгаа хүн амыг, иргэдийг дэмжих энэ бодлого бидэнд хэрэгтэй байсан.

Тийм учраас Улсын Их Хурлын хоёр, гурван парламентын бүрэн эрхийн хугацаанд үүнийг судалгаан дээр үндэслэж байж, нэлээн хэлэлцүүлэг хийж байж хуульд өөрчлөлт оруулсан. Тухайлах юм бол энэ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг фитнес төв, энэ клубүүдэд аттестатчилалд оруулаад тэгээд тэнд тодорхой хэмжээний

санхүүжилт өгдөг. Үгүй тэр чинь зүй ёсны биз дээ.

Иргэд маань өөрсдийнхөө ажиллаж хөдөлмөрлөсөн орлогоос эрүүл мэндийн даатгалд төлбөр төлөөд, тэр төлбөрөө эргүүлж өөрийнхөө эрүүл мэндээ өвчлөлөөс урьдчилан сэргийлэх энэ үйл ажиллагаанд зарах нь шударга ёсны зарчим мөн биз дээ.

Тэгээд энэ тогтолцоог бий болгосон. Гэтэл ухралт гарсан. 2019 оны төсөв дагаж орж ирсэн хуулиар энэ дэвшлээсээ ухарсан. Хүчингүй болгосон. Ингээд эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжүүлэх энэ бодлогын хүрээнд тэрийг хүчингүй болгоод ингээд нөгөө эмнэлгүүд рүү өгчхөж байгаа юм. Яг бодит байдал дээр эмнэлгийн анхан шатын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгүүдийн өрхийн эмнэлгийн төв ч байдаг юм уу, тэнд үнэхээр санхүүжилт нь дутуу хэвээрээ л явж байгаа байхгүй юу.

Энэ дээр Та бүхэн маань юу гэж үздэг юм бэ?

Бусад хөгжингүй улс орнууд энэ хүний хөгжлийг дээдэлсэн, хөгжил дэвшилд хүрсэн улс орнууд чинь энэ бодлогыг тууштай баримталж байна шүү дээ. Сингапурыг хэлж болно.

Энэ цахимжчихсан. Иргэд нь зүүдэг бугуйвчтай цаг. Энэ бүх юмнуудыг нь цаанаас нь холболттой хараад тэгээд өдөрт 10 мянга алхалтынхаа эрүүл идэвхтэй амьдралынхаа хэв маягийг биелүүлж байгаа иргэдэд эрүүл мэндийн даатгалаас нь тодорхой урамшуулал өгдөг. Өөрийнх нь оршин суугаа хамгийн ойрын фитнес клубүүд, эрүүл мэндийн үйлчилгээ, биеийн тамирын үйлчилгээ үзүүлж байгаа энэ газарт нь хичээллэх тийм

боломж эрхийг нь нээж өгдөг гээд ийм сайн жишгүүд байна шүү дээ.

Яагаад бид ингээд энэ дэвшлээсээ ухардаг юм бэ. Их Хурлын гишүүд минь үүнийг анхаараарай.

Би их олзуурхаж байгаа юм бол энэ дотор Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга С.Эрдэнэбат орж ирж байна. С.Эрдэнэбаттай бид хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Хэд хэдэн удаа уулзсан. Энэ хүний ойлголт, хандлага саяын миний ярьж байгаа юман дээр тууштай ийм хүн байна лээ.

Би бүр зориуд баяр хүргэе.

Энэ чиглэлээр бид ажиллагсдын ажлын байран дээрх дасгал хөдөлгөөнөөс эхлээд бид зорьж байгаа олон асуудлууд байгаа.

Энэ талаар та нөхдүүд.../минут дуусав/

Г.Занданшатар: Манай С.Эрдэнэбат Ерөнхийлөгч сайн ажиллаж байгаа шүү. Тэгээд С.Эрдэнэбат Ерөнхийлөгч хариулах уу? 85.

С.Эрдэнэбат: Эрүүл мэндийн даатгалын бодлогод хүн амыг өөрийнхөө эрүүл мэндэд анхаарах энэ асуудлыг нь дэмжих. Өөрөөр хэлбэл эмнэлэгт өвдсөн тохиолдолд эрсдэл тохиолдсон тохиолдолд түүнээсээ урьдчилан сэргийлэх боловсролыг сайжруулах. Энэ чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын сангийн тодорхой хэмжээнд зарцуулагдах нь би зөв гэж боддог.

Бусад гаднын орнууд ч гэсэн аль болохоор Эрүүл мэндийн даатгалын сангаас тодорхой хэмжээний зардал мөнгийг ихээр гаргуулаагүй нөхцөлд тэр хүмүүсийг өөрөө өөрийнхөө төлөө эрүүл

мэндийнхээ асуудалд анхаарсан тэр идэвх сонирхлыг нь дэмжсэн бас ийм арга хэмжээнүүд байдаг юм билээ.

Тэгээд энэ тал дээр би түрүүний хэлсэн гишүүд болон Б.Бат-Эрдэнэ сайдтай энэ чиглэлээр санал тавьж бид уулзсан.

Тэгээд манай улсад бүх нийтийн биеийн тамирын эрүүл мэнд, хүн амын маань 52 хувь нь бараг таргалалттай. Үүнийгээ дагаад сахрын шижин, хөдөлгөөний дутагдал гээд. Үүнийгээ эмээр болон эмнэлэгт хэвтэж эмчлүүлнэ гэдэг ийм үндсэн ойлголттой байдаг.

Тэгэхээр энэ том нийгмийн нөлөөний асуудлыг зөвхөн энэ даатгалын мөнгөөр дарж эмчилнэ гэдэг боломжгүй зүйл.

Тийм учраас энэ нөлөөллийн ажлууд болон бусад бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд эрүүл мэндийн даатгалын нэг хэсэг тэр фитнес болон бусад юмаар хичээллэдэг, эрүүл байгаа хүмүүст тодорхой урамшуулал олгодог байсан асуудлыг эргэн судалж асуудлыг нь холбогдох яам болон мэргэжилтнүүдтэй ярилцаж энэ асуудал дээр анхаарч ажиллая гэж бодож байгаа.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Түрүүн цаг багтсангүй л дээ.

Одоо ингээд нэр дэвшиж байгаа улсуудыг цаашдаа анхаарах хэрэгтэй. Одоо энэ дотор дандаа том шатлалын, гуравдугаар шатлалын ч юм уу ийм эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг төв эмнэлгийн төлөөллөөс хүмүүс орж ирээд байна шүү дээ.

Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг хариуцдаг, шийддэг, оролцдог энэ байгууллагын төлөөлөл яагаад алга байна гэж. Тухайлах юм бол биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагаас байж болно.

Тэгээд үүнийгээ цаашдаа анхаарах хэрэгтэй.

Хүн ерөөсөө бие бялдраа хөгжүүлэх, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, хатуужуулах явц дундаа хүнлэг, зүрх сэтгэлийн боловсролыг олж байдаг. Мэдлэг ухаан нь тэлж байдаг. Оюун санаа нь хөгжиж байдаг. Энэ зүй тогтлыг бид хайхрахгүй явснаас өнөөдрийн нийгэмд үүссэн олон асуудлын уг суурь шалтгаан энэ дээр болоод байгаа шүү.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ орж ирж байгаа 6 хүнийг дэмжиж байгаа.

Яагаад гэвэл шинжээчийн дүгнэлт гараад холбогдох тэр байгууллагуудыг нь төлөөлөөд орж ирж байгаа учраас бид дэмжиж байна.

Ер нь бусад оронд яг энэ Эрүүл мэндийн даатгалын асуудал хамгийн гол улс төр нь байдаг. Манайд энэ байгаа заалаа хар. Хэн сонирхож байна. Ер нь.

Одоо Америк бол “**Medicare**” гээд үндсэн улс төр, үндсэн кампанит ажил нь яг үүнийгээ тойроод л явдаг. Нөгөө Б.Обама хоорондоо маргалддаг юм нь.

Англид “**Эн Эйч Эс**” /The National Health Service (NHS)/ гээд. Нийтийн эрүүл мэндийн сан гээд байгаа юм уу, үйлчилгээ гээд байгаа юм уу. Тэр дээрээ бүх анхаарлаа тавьдаг.

Монголын энэ 3.4 сая хүний Эрүүл мэндийн даатгалын тухай ярьж байгаа юм шүү дээ. Бид. Энэ чуулган дотор хамгийн чухал асуудлын нэг нь.

Өнөөдөр бид ямар царайтай байгаагаа ард түмэн харж байгаа байх. Эрүүл мэндийн даатгал гэдэг бол чи мөнгөө төлөөд байхад эрүүл мэндийн хувьд ар нь түүзээ гэсэн үг шүү дээ.

Нарийн ярих юм бол жилдээ 1.4 их наядын орлого, зарлагатай сан. Энэ бол. 1.4 их наяд. Улсын төсвийн 5 хувь нь. Улсын төсвийн мөнгө биш шүү дээ. Энэ татварын мөнгө биш. Бид улсын төсвийн нэгдсэн төсөв баталдаг. Энэ бол шимтгэл. Ард түмний хөдөлмөрөөрөө олсон мөнгө. Яг цалингаасаа авч өгдөг мөнгө.

Энэ мөнгөний хариуцлага муу байгаа. Өнгөрсөн 30 жил зүгээр л улс төрчид хулгай хийсэн. 6 нөхөр минь улс төрчдийн энэ шунал аймшигтай бэрд царйлсан гарыг тас цохиж өгөөрэй гэж л гуйя. Ганцхан гуйх юм.

Та нар сонгууль дөхөөд ирэхээр “**Эрүүл монгол хүн**”, “**Эрүүл монгол хүүхэд**”, есөн долоон хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхэлнэ шүү.

Тэрийг нь нам цохиж унагаахгүй бол үүний золиос нь юу вэ гэвэл өвчин тусаад, нөгөө хэлж ирдэггүй хийсэж ирдэг өвчин тусаад ирэхээр хашаа байшингаа зардаг, тэгээд л хамаатан садангаа. Одоо энэ олон, энэ UB palace дүүрэн хандивын тоглолт. Энэ өвчин зовлон гээд.

Энэ чинь эрүүл мэндийн даатгал руу улс төрчид хулгай хийсэн байна гэсэн үг. Энэ аймшигтай юмыг таслан зогсоох ёстой. Яагаад гэвэл яагаад хүмүүс даатгал

төлөх дургүй байгаа юм. Төлөөд төлөөд тэртээ тэргүй хашаа байшингаа зарах дээрээ л тулж байна шүү дээ.

Энэ тэнэг байдлыг зогсоогоод өгөөрэй гэж ард түмэн та нарыг төлөөлүүлж оруулж ирлээ. Бид ёсчлон батлах байх гэж би найдаж байна.

Ажилтан, ажил олгогч, жирийн ажилчин, хөдөлмөр хийдэг 749 мянган хүний хөдөлмөр шүү. Малчин 51 мянга. 200-гаад мянган малчин байдаг. 51 мянга. Эрүүл мэндийн даатгалд итгэхгүй байна гэсэн үг. Түүнээс биш эрүүл мэнддээ хайргүй гэсэн үг биш.

Оюутан 14 мянга. Хувиараа хөдөлмөр эрхлэгч 133 мянга. Итгэхгүй байна. Энэ тоо маш бага тоо.

Тэгэхээр Та бүхэн нэгдүгээрт бид энэ даатгалын утга учрыг нь гаргаарай. Та нар эзэд нь шүү. Төр засаг биш шүү. Та нар яг энэ даатгал төлж байгаа хүмүүсийг төлөөлж наана чинь сууж байгаа шүү гэдгээ битгий мартаарай.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн даатгал төлчхөөд би эзэн нь гэж бодож байтал энэ даатгалын мөнгийг дамжуулдаг Эрүүл мэнд даатгалын ерөнхий газар. Би хувь хүн ярьсангүй. 30 жилийн юмыг ярьж байна шүү.

Ерөнхий газар өөрийнхөө мөнгөө өгч байгаа юм шиг эмнэлгүүдэд үйлчлүүлдэг. Эмнэлгүүд тэдэнд долигонодог. Хэн мөнгө өгнө тэр хөгжмөө захиалдаг. Үгүй ээ. Гол эзэн нь даатгал төлөгч.

Эмнэлгийн удирдлагууд даатгал төлсөн хүмүүст бөхөлздөг байх механизмыг бий болгохын тулд маргаан тасалдаг комисс гэж маргаан тасалдаг тэр механизмыг нь бүрдүүлээрэй.

Нөгөө даатгал төлсөн, мөнгө төлсөн хүн маргаан гаргадаг эрх нь хаана байна аа. Байхгүй ээ. Байхгүй. Холоо очиж хуц гэж хэлж байгаа байхгүй юу. Ингэхээр чинь яаж мөнгө төлөх юм бэ. Эд нар.

Дараагийн гуравт нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Сая хэлж байна л даа. Даатгал төлж байгаа хүмүүсийн эзэд нь та нар шүү буюу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, гишүүд нь гэж байгаа.

Тэгээд сая хэлж байна л даа. Улс төрчдийн гарыг тасалж, энэ хулгайг зогсоох ёстой шүү гээд. Гэтэл үе үеийн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Үйлдвэрчний эвлэлийн удирдлагууд, тэгээд л даатгуулагч талаасаа дандаа Үйлдвэрчний эвлэлээс ордог. Даатгагч талаасаа ажил олгогч эздээс гээд л хэдэн хүн эргэлдэж эргэлдэж явдаг. Тэгээд энэ хүмүүс маань үнэхээр тэнд эзэн нь болж манаж чаддаггүй.

Яагаад тийм байдаг шалтгааныг нь өнөөдрийг хүртэл мэдэхгүй. Тэгээд л ирсэн хүмүүс нь би ёстой будаа болгоод өгнө, хянаад өгнө гэсэн. Эргээд бөөн алдагдал дунд өнөөдөр жишээлбэл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл энэ 270 хэд, 300 тэрбум төгрөгөөрөө өглөг, авлагаа авч чадахгүй байж байгаа юм.

Тийм учраас Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн энэ

асуудлыг ер нь дарга аа, ингэж цэгцэлж өөрчлөхгүй бол шинэ хүмүүс томилогдоод л очдог. Байдал хэвээрээ л байна. Үүний шалтгаан нь энэ хүмүүстэй ч биш байгаа. Яагаад.

Бас ингээд судлаад үзээд байхад одоо жишээлбэл энэ Маргаан шийдвэрлэх зөвлөл гээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хажууд байгаа. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хажууд Эрүүл мэндийн магадлалын зөвлөл гээд байгаа. 7 хүний бүрэлдэхүүнтэй. Энэ зөвлөл гомдол гаргаж асуудал дээрээ хэдэн сар ажиллаад асуудал яах гэхээр иргэн үгүй эд нартай би санал нийлэхгүй байна гээд анхан шатын шүүхэд гомдол гаргачихвал энэ хүмүүсийн, тэр зөвлөлийн хийсэн ажил ямар ч хэрэггүй болоод л. Тэгээд шүүхээр бүх юм явдаг. Тэгээд нөгөө маргаан нь эцэстээ шийдвэрлэгддэггүй үлдчихдэг.

Тэгээд энэ хүмүүс тодорхой хэмжээгээр бас урамшууллаа аваад явдаг. Тэр маргаан шийдвэрлэхийг 9 хүн, эрүүл мэндийн тэр магадлалын 7 хүн ингээд тус тусдаа. Нөгөө төрийн хэмнэлтийн хууль мууль энд үйлчлэхгүй шүү дээ. Энэ мэдээж ойлгомжтой.

Тэгэхээр нэгд энэ асуудлыг бид цэгцлэх хэрэгтэй байна.

Хоёрт нь, одоо энэ сайдын багцад орсон мөнгө. Жишээлбэл, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 3, 4-хөн хувиас хэтэрдэггүй байсныг бид энэ 2018 оноос хойш анх удаагаа 7.6 хувьд буюу өнөөдөр 1.4 их наядад хүргэсэн.

Эрүүл мэндийн сайдын багцад орсон энэ мөнгө эрүүл мэндийн даатгалаар дамжаад хэрэгжиж байгаа энэ төсөл, хөтөлбөрүүд яг шударга байна уу,

эзнээ олж байна уу, санхүүжилт нь хаана орж байна гэдэгт хяналт тавих үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл маань энэ үүргээ биелүүлж чаддаггүй. Энэ нь өөрөө юу байна гэхээр нөгөө сайдынхаа доор. Тэр захиран зарцуулж байгаа сайдынхаа удирдлага доор ажиллаж байгаа нь өөрөө бас утгагүй болчхоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хуулиар Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль дээр энэ төсөв захиран зарцуулагч нь өөрөө хяналт тавьдаг Үндэсний зөвлөлийнхөө дарга нь байна гэдэг бол ерөөсөө боломжгүй асуудал байхгүй юу.

Тийм учраас бид үүнийг бас цэгцлэхгүй ер нь цаашаа хэчнээн мундаг хүн томилоод ч асуудал шийдэгдэхгүй. Дараа дараагийн хүн томилоход бид яг 10 жилийн өмнө ярьж байсан юмаа энэ танхимд, Байнгын хороон дээр яриад л байж байна.

Тийм учраас энэ хуулиудаар үүнийг цэгцлэх хэрэгтэй байна.

Одоо яг энд орж ирж байгаа хүмүүс дээр ч гэсэн бид ингээд харахад хөндий биш. Нөгөө тэр тогтолцоондоо байгаад байна шүү дээ.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл дандаа төлөөллөө оруулчихдаг. Би өөрөө Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байхдаа эмийн бизнес, эм, эмнэлгийг дагасан бүлэглэлтэй үнэхээр үзэлцэж эхэлсэн л дээ.

1 долларын эмийг 100 доллароор оруулж ирж зарж байгаа. Орж ирж байгаа эмийн чанар нь үнэхээр стандартын шаардлага хангахгүй. Хууль бус тэр

газруудаас ороод ирчихсэн. Тэгсэн хэрнээ “NOVARTIS”-ын 1 долларыг 100 доллар гээд зарж байдаг.

Өөрөөр хэлбэл 3400 төгрөгийн үнэтэй эмийг 347 мянган төгрөгөөр зарж байдаг юм уу, 30-аас 80 хувийн өндөр өртөгтэй хэрнээ үйлчилгээ муутай чанаргүй эм байна. Эмийн хяналт бол утгаа алдсан байсан. Тэмцэл зарласан. Гэтэл Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл энэ сүлжээнд дандаа бүлэглэлүүд оруулчихсан.

Тийм учраас л бид энэ нээлттэй сонсгол анх удаа Их Хурал явуулдаг болсон. Хяналт ингэж тавиад байгаа юм. Тиймээс ер нь одоо энэ гишүүдийг оруулахдаа Та бүхэн тэнд ажиллахдаа маш их хяналттай байхгүй бол энэ бол даатгуулагчийн мөнгөөр тоглож болохгүй шүү гэдгийг хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Үг хэллээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ Даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд дээр эмийн асуудлыг шалгахаас илүү Хяналт шалгалтын түр хороо байгуулаад өгсөн. Та нар ажлаа хийх хэрэгтэй шүү. Одоо бас. Тэгээд ямар учиртай юм. Энэ таг чиг болцгоочихсон.

Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: 7 нэр дэвшигч байгаа юм байна. Тэгээд энэ олон нэр дэвшигчээс яг тухайлж ч юу асуух вэ?

Би Байнгын хорооны даргаас ганц хоёр зүйл асууя.

Ер нь Монгол Улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдэг зүйл өөрийг нь одоо яг яаж үнэлж, цэгнэдэг юм бэ? Үүнийг тэр эмчлүүлэгчдийн

сэтгэл ханамж ямар байгаа гэдгийг үнэлдэг, цэгнэдэг, дүгнэдэг, эрэмбэлдэг, тийм харьцуулдаг үзүүлэлтүүд байна уу?

Яагаад гэхээр яг Монголд бараг дээд шатлалын эмнэлэг гэдэг, гуравдугаар шатлалын эмнэлэг гэдэг эмчилгээ, үйлчилгээ гэдэг зүйл бараг тэр Солонгост, Хятад, Тайландад байх шиг байна.

Яг нөхцөл байдал дээр эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж гэдэг зүйл өнөөдөр яг ямар байгаа вэ? Үүнийг ер нь харьцуулсан тоон үзүүлэлт, аргачлал энэ дээр яг юу байдаг юм?

Хоёрдугаарт, нь түрүүн бас зарим гишүүдийн үгэнд гарч байна. Энэ эрүүл мэндийн салбарын засаглалын асуудал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар гэж байх шиг байгаа юм. Тэгэнгүүт тэд нар өөрснөө захиалгаа өгдөг, тэд нар өөрсдөө үйлчилгээгээ худалдаж авдаг. Өөрсдөө мөнгөө төлөөд өөрөө өөртөө үйлчилгээгээ үзүүлчихдэг.

Тэгэхээр энд чинь ямарваа нэгэн тэр засаглалын асуудал, үр ашгийн асуудал энэ тогтолцооны чинь цаана байхгүй болчхоод байна. Энэ тогтолцооны цаана засаглалын үр ашгийн асуудал.

Тэгэхээр үүн дээр яг энэ харьяа, хариуцсан Байнгын хороо нь өөрөө үүн дээрээ ямар бодол санал, дүгнэлттэй байдаг юм.

Тэгээд төгсгөлд нь, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл эрүүл мэндийн даатгалтай холбоотой баахан өр авлагын асуудлууд яригддаг.

Капитал банк, Чингис Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк гээд

ийм банкнудаас баахан өр, авлагын асуудлууд яригддаг.

Энэ өр, авлагын асуудал өнөөдөр яг ямар түвшинд байгаа вэ? Эдгээр дээр хариулаач. Байнгын хорооны даргаас нь.

Тэгээд дараа нь тодруулъя.

Г.Занданшатар: Хэн хариулах юм? Байнгын хороон дарга. Пүрэв-Очирын Анужин, Нийгмийн бодлогын байнгын хороон дарга.

П.Анужин: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар асуулт асууж байна. О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн бодлогын байнгын хороо энэ эрүүл мэндийн салбарт хийсэн гүйцэтгэл дээр үндэслэсэн энэ санхүүжилтийн асуудлыг хэрэгжүүлэх тал дээр бид байнгын Эрүүл мэндийнхээ яам, Засгийн газартайгаа хамтарч ажиллаж байгаа.

Та анзаарч байгаа бол долоо хоног бүр Нийгмийн бодлогын байнгын хороон дээр энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн тохиргоо, тохируулга тал дээр бид байнгын сонголт, мэдээллийг авч.

Тэгээд С.Чинзориг сайд энэ шинээр нэвтрүүлсэн гүйцэтгэлийн санхүүжилт тохирохгүй байгаа зарим сумууд дээр яаралтай шинэ тохиргоонуудыг хийж тогтолцоог сайжруулах тал дээр зогсолтгүй ажиллаж байгаа.

Сая Их Хурлын дарга энэ Эмийн түр хороог байгуулсан талаар ярьж байна. Эмийн түр хороог удахгүй Ч.Учрал сайд ажилласан тайлангаа Улсын Их Хуралд тайлагнана.

Ингээд Эмийн түр хороо цаашдаа үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эсэхийг Их Хурал дээр шийдэж явах юм.

Ер нь бид энэ Их Хурлын эрүүл мэндийн салбарт хийсэн нэг том ухарч болохгүй зүйл бол энэ эрүүл мэндийн гүйцэтгэл дээр үндэслэсэн санхүүжилтийн тогтолцоо юм.

Тэгээд үүнийгээ бас зарим гишүүд маань, зарим хүмүүс мэдлэг мэдээлэл дутуугаас энэ ерөөсөө болохгүй, тохирохгүй байгаа юм шиг ийм зүйлүүдийг бас ярьж байгаа.

Тийм учраас бид энэ гүйцэтгэлийг сайжруулах тал дээр илүү анхаарч цаашдаа ажиллах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Энэ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг байгуулах нь маш чухал үүрэгтэй. Та өөрөө мэдэж байгаа. Энэ Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг явуулахын тулд Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлөө бид яаралтай байгуулахгүй бол Үндэсний зөвлөлийн гишүүдийн ихэнхийнх нь ажиллах хугацаа дуусчхаад ингээд явж байгаа гэдгийг танд хэлье.

Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн тайлан жил бүр сонсдог байгаа.

Ирэх долоо хоногт уу, түүний дараагийн долоо хоногт бид Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн ажилласан нэг жилийн тайланг бид Байнгын хороон дээр сонсох ийм чиглэлтэй ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Байнгын хорооны дарга аа, миний асуулт, хариулт бүр ингээд хоёр өөр тийшээ явчихлаа л даа.

Би тодорхой асуулт л асуусан л даа. Энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдэг зүйлээ яаж үнэлж, цэгнэдэг, яаж харьцуулдаг, сайжирч байгаа, муужирч байгаа, тэр эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжаа яаж үнэлж цэгнэдэг юм бэ? Монгол Улсад. Бусад оронд яадаг юм бэ?

Энэ чинь нийтээрээ сэтгэл ханамжгүй байгаад байна. Үүнийг ер нь үнэлдэг, цэгнэдэг, арга аргачлал харьцуулдаг, сайн муу гэж үздэг зүйл байна уу? Өсөж байгаа, буурч байгаа гэж үздэг зүйл байна уу гэж асуусан.

Хоёрдугаарт, нь тэр засаглал. Тэр Эрүүл мэндийн даатгалын зөвлөл гэдэг чинь яамныхаа харьяа. Дахиад энд байгаа зөвлөлөөс гадна Ерөнхий газар. Тэгээд санхүүжүүлэгч, худалдан авагчид чинь хармаанд байгаад байна.

Энэ засаглалын тогтолцоо чинь зөв юм уу, буруу юм уу?

Гуравдугаарт нь, тэр өр, авлага. Банкнууд дээр байсан баахан өр авлага гэсэн. Тэр чинь төлөгдөж байгаа юм уу? Эдгээр дээр ингээд мэдээлэл өгөөч гэсэн. Та шал өөр юм яриад явчихлаа.

Г.Занданшатар: П.Анужин дарга хариулна.

П.Анужин: Таны саяын асуусан энэ зүйл дээр Эрүүл мэндийн даатгалын хууль удахгүй орж ирэх ёстой.

Энэ хуулийн хүрээнд бид энэ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл хэрхэн ажиллах юм, харьяалал нь

юу байх юм, тогтолцоо нь яаж явах юм гэдгийг бид энэ хуулиараа шийдэх ёстой.

Тийм учраас Улсын Их Хурал, Нийгмийн бодлогын байнгын хорооны зүгээс Эрүүл мэндийн яам, Засгийн газарт бид энэ Эрүүл мэндийн даатгалын хуулийг яаралтай оруулж ирэхийг бид байнга шаардаж ажиллаж байгаа.

Намрын чуулган гэхэд оруулж ирнэ гэдгийг бид нарт хэлж байгаа.

Энэ эрүүл мэндийн сэтгэл ханамжийн асуудал гэхээр би танд түрүүн хариулсан. Энэ ер нь иргэндээ хүрч ажилладаг, иргэн бүр сэтгэл ханамжтай байдаг, хүсэж байгаа эрүүл мэндийн үйлчилгээгээ авдаг болохын тулд бид энэ эрүүл мэндийн гүйцэтгэл дээр суурилсан санхүүжилт гэсэн ийм тогтолцооны өөрчлөлтийг хийсэн юм.

Тэгэхээр үүнийгээ бид сайжруулаад, тохируулаад явах шаардлагатай. Тогтолцооныхоо гол бодлогын өөрчлөлтөө хийчихсэн гэдгийг танд хэлье.

Капитрон банк болоод энэ Эрүүл мэндийн даатгалын сангуудтай холбоотой өр авлагын асуудлуудыг. Уучлаарай. Капитал банктай холбоотой асуудлуудыг.../минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь П.Анужин гишүүн ээ. Тэр Хянан шалгалтын түр хороо тайлангаа Улсын Их Хуралд танилцуулаад, цаашаа ажиллах эсэхийг шийднэ гэж байхгүй шүү дээ.

Тайлан танилцуулснаар Хяналт шалгалтын түр хороо татан буугдсанд тооцно гэж байгаа шүү дээ.

Түүнээсээ өмнө тэр Хяналт шалгалтын түр хороо эмийн зөндөө

асуудал байна гэж ярьсан. Тэр сонсгол, энэ тэр хийх, хяналт шалгалтын бусад арга хэрэгслүүд. Тав, зургаан арга хэрэгсэл байгаа. Асуулга, асуултаас авхуулаад.

Ядаж Байнгын хороон дээрээ сонсох ёстой байхгүй юу. Наад зүйлүүдээ.

Тэгээд тайлан тавьчих юм бол Их Хурал дээр шууд татан буугдсанд тооцно.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл гэдэг олон талуудын эрх ашгийн тэнцвэр байх ёстой л доо.

Тэгээд энэ үүднээсээ өнөөдөр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд гишүүнээр нэр дэвшиж орж ирж байгаа 6 төлөөлөл маань энэ эрх ашгийн нэгдлийг хангаж байгаа гэж үзэж байгаа.

Учир нь манай Нийгмийн бодлогын байнгын хороо сонсгол явуулсан байгаа. Шинжээч томилсон. Бүх дүгнэлтүүд гарсан. Тэгээд би энэ үүднээсээ тухайлбал даатгуулагчид, иргэд, ажиллагсдыг төлөөлөөд Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч С.Эрдэнэбат орж ирж байна.

С.Эрдэнэбат дарга арга байхгүй эдгээрийг төлөөлж чадах шулуун шударга, асуудлаа мэддэг ийм хүн юм билээ. Бид бас энэ сонсгол дээр болон шинжээчийн дүгнэлттэй танилцахад тэгж харагдаж байгаа.

Мөн ажил олгогчдыг төлөөлж Ш.Зоригоо орж ирж байна. Ш.Зоригоо

эмчийн хувьд арга байхгүй эрүүл мэндийн салбараа төлөөлөх, ялангуяа эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэх, аль болох иргэдийг гадагш нь явуулахгүй дотооддоо эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх энэ чиглэлд хувь нэмрээ оруулж чадах ийм төлөөлөл юм байна лээ гэж ингэж үзэж байгаа.

Бусдыг нь би бас доор бүрд нь тодорхойлоод яах вэ. Яагаад гэвэл бүгдийг нь дэмжиж байгаа. Шинжээчдийн дүгнэлт болон сонсгол дээр Та бүхэн аль аль нь шаардлага хангасан ийм төлөөлөл байна гэсэн ийм дүгнэлттэй байгааг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, би Та бүхэндээ хэлэх гээд байгаа зүйл бол иргэдийн өмнө тулгамдаад байгаа гол гол асуудлууд дээр манай 6 нэр дэвшигч хэрвээ Улсын Их Хурлаас Та бүхнийг батлах юм бол эдгээр эрх ашгийг шийдвэрлэх чиглэлд ажиллах ёстой гэдгийг сануулах гэсэн юм.

Бид бүгдээрээ харж байгаа. Түрүүн манай С.Ганбаатар гишүүн ч хэлж байна лээ. Хэд хэдэн гишүүн хэллээ.

Өнөөдөр эмчилгээний дэмжлэг, тусламж хүссэн иргэд олноороо байна. Сүхбаатарын талбай дээр хүртэл шаардлага тавиад гарсан ижий, аавуудын төлөөлөл байгаа. Үр хүүхдийнхээ төлөө санаагаа чилээж өөрт байгаа бүхнээ зарж борлуулаад энэ өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ авах гээд, мөнгө төгрөг олох гээд зовж байгаа олон иргэд бий.

Би Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргаар тодорхой хугацаанд ажилласан.

Ингэхэд эрсдэлийн сан бий. Энэ эрсдэлийн санд жилдээ 30 тэрбум төгрөг төлөвлөдөг. Үүнээс одоогоор эх орондоо эмчилж чадахгүй байгаа тэр эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэддээ үзүүлэхэд Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөс зарцуулах ийм боломж бий. Үүн дээр Та бүхнийгээ би тооцоо судалгаатай, сэтгэлтэй хандаасай гэж нэгдүгээрт хүсэж байна.

Хоёрдугаарт, ахмадууд ялангуяа голлон шүүмжилдэг, гомдлоо илэрхийлдэг зүйл бол хөнгөлөлттэй эм байгаа. Хөнгөлөлттэй эмийн тухайд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага энэ хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг баталдаг юм. Үүн дээр суурилж бид мөн бас хөнгөлөлттэй эмийнхээ жагсаалтыг гаргадаг. Үүнийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл баталдаг юм байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хүн амын дунд голлон зонхилж байгаа энэ өвчин рүү чиглэсэн тэдгээр эмийг л бид аль болох өндөр түвшинд өндөр хувиар хөнгөлөх ёстой. Үүн дээр Та бүхэн бодитой хандаарай. Бусад аж ахуйн нэгж гэдэг юм уу, одоо энэ эм ханган нийлүүлэх байгууллагуудын лоббинд автахгүй ажиллах хэрэгтэй. Хэрвээ автах юм бол иргэдийнхээ эрх ашгийг умартсан, тэднийхээ эрүүл мэндэд харш ийм зүйл хийх болно гэдгийг хэлэх гэсэн юм.

Тэгэхээр өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээний энэ хэрэгслийн талаар мөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл шийдвэр гаргадаг юм. Үүнийг бид шийдэж өгч чадах юм бол нөгөө иргэдийн гадагшаа явах, гадагшаа мөнгө төгрөг урсах. Үүнийг хааж чадах ийм боломжтой. Ингэж байж.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал уу? Тийм ээ. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн 1 минут тодруулж асууя.

Д.Сарангэрэл: Тийм учраас энэ иргэдийнхээ зайлшгүй шаардлагатай авах гээд байгаа тэр эмнэлгийн тусламж, үйлчилгээг эх орондоо авдаг болоход энэ өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийн асуудлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл зөв зүйтэй шударгаар шийдэж өгөх юм бол энэ гадагшаа урсах урсгалыг бууруулж чадна.

Улмаар иргэдийнхээ эрүүл мэнд, амь насыг хамгаалахад хувь нэмрээ оруулж чадах юм байгаа юм.

Энэ чиглэлд би Та бүхнийг зүтгэлтэй ажиллаасай гэж хүсэж байна. Ингээд би 6 нэр дэвшигчийгээ шинжээчдийн дүгнэлт болон Та бүхний сонсгол, мэдээллийг сонссоны үндсэн дээр зургууланг нь бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа эцэст нь илэрхийлж байна. Баярлалаа. Дарга аа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? С.Эрдэнэбат дарга. 85. Ш.Зоригоо дарга.

С.Эрдэнэбат: Эмийн хөнгөлөлттэй үнэтэй холбоотой асуудал манай Үйлдвэрчний эвлэл дээр маш их ярьдаг.

Энэ талаар бид тодорхой судалгаатай байгаа.

Ялангуяа сая гүйцэтгэлтэй холбоотой, цахимжилттай холбоотой, зарим үйл ажиллагааны давхцал хамаараад байдаг юм билээ. Тухайлбал, бараг насаараа зүрхний цус шингэлэх эмийг авах ёстой, даатгалын хөнгөлөлтөөр авах ёстой эмийг сар болгон очиж хуруугаа хийж тэгээд аптек дээрээ очиж хийдэг ийм давхардсан, хий

дэмий хүмүүсийг чирэгдүүлсэн ийм асуудлууд байна.

Зарим эмүүд хоорондоо маш их үнийн зөрүүтэй. Нэг нь 7 мянган төгрөг гэж байхад нөгөөдөх нь 37 мянган төгрөг.

Тэгэхээр үүнийг нөгөө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага маань нэг эм гэдэг байдлаар асар ялгаатай байдлаар үйлчилгээ үзүүлж байгаа.

Мэдээж энэ үнийн чанараас авхуулаад цаана нь хүмүүсийн эрүүл мэндийн асуудал байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор энэ өртөг, бусад эм болон саяын түрүүний хэлдэг гадаад руу явахаас өөр аргагүй байдалтай маш олон эмч, эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, баг, үйлчилгээнээс бэлтгэл байхгүйгээс болоод хүмүүс маш их зардал гардаг. Энэ нь өөрөө эргээд манай валютын нөөц, мөн тухайн Эрүүл мэндийн даатгалын эрсдэлд өөрөө бүрэн дүүрэн өртдөг ийм асуудлыг бид бүхэн энэ өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээг бий болгоход энэ эмнэлгүүд зарим талаараа нэгдэж ажиллах хэрэгтэй байгаад байгаа юм. Тус тусдаа тоо эмнэлгүүд гэдэг байдлаас илүү давуу давуу талаа нийлээд энэ бодлогыг нь дэмжиж өгөх, хамтраад энэ Монголчуудаа эмчлэх тал дээр нь, анхаарах тал дээр нь бодлогын асуудлууд байгаа гэдгийг хэлмээр байна. Тийм. Товчхон хариулчихъя.

Г.Занданшатар: 83.

Ш.Зоригоо: Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулья.

Г.Занданшатар: Протоколд үлдэх учраас нэрээ хэлээд. Протоколд бичигдэж байгаа.

Ш.Зоригоо: Уучлаарай. Нэр дэвшигч Ш.Зоригоо.

Эрүүл мэндийн даатгалын хууль 2016 оноос хойш хэрэгжиж эхлээд анагаах ухаанд үсрэлт авчирсан.

Юу гэхээр жишээлбэл Монгол Улсад эмчилж болдоггүй 33 өвчин байсныг 26 болгосон. Тэгээд энэ нь эрүүл мэндийн даатгалаас санхүүжилтээ сайн хийгээд ирэхээр тэнд хэрэглэдэг хэрэгсэл, эм, тэрийгээ дагаад орлогоороо мэргэжилтнүүдийн сургалт, энэ бүхэн бүрэлдэн тогтоод ингээд үсрэлт авчирч өгсөн.

Одоо байгаа 26 өвчин дээр нэг ийм санал байдаг. Юу гэхээр тэнд Монголд эмчилж болох боломжтой эмнэлгүүдийн санхүүжилтийн тал дээр нь даатгалын талаас нь буюу саяын хэлсэн эрсдэлийн сангаас санхүүжилт нэмээд өгчихвөл үүнийг Монгол Улсад эмчлэх нөхцөлийг нь бүрдүүлнэ гэж харж байгаа.

Жишээлбэл, Сонгдо эмнэлэг зүрхний чиглэлийн 5 өвчнийг Монголд эмчлэх зорилт тавиад ажиллаж байгаа. Өнгөрсөн 2022 онд энэ 5 өвчний 2-ынх нь эхний мэс заслыг хийчихсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр Эрүүл мэндийн даатгалаас буюу эрсдэлийн сангаас нэмэлт ахиухан санхүүжилтүүдийг тухайн тусламжийг үзүүлдэг эмнэлгүүдэд ахиухан өгч чадвал энэ маань ойрын хугацаанд Монгол Улсад эмчлэгдэх боломжтой.

Нөгөө талаас Монголд эмчлэх боломжгүй 26 өвчин дотор дэлхий нийтэд эмчлэх боломжгүй ч өвчнүүд бас байгаа.

Тэгэхээр үүнийг үе шаттайгаар цааш нь яаж хөгжүүлэх вэ гэдэг

төлөвлөлт хийх байх аа гэж харж байгаа.
Баярлалаа.

Г.Занданшатар: Чинбатын
Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Эрүүл мэндийн
салбарын аливаа асуудал манай улсын
хамгийн чухал асуудал байгаа.

Бид эрүүл биетэй, боловсролтой
иргэдтэй байж дараа дараагийн
асуудлуудыг ярьдаг.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын
тухай хуулиар даатгуулагч нь эрүүл
мэндийн чанартай, аюулгүй, тэгш,
хүртээмжтэй тусламж, үйлчилгээ авах
эрхтэй.

Тэрийг хангахын тулд одоо энэ
Эрүүл мэндийн даатгалын үндэсний
зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын
ерөнхий газар гээд энэ хүмүүс ингээд
ажиллах ёстой байгаа юм.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын
үндэсний зөвлөлд бас мэргэжлийн
хүмүүс, мөн Үйлдвэрчний эвлэлийн
холбооны ерөнхийлөгчөөс авхуулаад
ингээд чухал хүмүүс орж ирж байгаад би
баяртай байна.

Тэгээд ер нь манай энэ
хөдөлмөрчид бүгд албан журмаар эрүүл
мэндийн даатгал төлдөг. Түүнийхээ
эргээд чанартай, хүртээмжтэй, аюулгүй
ийм үйлчилгээг авч бүгдээрээ чадаж
байна уу гэвэл бас асуудалтай байгаа.

Мэдээж энэ салбарын хүрээнд
өнгөрсөн хугацаанд КОВИД гээд бүгд л
шат шатдаа эрвийх дэрвийхээрээ
ажилласан. Гэхдээ маш олон асуудал
байна.

Нэгдүгээрт, эмийн чанарын
асуудал. Хөнгөлөлттэй эм гээд манай
хөгшчүүл авч байна. Даралтын эм ч гэдэг
юм уу. Үүнийг уугаад байхаар эргээд
ходоод өвдөөд байна. Ходоод гашуу
оргиод байна гээд. Эргээд нэг эмийг
уугаад нөгөөдөх нь нөгөө эрүүл мэндийн
өөр асуудал үүсгээд байдаг ийм юм
байна.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн маань
хяналт тавьж ажиллаасай гэж хүсэж
байна.

Хоёрдугаарт, эмийн үнэ өртөг
өндөр байна гэж байгаа юм. Өндөр үнээр
шахаад байна гэж байгаа юм.
Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй
иргэдийн уналт таталтын эсрэг эм.

Бид өмнө нь Солонгосоос өөрсдөө
захиалж авдаг байхад 100 мянган төгрөг
орчмоор авдаг байсан. Одоо үүнийг
Эрүүл мэндийн даатгалын сангаас 18
хүртэлх насныхныг 100 хувь төлөөд
өгдөг. Гэхдээ даатгалын сангаас
шилжүүлж байгаа үнэлгээ нь 500 мянган
төгрөг байна.

Тэгэхээр дунд нь байгаа компани
үнэтэйгээр шахаад байна гэдэг асуудлыг
энэ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
холбооноос өөрсдөө надад ирж эцэг,
эхүүд нь хэлж байна.

Тэгэхээр энэ дээр бид хяналт
тавилаар байна. Эрүүл мэндээр, хүний
амь насаар бизнес хиймээргүй байна.

Энэ дээр Та бүхэн маань чин
сэтгэлээсээ ажиллана гэж бодож байна.

Дараа нь, түрүүн бас гишүүд ярьж
байна. Өвчнөөс урьдчилан сэргийлэх
асуудал гээд.

Мэдээж бүх нийтийн биеийн тамир чухал. Үүнээс гадна хүнсний асуудал чухал байгаа шүү. Одоо жишээлбэл, өнөөдөр миний бие нэр бүхий гишүүдтэй хамтраад Органик бүтээгдэхүүний тухай хууль өргөн барьж байгаа.

Бид энэ хүнсний чанар, пестицидгүй, янз бүрийн хортой химийн бордоогүй ийм эрүүл хүнс идэж байж шаардлагатай шим тэжээлээ аюулгүйгээр авна гэсэн үг.

Дараагийн асуудал нь, энэ дотоод орчны агаарын чанарын асуудал. Үүнийг Их Хурлаар саяхан түрүү долоо хоног хэлэлцсэн. Байнгын хороогоор бас хэд хэдэн удаа хэлэлцсэн. Бидний хэрэглэж байгаа энэ барилгын материал, энэ тавилгад хэрэглэж байгаа цавуу бүгдээрээ формалдигид, бензол, целол гээд урагт нөлөөлдөг. Тийм ээ. Хорт хавдар үүсгэдэг ийм бодистой байгаа.

Тэгэхээр зөвхөн энэ Эрүүл мэндийн даатгалын мөнгийг яах вэ, гүйцэтгэлээр санхүүжилтийг нь хэрхэн зөв хийх вэ гэхээс гадна урьдчилан сэргийлэх. Тэр дундаа энэ бидний дотоод орчны агаарын чанар болон хүнсний асуудлыг Та бүхэн маань бас энд байнга анхаарч чих тавьж холбогдох газруудтай нь хамтарч ажиллаасай гэж хүсэж байна.

Тэгээд Та бүхэнд томилогдвол амжилт хүсье.

Г.Занданшатар: Үг хэллээ. Батсүхийн Саранчимэг гишүүн.

Б.Саранчимэг: Баярлалаа.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг томилох асуудлаар Байнгын хороон дээр хэлэлцээд тодорхой асуулт

асуусан. Тэгээд тэрнээс өөр асуулт асууя гэж бодож байна.

2020 онд Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон энэ холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, 2021 онд оноос эхэлж эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эхлүүлсэн.

Тэгэхээр энэ ажлын үр дүнд Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийг хэрэгжүүлж эхэлсэн байгаа.

Тэгээд эмч, эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудад гүйцэтгэлд үндэслэн цалин, урамшууллыг олгох энэ ажил үе шаттайгаар үргэлжилж байгаа.

Тэгэхээр цаашид энэ бодлогыг илүү боловсронгуй болгоход одоо яаж ажиллавал шаардлагатай гэж үзэж байна? Та бүхний саналыг сонсмоор байна?

Дараагийн асуулт бол цөөн хүн амтай сумуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл хангалтгүйн улмаас хүндрэлд орж байгаа. Мөн сумдын эрүүл мэндийн төвийн цалин салбарын дунджаас доогуур байгаа.

Тэгэхээр эдгээр тулгамдаж байгаа асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх бодолтой байна вэ?

Одоо эрүүл мэндийн анхан шатын үйлчилгээг өрхийн эмнэлгүүд өгдөг. Тэд нар гэрээгээр энэ санхүүжилтээ авдаг.

Тэгэхээр энэ ажлын гүйцэтгэлийн тооцол, аргачлал дутагдалтай. Мөн энэ цахим системийн алдаа зэргээс шалтгаалаад санхүүжилтээ авч чадахгүй тал дээр өрхийн эмнэлгүүд маш их гомдол ирүүлж байгаа.

Тэгэхээр өрхийн эмнэлгүүдээс ирж байгаа энэ гомдлыг арилгах тал дээр та бүгд бодсон уу? Энэ тал дээр хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Ш.Зоригоо. 83. Хариулъя.

Ш.Зоригоо: Нэр дэвшигч Ш.Зоригоо. Б.Саранчимэг гишүүний асуултад хариулъя.

Цахим боловсронгуй болгох гээд. Энэ дээр үнэхээр сэтгэл эмзэглэж явдаг.

2000 оноос хойш эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн цахим системийг боловсруулах талаар маш их мөнгө зарцуулсан. Сая саяар нь доллароо зарцуулсан.

Одоо эрүүл мэндийн даатгалд гэхэд 10-аад компани дуртай эмнэлэг дээрээ очиж программаа суулгаад тэгээд тэр нь даатгалын газартайгаа нийлж ажиллаж өгөхгүй, ингээд даатгал зогсоод байгаа ийм үйлдлүүд байгаа.

Тэгэхээр энэ дээр ганцхан санал байгаа. Юу гэхээр манай улс юм уу, Засгийн газар Макрософттой гэрээ хийгээд л тэгээд энэ дээр бид захиалгаа өгөөд даатгал нь, статистик нь, эрүүл мэндийн мэдээлэл нь, хяналт нь, санхүүжилт нь гээд бүх юмнууд эд нартай ингээд нийлээд захиалгаа өгөөд хийлгэчихвэл илүү их хялбар болох болов уу? Үүнийгээ улсын эмнэлэгт үнэгүй суулгаад, хувийн эмнэлгүүдэд нь зараад ингээд тухайн жил болгон сервисээ аваад явбал болчих болов уу гэж хардаг.

Сумдын эмч нарын цалингийн асуудлыг яг үнэндээ бид шийдэх ёстой үгүйг хэлж мэдэхгүй байна.

Зүгээр энэ даатгалын тогтолцооны цалинтай уялдуулах манай эмнэлгийн жишээ бий.

Бид орлогоосоо цалинждаг. Юу гэхээр өөрийн бичсэн эм, үзсэн үзлэг, эмчилсэн эмчилгээ, энэ бүх нийт зардлаас тодорхой хувь эмч буюу сувилагч, бусад ажилчдадаа очиж ингэж цалинждаг.

Тэгэхээр энэ байгууллагуудыг удирдаж байгаа менежерүүдэд энэхүү хувийг тооцож өгөх эрх нь нээгдэхэд л даатгалтайгаа уялдана гэж хардаг.

Үүнийгээ дагаад цалин нь харьцангуй даатгалтай уялдаад нэмэгдээд ирэхээр аяндаа сум, өрхийн эмнэлгүүдэд эмч, мэргэжилтнүүд маань ажиллах нөхцөл нь бүрдэх байх гэж хардаг. Баярлалаа.

Г.Занданшатар: Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд хүний хөгжлийн гол тулгуур хүчин зүйл бол эрүүл мэндийн асуудал.

Тийм учраас энэ эрүүл мэндийн асуудал дээр онцгой анхаарч, маш зөв, цэгцтэй шийдлүүд гарч байх ёстой гэж хардаг. Хууль эрх зүйн орчин ч гэсэн тийм төгс байх ёстой гэж ойлгож харж байгаа.

Тэгэхдээ манай Монгол Улсад эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлийн санхүүжилт орж эхэлж ажилласнаас хойших хугацаа төдийлөн удаагүй ч гэсэн тодорхой үр дүнд хүрч байгаа. Тэгэхдээ сайны хажуугаар саар гэгчээр олон дутагдалтай асуудлууд байна.

Тэгэхээр өнөөдөр энэ Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлд нэр дэвшигч нар хэрвээ Та бүхэнд томилогдвол дараах хэдэн зүйл дээр анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаагаа илэрхийлье.

Гүйцэтгэлийн санхүүжилтэд орж ажилласнаараа хоёр дахь, гурав дахь шатлалын эмнэлгүүд харьцангуй эдийн засгийн чөлөөт үр дүнд хүрч ажилчдынхаа цалинг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг нь хангах, шаардлагатай байгаа тоног төхөөрөмжүүдээр өөрсдийгөө хангах тийм боломж бололцоо үүснэ гэж харж байгаа. Бас үүсэж ч байгаа.

Тэгэхдээ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай холбоотой асуудлууд бас ужгирч энэ гүйцэтгэлийн санхүүжилт явуулахад нэлээн хүндрэл учраад байгаа зүйл байна.

Монгол Улсын Засгийн газар, Их Хурлаас төвлөрлийг сааруулах чиглэлээр тодорхой алхмууд хийж ажиллаж байгаа.

Гэтэл энэ агентлаг нь өөрөө энэ төвлөрлийг сааруулах бодлогын эсрэг яваад байгаа юм шиг санагдаад байгаа юм л даа. Зарим үйл ажиллагаагаараа шүү.

Хоёр дахь, гурав дахь шатлалын эмнэлгүүд буюу орон нутагт байгаа эмнэлгүүд эмчлэх боломжтой хүний нөөц болон тоног төхөөрөмжийн шаардлага хангачихсан байхад тэр эмчлэх, оношлох гүйцэтгэлийг гүйцэтгэлийн гэрээндээ тусгаж өгөхгүйгээр зөвхөн Улаанбаатар хотод эмчлүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь өөрөө ашиг сонирхлын зөрчил байгаа гэж харахаас өөр аргагүй болж байгаа зүйл шүү.

Иргэддээ бас тэгж хүндрэл учруулмааргүй байна шүү дээ. Цаг

хугацааны хувьд ч гэсэн, эрсдэлийн хувьд ч гэсэн ямар хүндрэл гарах вэ. Дээрээс нь санхүүгийн ч гэсэн томоохон дарамтад орно шүү дээ.

Тийм учраас тэр орон нутагт илүүтэй оношлох, эмчлэх бололцоог хангахын төлөө тэмүүлдэг байх ёстой гэж харж байгаа.

Тэгэхээр энэ дээр манай шинээр томилогдох хүмүүс маань анхаарч ажиллахгүй бол Улаанбаатар луу чиглэсэн урсгал дийлдэхээ байх нь.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын энэ авч байгаа арга хэмжээний цаана ашиг сонирхлын тодорхой зөрчил байна гэж харж байгаа шүү. Төрийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг боомилж байна гэж харж байгаа шүү гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь, эрүүл мэндийн даатгалд 1.4 их наяд төгрөг баталж санхүүжүүлж байгаа. Гэсэн хэдий ч гэсэн бас даатгуулагчдын эрх ашгийг ноцтойгоор зөрчигдөж байгаа зүйлүүд маш ихээр гарч байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг шийдэх тал дээр. Саяын миний жишээ хэлсэнчлэн шийдэх асуудлыг анхаарах хэрэгтэй.

Гүйцэтгэлийн санхүүжилт гэхээд тухайлбал өрх гэр, эрүүл мэндийн төвүүдийн анхан шатын эмнэлгүүдийн гүйцэтгэлийн санхүүжилтийг 4 төрлийн тусламж, үйлчилгээг бүрэн гүйцэтгэлийн санхүүжилтэд оруулчхаад байхад хязгаарлалт тавьж олгодог асуудлууд гарч байна. Энэ бол өөрөө энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн эсрэг бас зохион байгуулж байгаа арга хэмжээ гэж харж байгаа шүү.

Тэгэхээр энэ дээр өөрчлөлт гарах тал дээр анхаарах хэрэгтэй байна.

Нийгмийн эрүүл мэнд манай монголчуудын хамгийн чухал асуудал. Эрүүл мэндийн салбарт хамгийн чухал асуудал. Энэ асуудал дээр онцгой анхаарч энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг яаралтай оруулж ирж батал.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэлчихлээ дээ. Тийм ээ. Нэмэлт минут байхгүй.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дараа нь санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Асуулт хариултын цаг дууслаа.

Ж.Чинбүрэн: Бид маш чухал томилгоог энд батлах гэж байна.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Монгол 3.4 сая иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэр сайн байлгах вэ гэдгийг шийддэг ийм чухал сан, энэ байгууллага.

Тэгэхээр энэ байгууллагын үндсэн гол суурь бодлогыг барьж явах улсуудыг бид томилж, сонгох гэж байна.

Эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийн хүрээнд бид гүйцэтгэл гэж яриад байгаа. Яг үнэн хэрэгтээ сайн гүйцэтгэсний төлөө худалдаж авч байгаа тогтолцоо шүү дээ. Үр дүнгийн.

Тэгэхээр үр дүнтэй гүйцэтгэлийг худалдаж авч байгаа ийм тогтолцоо руу бид шилжсэн. Энэ тогтолцоо руу шилждэг нь ер нь бид хамгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг илүү сайн хөгжүүлэх, иргэддээ эмнэлэг нь тусламж, үйлчилгээг цаг алдахгүй хүргэдэг. Нөгөө талаасаа иргэд нь ядуурдаггүй байх энэ

чухал тогтолцоог бид баталж хэрэгжүүлж эхэлсэн.

Үр дүнгээ өгөөд эхэлсэн. Сайн байгаа. Гэхдээ дутагдалтай талууд бас байгаа.

Ер нь даатгалын сан өөрөө маш тийм маневр хурдан байхгүй өвчин гэдэг бид КОВИД цар тахлын үед харлаа шүү дээ. Ямар ноцтой аюултай байдаг вэ. Тэр болгон дээр шуурхай. Дэлхий дээр сайн байгаа эмчилгээг Монгол иргэд санхүүгийн дарамтгүй авах энэ боломжийг бүрдүүлэх зорьсон ийм даатгал.

Энэ хүрээнд хорт хавдрын эмчилгээ хамтын төлбөргүй болсон байгаа. Эрхтэн шилжүүлэн суулгахад иргэн ядуурдаггүй, хамтын төлбөргүй ийм болсон. Энэ сайн талууд байгаа.

Тийм учраас энэ гүйцэтгэлийн тогтолцоо гэдэг маань үндсэндээ Бүгд Найрамдах Солонгос Улсын эрүүл мэндийн салбартай нэлээн дөхөж очиж байгаа ийм хэмжээнд хүрэх зорилго тавьж ажиллаж байгаа гэж харж байгаа.

Түрүүн Д.Сарангэрэл гишүүн бас их чухал зүйл хэллээ.

Эрсдэлийн даатгалаас бид Монголдоо эмчилж чадахгүй гээд зарлаад байгаа юм бол ядаж гүйцэтгэлийг худалдаж авдаг тогтолцоогоо хэрэгжүүлье. Чадахгүй гэж зарлачхаад тэгээд эмчлүүлээд ирэхээр нь төлбөрийг нь тусалж чаддаггүй. Ердөө 5-хан хувийг нь төлдөг ийм тогтолцоо байна шүү дээ.

Тэгвэл үүнийг бид хуульд “стратегийн худалдан авалт” гэдэг үг оруулчихсан байгаа.

Хэрвээ эмчилж чадахгүй байгаа бол Монголдоо эмчилдэг болгохын төлөө даатгалын сангаар дамжуулан гүйцэтгэлийг худалдан авч тухайн эмнэлгүүд хийх сонирхолтой болж хийдэг болгох энэ тогтолцоо хуульдаа байгаа шүү.

Та бүхэн энэ дээр бас анхаарч ажиллана биз.

Харин Эрүүл мэндийн яаманд би зориуд хэлэх гээд байгаа зүйл бол С.Чинзориг сайдад хэлэх зүйл байна.

Юу байна вэ гэхээр энэ Эмнэлгийн тусламжийн тухай хууль 2017 онд баталсан. Одоо хүртэл хэрэгжихгүй байна. Эмнэлгүүд төлөөлөн удирдах зөвлөлтэй болоод хагас автономит бие даасан байдлаар илүү сайн ажиллах тэр боломжийг нь өгөх энэ үйл ажиллагаа ерөөсөө явахгүй гагцхисан байгаа. Энэ дээр анхаарна биз ээ.

Бас нэг хэлэх гэсэн зүйл бол ер нь зарцуулж байгаа мөнгө болгон өөрөө өгөөжтэй байх ёстой. Энэ утгаараа бид эрт илрүүлэх үзлэгт 67 тэрбум төгрөг тавьсан хэдий ч үр дүн тийм сайн хангалттай биш байна. Нэг л баахан тоо хөөцөлдсөн. 900 гаруй мянган хүнийг үзсэн л гэдэг тоо болохоос яг үхэлд хүргэж байгаа өвчнөөс урьдчилан сэргийлж чадсан уу гэдэг нь одоогоор тийм тооцоолол, дүгнэлт гарахгүй байна.

Тийм учраас бид илүү хүний амь насанд аюултай өвчинг илүү эрт оношлох энэ боломжоор нь хангах нь манай энэ эрт илрүүлгийн зорилго нь байх ёстой. Энэ дээр анхаарах байх гэж бодож байна.

Даатгалын үндэсний зөвлөл Та бүхэн техникийн хороог би бас Байнгын хороон дээр байнга яриад байгаа.

Техникийн хороог яаралтай байгуулж ажиллаарай. Ингэснээрээ бид энэ шинэ шинэ даатгалд хамрагдах шаардлагатай эмчилгээний аргуудаа оруулдаг, зарим ороогүй зүйлүүдээ нэмж оруулах зүйлүүд гээд их олон ажлууд байгаа шүү.

Тэгээд Та бүхэнд бүгдэд нь амжилт хүсье.

Г.Занданшатар: Одоо санал хураалттай учраас асуулт хариултын цаг дууслаа.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо асуулт хариултын цаг дууссан учраас гишүүд чуулганы танхимд цуглая.

Энэ хооронд зочид танилцуулья.

Дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхэд “Манлайлагч эмэгтэйчүүдийн оролцоо” олон улсын хуралд оролцож буй төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт олон улсын төлөөлөгчид Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс, Монголын парламентын өмнөөс халуун мэндчилгээ дэвшүүлж, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Энэ ташрамд манай Б.Саранчимэг гишүүн маань 186 орны парламентыг нэгтгэсэн Олон улсын парламентын холбоонд идэвхтэй ажилладаг 10 эмэгтэйг онцлон нэрлэсэн дотор Монгол Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын

хорооны дарга Б.Саранчимэгийг нэрлэсэн байна.

Б.Саранчимэг гишүүн маань Олон улсын парламентын холбооны Ардчилал, хүний эрхийн хорооны дэд ерөнхийлөгчөөр сонгодон ажиллаж байгаа.

Тэгээд бас нэг мэндчилгээ дэвшүүлье. Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн 04 дүгээр сарын 19-нд Содномдаржаагийн Жигжидсүрэн, Гонгорын Надмид нарын дундах хүү болон эхээс мэндэлжээ.

Ээж Гонгорын Надмид нь болон Чинбүрэн гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэж Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон бас эрүүл мэндийн салбарын төлөөлөл болсон Танд болон таны гэр бүлд эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Санал хураалтын өмнө гишүүд олон санал хэллээ.

Даатгуулагчийг төлөөлж Та бүхэн маань Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллагад сонгогдох гэж байна.

Онцгой анхааруулж хэлэх зүйл байна.

Ерөөсөө энэ сангуудад нүүрлэсэн хулгай бол энэ хөндлөнгийн хяналт, хараа шалгалт муудсанаас болсон зүйл. Нийгмийн даатгалын сан ч ялгаагүй, Эрүүл мэндийн даатгалын сан ч.

Энэ өсөж үржээд арвижиж хүн ардын нийгмийн эрүүл мэндийн

үйлчилгээнд зарцуулагдах, зориулагдах ёстой мөнгө банканд хууль бусаар байршдаг, мөнгөний ханшийн уналтаар элэгдэл хорогдолд орж байхад үүнийг өсгөн үржүүлдэггүй ийм хулгай бол сангуудад нүүрлэснийг ард түмэн харж жигшин зэвүүцэж байгаа юм.

Энэ бол төрийн мөнгө биш учраас Та бүхнийг томилж байгаа юм. Энэ бол татвар төлөгчдийн мөнгөөр. Шимтгэл төлбөр чинь татварт тооцогддог. Татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ гэж байгаа юм.

Тэгээд нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр бол даатгуулагч, ажил олгогчид төлж байгаа төлбөр.

Үүнийг төлөөлж хяналт тавих гэж байгаа. Энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг. Та нар нэг их эрүүл мэндийн асуудал асуугаад байх юм. Тэрийг хариуцна гэсэн үг биш. Ажилчид өөрсдөө Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хүн ард төлж байгаа юм. Тэрний мөнгөнд хяналт тавих гэж байгаа юм.

Ийм учраас монгол хүний үхлийн шалтгаан болоод байгаа тэр “Элэг бүтэн Монгол” зэрэг энэ хорт хавдраас урьдчилан сэргийлэх.

Нэг номерын үхлийн шалтгаан зүрхний өвчин, хорт хавдар байна. Хорт хавдар дотроо элэгний хорт хавдар, ходоодны хорт хавдар зонхилж байна.

Энэ нийгмийн эрүүл мэндийн төлөө Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө зарцуулагдах ёстой. Гэтэл энэ хөрөнгө зөв зүйтэй зарцуулагдаж байна уу. Хэсэг бусаг хүний гараар ороод дуусаж байна уу.

Сая тэр эмийн чанар, хяналтын асуудлаар Хяналт шалгалтын түр хороо байгуулсан. Энэ хороо ажлаа хийх хэрэгтэй байна. Эцсийн эцэст эм гэдэг маань хүн ардын эрүүл мэндийн хамгийн чухал асуудал.

Эмийн чанар үнийн асуудал. Энэ асуудалд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл онцгой анхаарал хяналт тавих ёстой. Яагаад гэвэл даатгалын сангаас хямдруулж байгаа, төлбөр төлж байгаа олон эм бий.

Ийм учраас энэ Эрүүл мэндийн даатгалын санд байгаа зарцуулалт, төсөв хөрөнгийг Даатгуулагчдын үндэсний зөвлөл, энэ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл хянаж баталдаг юм шүү дээ.

Тийм учраас та нар цалин урамшуулал авч байгаа шүү дээ. Зөвхөн төр сайд биш. Хуулиараа урамшуулалтай. Урамшуулал чинь урамшуулал гэсэн үг.

Тийм учраас ингээд нэг төлөөлөл болоод суудаг байж таарахгүй. Үе үеийн энэ даатгуулагчдын, ажил олгогчдын төлөөлөл болж. Үйлдвэрчний эвлэл гэдэг маань нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг төлөөлж байгаа. Ажил олгогчид Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд тэр төлөөлж тодорхой хувийг төлж байгаа компани, аж ахуйн нэгжүүдийг төлөөлж байгаа.

Үүний өмнөөс нийгмийн эрүүл мэндийн төлөө энэ мөнгө зөв зарцуулагдаж байгаад хяналт тавьж байх ёстой байгууллага.

Энэ чиг үүргээ л сайн хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй.

Ийм учраас энэ чиглэлээрээ анх онцгой анхаарч ажиллахыг хүсье.

Тэгээд тэр “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр байна. Зогсчихсон. Эрүүл мэндийн яам сайн анхаарах хэрэгтэй.

Нийгмийн эрүүл мэндийн асуудлууд байна. Онцгой анхаарах хэрэгтэй.

Эмийн чанар хяналтын асуудал байна. Гишүүд олон ярьсан учраас давтаж анхааруулж хэлэх гэж байгаа юм.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулна.

Эхлээд Сүхбаатарын Эрдэнэбатыг даатгуулагчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураална. Нууц санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Таны саналаар нууц болгочихсон юм байна лээ. Хуульд тэгээд заачихсан байна.

50 гишүүн оролцож, 30 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баасангийн Алтанхуягийг даатгуулагчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

31 гишүүн дэмжиж, 62.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түдэвийн Баясгаланг даатгуулагчийг төлөөлсөн Эрүүл

мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжээгүй Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Байнгын хорооны дэмжээгүй саналыг гишүүд дэмжээгүй учраас.

Дэмжээгүйг дэмжсэнгүй.

Тийм учраас энэ дэмжигдэж байна гэсэн үг.

Шагдарын Зоригоог ажил олгогчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжээгүй Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Байнгын хорооны саналаа дэмжих үү, нэр дэвшигчийг дэмжих үү гэсэн санал хураалт явуулж байна.

Тэгэхээр та өөрөө дэмжээгүйг дэмжихгүй санал өгөхөөр чинь энэ чинь дэмжигдчихэж байгаа байхгүй юу. Энэ дээр ил гарч байна. Тэгээд дэмжигдчихлээ л дээ.

Шагдарын Зоригоо дэмжигдлээ.

Жамсрангийн Гэрэлмааг ажил олгогчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

66.0 хувийн саналаар санал дэмжигдэж, Ж.Гэрэлмаа дэмжигдлээ.

Нэмэхээгийн Одонгуаг ажил олгогчийг төлөөлсөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн

гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

35 гишүүн дэмжиж, 70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль нь ийм учраас тэгээд нууцаар л санал хурааж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо. /алх цохив/

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Эрүүл мэндийн мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14^{1.2} 14^{1.3} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг доор дурдсанаар баталсугай.

Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр:

- 1/Сангийн сайд
- 2/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
- 3/Эрүүл мэндийн сайд

Даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр:

1/Б.Алтанхуяг -Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

2/Т.Баясгалан -Шинжлэх Ухааны Академийн харьяа Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

3/С.Эрдэнэбат -Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч

Ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр:

1/Ж.Гэрэлмаа -Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн

2/Ш.Зоригоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны Ерөнхийлөгч.

3/Н.Одонгуа -Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.18-ны өдөр ирүүлсэн/

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Ингээд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдсон Та бүхэнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг авлигал, ашиг сонирхлоос ангид байж хүн ардын эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахын төлөө чин шударгаар ажиллахыг хүсэн ерөөе.

Та бүхний ажилд амжилт хүсье. /алга ташив/

Ашиг сонирхлын зөрчилтэй асуудалд угаасаа өөрсдөө оролцох ёсгүй л дээ. Тийм. Авлигатай тэмцэх газраас урьдчилсан мэдүүлгүүдээ авсан байх гэж бодож байна.

С.Эрдэнэбат Ерөнхийлөгч уулзаарай.

Дараагийн асуудал орно.

Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшинд танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай саналыг үндэслэн Эдийн засгийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хамтран боловсруулсан “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3 дахь хэсгийг үндэслэн уг асуудлыг дахин хэлэлцэх горимын саналыг гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж холбогдох Байнгын хороонд буцаасан болно.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар тус тогтоолын төслийг дахин хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр уг тогтоолын төсөлд Тавантолгой цахилгаан станцын болон хил холболт хийгдээгүй төмөр замын асуудлыг тусгаагүй шалтгааны талаар,

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм тогтоолын төсөлд иргэдэд хуваарилах 1072 хувьцааны талаар болон харьяатаас гарсан, нас барсан, шинээр төрсөн хүүхдүүдэд 1072 хувьцааг нөхөн олгох асуудлыг тусгах боломж байгаа эсэх,

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах талаар,

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын 2023 оны 8 дугаар тогтоолоор өгсөн үүргийн хэрэгжилтийг Улсын Их Хуралд

танилцуулах талаар асуулт асууж хариулт авсан болно.

Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжиж, Байнгын хорооны санал, дүгнэлтийг тогтоолын төслийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг ороорой.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 11-ийн А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт сурагчид, багш нар Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Сурах чиглэлийг эрхэм болговоос хандах зүг чинь өөрөө тогтоно шүү гэдгийг санаж яваарай.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Өчигдөр нэлээн ярьсан даа. Баагаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа. Ш.Адъяаа гишүүнээр тасаллаа.

Үгүй наад байхгүй хүний кноп яагаад дарчхав аа? Хас. Байхгүй хүний өмнөөс кноп дардаг та хэн юм. Та Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд халдаж байна. Наадхаа буцаад зас. Хас.

Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын тогтоол энэ онцгой дэглэмийг сонгох энэ юуг дэмжиж байгаа юм.

Тэгээд яах вэ, энэ тогтоол маань их ерөнхий гарч байгаа юм. Ерөнхий гарч байгаа энэ дотроо тэгээд зохицуулж ажиллах юм уу, яах юм?

Нүүрсээ тэр биржээр худалдах асуудлыг энд тусгаагүй байгаа. Хувьцаат компани болох тэр бэлтгэл ажлуудыг хийх ёстой.

Энэ зөрчигдсөн технологиудыг зөв болгох чиглэлд ажиллах ёстой. Энэ бүтээгдэхүүнээ бүс нутгийн. Одоо дэлхийн зах зээлийн үнэ байлаа гэхэд бүс нутгийн үнэд хүргэж худалдах асуудал байгаа. Өр авлагын асуудал байгаа.

Тэгээд тэр хувьцаатай холбоотой асуудлууд гээд. Ингээд зөндөө олон асуудлууд байгаа юм л даа.

Эхний улирлын Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлын дүгнэлт гарч байна л даа. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 7.6 хувиар өссөн

байна. Энэ өсөлтөд нөлөөлж байгаа нь гэхээр уул уурхайн салбарын өсөлт 50 хувиар нэмэгдсэнээс дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 7.6 гэсэн ийм дүн гарч байна. Энэ их сайн үзүүлэлт.

Энд манай “Эрдэнэс Тавантолгой” компанийн удирдлагын ажилтнуудын хийж байгаа ажлын үр дүн гарч байна гэж бодож байгаа юм.

Энэ хулгай энэ тэртэй холбоотой асуудлуудыг мэдээж хянаж шалгадаг байгууллагууд нь шалгаж байгаа байх. Үр дүн нь ямар байдаг юм. Үүнийг мэдэх юм алга байна.

Энэ дотор томоохон төслүүдийг 4.9 тэрбум доллароор санхүүжүүлнэ. Тэгээд энэ дотор но-той юмнууд их байгаа л даа. Одоо энэ төмөр замтай холбоотой асуудал.

Энд энэ нүүрс баяжуулах үйлдвэр гээд 335 сая доллароор 10 сая тонныг Хятадын технологиор барьж байгаа. Үүний 43 сая долларыг нь өгчихсөн гэсэн ийм тооцоо явж байгаа байхгүй юу.

Гэтэл үүнийг “Энержи Ресурс” 10 биш 15 сая тонныг баяжуулахыг Евро Стандарт. Данийн **Ф.Л.Смит** /engineering group **FLSmidth & Co. A/S/** гэдэг компанийн технологиор 120 сая төгрөгөөр хийсэн байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь 335 гэж бараг 3 дахин илүү үнээр ингээд л явж байгаа байхгүй юу.

Тэгээд ийм ийм юмнуудаа та нар үзэхгүй бол бас болохгүй дээ. Энэ одоо маш их л юм явж байна даа. Тэгээд.

Газрын тос дамжуулах хоолой гээд 388 сая доллар.

Уг нь одоо тэгээд үүний тооцоог нь яаж хийсэн байдаг юм. Уг нь төмөр замаа тавиад төмөр замаараа тээвэр хийгээд тэгээд ингээд явбал илүү ч үр ашигтай байсан байж магадгүй.

Энэ 19 сая доллар зарцуулчихсан гээд.

Энэ хулгайтайгаа тэмцэх чиглэлд компанийн удирдлага идэвхтэй сайн ажиллах ёстой шүү. Үүнийг өнөөдөр би зориуд тэмдэглэе. Ялангуяа энэ нүүрс баяжуулах үйлдвэрийнхээ энэ гэрээг эргэж үзээрэй.

Бэлэн 15 сая тонныг 120 сая доллароор евро стандартаар хийж байхад 10 сая тонн баяжуулах үйлдвэрийг 335 сая доллар гэж юу гэсэн үг юм бэ.

Ямар ид шидтэй юм болоод ийм болчхов оо. Үүнийг үзээрэй.

Тэгээд энэ тогтоолын төслийг нь хэлэлцээд батална биз дээ. Би дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Чинбатын Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Энэ “Эрдэнэс Монгол” компанитай холбоотой 2010 оны 07 сарын 07-нд анхны Улсын Их Хурлын тогтоол гарснаас хойш 7 тогтоол нийт гарсан байна.

Засгийн газрын 15 тогтоол гарсан гэж миний тоолсноор байна л даа.

Энэ бүх Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолуудаас нэлээд ажил хэрэгжээгүй байна.

Нэгдүгээрт, энэ нэг ширхэг давуу эрхийн хувьцаатай холбоотой 2 тогтоол гарч байсан.

Засгийн газрын 2012 оны 218 дугаар тогтоол, 2017 оны 154 дүгээр тогтоол байгаа. Тэгээд энд болохоор Монгол Улсын иргэн бүрд эзэмшүүлсэн нэг ширхэг давуу эрхийн хувьцааны бүртгэлийг баталгаажуулах арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХК компанийн ТУЗ-д даалгасугай гээд ийм тогтоол.

Тэгэхээр үүний хэрэгжилт хангагдаагүй байна. Үүнтэй холбоотой төлөвлөж байгаа ажил, ярилцсан юм байна уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 440 мянга гаруй иргэний ногдол ашиг огт ороогүй байгаа.

“Эрдэнэс Монгол” компанийн 14.75 хувийг 2.5 сая иргэн эзэмшиж байгаа. Үүнээс 2 сая 171 мянга 215 иргэн нь ямар нэгэн байдлаар ногдол ашиг авсан байгаа.

440 мянга гаруй иргэн огт аваагүй байгаа. Үүнтэй холбоотой ямар арга хэмжээ авах вэ гэдэг хоёрдугаар асуудал.

Гуравдугаарт, 900 мянга гаруй хүүхдэд хувьцаа огт олгогдоогүй байгаа. Энэ асуудал түрүүн Байнгын хороон дээр яригдсан. Олгогдох юм байна гэж ойлгосон.

Дөрөвдүгээрт, Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйл байдаг. 5.6-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина гэж заасан байдаг.

Тэгэхээр яг хэзээ Монголын хөрөнгийн биржээр хувьцаагаа арилжих үйл ажиллагаанд оролцох вэ?

Ер нь үүнтэй холбоотой бас тогтоолууд ч гэсэн гарсан байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ тогтоолын хэрэгжилт хангагдахгүй байна гэж ойлгож байна.

Тэгээд хамгийн наад талын 1072 хувьцаатай холбоотой ногдол ашгийн асуудал хэзээ танай Удирдах зөвлөлөөр яригдах вэ? Ямар багцаа төлөвлөгөө байна вэ гэсэн энэ асуултуудад хариулж өгнө үү.

Г.Занданшатар: Өчигдөр хэлэлцээд тогтоол батлах хэлэлцүүлэг Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж л асуулт асууна л даа. Дэгээрээ Байнгын хорооны санал, дүгнэлттэй л холбогдуулж асуулт асууна.

Яг энэ асуудалтай шууд холбоогүй. Энэ онцгой дэглэмийн хугацаа сунгах л асуудал хэлэлцэж байгаа.

Ж.Ганбат бүрэн эрхт төлөөлөгч хариулах уу? Б.Ганбат дарга уу? Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд. 83. Тэргүүн дэд дарга Б.Ганбат хариулна. Бямбажавын Ганбат. Жигжидийн Ганбат биш. Бямбажавын Ганбат.

Б.Ганбат: Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Тавантолгой” компани дээр иргэдэд хувьцаа эзэмшүүлсэн. Аж ахуйн нэгжүүдэд тодорхой хэмжээний хувьцаа эзэмшүүлсэн ийм асуудал байгаа.

Өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааны эзэмшил, энэ асуудал нь үнэт цаасны төлбөр тооцоон дээр зөвхөн бүртгэлтэй байж байгаа.

Эдийн засгийн эргэлтэд орох энэ асуудал дээр асуудалтай байгаа. Цаашид

иргэдэд энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг эзэмшүүлэх үү гэдэг асуудал дээр Засгийн газар дээр нэлээн асуудал төлөвлөгдөөд явж байгаа.

Ногдол ашгийн хувьд “Эрдэнэс Тавантолгой” компани 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагаагаараа одоо хүлээгдэж байгаа гүйцэтгэлээрээ 1.3 их наядын ашигтай гарах ийм магадлалтай байгаа.

Гэхдээ энэ дүн маань хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажигдсан тэр дүн бол бас биш ээ.

Тийм учраас хөндлөнгийн аудитын байгууллагын баталгаажсан дүн гарангуут хэдий хэмжээний цэвэр ашиг гарах нь уу гэдэг энэ асуудал дээрээ тулгуурлаж байж энэ ногдол ашгийн асуудал яригдана.

Нөгөөтээгүүр компанийн тухай хууль байгаа. Ямар тохиолдолд ногдол ашиг хуваарилах вэ гэдэг асуудал зохицуулалт нь компанийнхаа хуулиар явж байгаа.

Ингээд “Эрдэнэс Тавантолгой” компанийн эрх бүхий байгууллага буюу төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хурал нь энэ ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хуулийн зохицуулалт ёсоор ногдол ашиг хуваарилсан тохиолдолд үйл ажиллагаа явуулах ийм санхүүгийн хувьд хүчин чадалтай байх зайлшгүй шаардлагатай.

Дээр нь компанийн санхүүгийн үйл ажиллагааныхаа үр дүн дээр хуримтлагдсан өр төлбөрийн асуудал бас нэлээн байдаг.

Тэгэхээр энэ бүх үйл ажиллагааг нарийн судалж тооцсоны үндсэн дээр энэ ногдол ашгийн асуудал яригдана.

Улсын Их Хурал, Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгой” компанийн үйл ажиллагаатай холбогдуулж гарсан бүх тогтоол шийдвэрийг компани нэг бүрчлэн хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн энэ үзүүлэлтээрээ тухай тухай үед нь тайлагнаад ингээд явж байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар Нийслэлийн Баянзүрх дүүргийн 35 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Эрхэм хүндэт ахмадууд Та бүхэндээ эрүүл энх, урт удаан наслахыг хүсэн ерөөе.

Ингээд Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Онцгой дэглэм БЭТ_[бүрэн эрхт төлөөлөгч]-ийг сунгах тухай өчигдөр, уржигдаржингаа л ярилаа.

Та нар БЭТ гэж үгүй мөн сайхан хүн байгаа, нэг сайн хүн байгаа, мундаг байна л гэж яриад байгаа юм.

Социализмын үед байна шүү дээ, хүн ярьсаар байгаад л алдсан шүү дээ.

Социализмын үеийн хамгийн том алдаа хүн ярьсан. Хууль биш. Хууль засагладаг биш хүн засагладаг байсан.

Би өнөөдөр хүн ярих гээгүй. Энэ хүмүүстэй би хувь хүний хувьд муу биш. Сайн ч биш. Би таних ч үгүй.

Харин та нар ямар тогтоол баталсныг хэл. Улсын Их Хурал бас нэр хүндээ хамгаалж ичих сэтгэл байна. Энэ ороод ирсэн энэ аймшигтай юмыг буцаагаад хэлэлцлээ.

Орж ирсэн юман дээр аудит хийлгээрэй, яаралтай хийгээрэй, даруй хийлгээрэй л гэсэн байна. Энэ чинь урьд нь аудит хийлгээрэй гэж хэлсэн шүү дээ.

Энэ чинь 2022 оны 12 дугаар сарын 12-нд 457 дугаар тогтоолоор. Аудит олдоогүй л гэсэн.

Энэ хууль засаглаж байгаа юм уу. Энэ юмаа болохгүй ээ. Дахиад л аудит олдоогүй л гэж ороод ирнэ дээ.

Хоёрдугаарт, энэ тогтоолын 5 дугаар зүйл дээр заалтын хэрэгжилтийг хангах талаар шуурхай арга хэмжээ авч, тус тогтоолын биелэлтийг сар бүр Улсын Их Хуралд тайлагнана гэж байгаа. Үгүй ээ, овоо доо.

Та нар энэ 5 дугаар тогтоол дээр би холбогдуулж юм хэлье дээ.

Хуульгүй доор хулгай, мэдлэггүй доор боол. Улсын Их Хурлын өмнөх 30 жилийн юмыг ярья.

Төрийн өмчтэй холбоотой энэ цөм цөм хулгай хийсний гай нь юунд гээч. Энэ мангас царайлаад л хөөрхий тэр муу хэдэн гүйцэтгэх захирлуудыг л муулаад л байна. Та нар БЭТ-үүдийг дараа нь муулна даа.

Улсын Их Хурал Нүдэн балай байж, мэдлэггүй байж ард түмний өмнөөс сонгогдсон Улсын Их Хурал ард түмнийг боол болгосон шүү.

Төрийн өмчийн энэ олон идэж уух шамшигдуулалт дээр Улсын Их Хурал хяналт тавиагүйгээсээ болж бид буруутай. БЭТ биш ээ. Өмнөх тэр гүйцэтгэх улсуудыг буруутгахаас илүү бид буруутай. Хяналт тавиагүйгээсээ бид буруутай.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа санаа гэвэл та нар ямар тогтоол дээр дэмжээд байгаагаа би хэлье дээ.

Үйлдвэрийн газар байгууллагад шаардлагатай гэж үзвэл нийтлэг баримталдаг хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүйгээр 6 сар хүртэл ажиллуулах эрхийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар онцгой дэглэм тогтоож олгосугай гэж байгаа байхгүй юу.

Та нар энэ ямар ч хууль хэрэгжихгүй шүү дээ. Энэ хүнд. Тендерийн хууль. Янз бүрийн тэр санхүүгийн тайлагнал, орлого, зарлагын тайлагнал, үйл ажиллагааны хууль хэрэгжихгүй байж болно гэж байгаа.

Энэ дээр Улсын Их Хурал хяналтаа тавиач ээ. Хүүхэд галаар тоглоход хажуугаар нь дугуй өнгөрвөл гэмт хэрэг гэж нэг үг байдаг юм шүү дээ.

Энэ БЭТ-ээ би хамгаалаад байна шүү дээ. Дараа нь шоронд хийхгүй гэж хэлээд байна шүү дээ. Бүх гүйцэтгэх захирлууд шоронд орсон.

Улсын Их Хурал хяналт тавиагүй нүдэн балай байсан учраас ийм байдалд орсон.

Тэгэхээр миний санал. БЭТ сунгах тогтоолд өөрчлөлт орсныг уншлаа.

Тэгэхээр ГОК-ийн өмнөхүүдээ ярья. ГОК-ийн БЭТ. Тэрний далбаан доор ямар олон хулгай хийсэн бол оо. “Эрдэнэс Тавантолгой”-н БЭТ гэдэг энэ эрдэнэсийн авдраа ямар ч хуульгүй цэгцэл гэж өгсөн энэ хүмүүсээ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу Хяналтын түр хороо байгуулж хяная.

Хөөрхий тэр эрдэнэсийн авдраа цэгцлээд гараад ирсэн хүний санамсаргүйгээр энд тэнд хармаанд нь алт эрдэнэс орчихсон байх вий дээ. Наалдчихсан байх вий дээ. Хүн хэрэгт хийхгүйн тулд цөмөөрөө хяная.

Ингээд миний санал. Би үг хэлж байна. Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу сөрөг хүчнээс толгойлж эрх баригчид аа үүнийг харин эсэргүүцэж нүдний булай болов. Хяналт шалгалтын комисс байгуулж, түр хороо байгуулж ард нийтийн сонсголыг хийе. Нийтийн сонсгол хийе. /минут дуусав/

Г.Занданшатар: С.Ганбаатар гишүүн үг хэллээ. Асуулт биш байна.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төсөл дээр энэ санаа байгаа байх.

Тэгэхдээ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар Хяналт шалгалтын түр хороог 19 гишүүн санаачилж байгуулж хэрэгжүүлж болно.

Нээлттэй сонсголыг 9 гишүүн санаачилж хийж болно. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг.

Тэгэхээр энэ тогтоолын хэрэгжилтийн талаар 9 гишүүн санаачлаад сонсгол зохион байгуулж болно.

Асуулга, асуулт тавьж болно. Ажлын хэсэг байгуулж болно.

Энэ зарчмаараа нээлттэй.

Ингээд Байнгын хорооны саналаар “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

24 гишүүн дэмжиж, 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

“Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулж, эцсийн найруулга дээр санал байна. БЭТ байж байгаарай. Ж.Ганбат дарга.

Та бүхэнд хатуу үүрэг өгч байгаа шүү.

Онцгой дэглэм тогтоосон 6 сарын хугацаанд компанийн удирдлага, зохион байгуулалт.

Үүнийг **corporate governance**_[компанийн засаглал] дагуу олон улсын зарчимд нийцүүлж энэ оновчтой, үр ашигтай бүтцийг бий болгоод, засаглалыг сайжруулах хэрэгтэй.

Ингэсний үндсэн дээр нээлттэй сонгон шалгаруулалтаар компанийн удирдлагыг томилох хэрэгтэй.

Хоёрдугаарт нь, компанийн үйл ажиллагаанд олон улсын нэр хүндтэй аудитын компаниар аудит хийлгэх хэрэгтэй. Энэ чинь IPO гаргах, дараа дараагийн бүх ажлын үндэс нь энэ.

Энэ олон жил хийгдсэн, хийгдээд байгаа л гэж яваад байгаа. Тэрийгээ цэгцлүүлж Улсын Их Хуралд танилцуулмаар байна.

Гуравдугаарт нь, энэ эрх зүйн хэм хэмжээг сахихгүй гээд одоо Тендерийн хууль дагаж мөрдөхгүй энэ тэр гээд С.Ганбаатар гишүүн хэлээд байна.

Тэрийг чанд сахина. Тэгвэл сүүлдээ бүгдээрээ хэрэгт орно. Шууд гэрээ байгуулж болохгүй. Нягтлан бодох бүртгэлийн хууль, бүх хууль тогтоомж чанд мөрдөж ажиллах ёстой.

Олон улсын нийтээр мөрдөгдөх зарчмыг чанд мөрдөж ажиллах ёстой. Тэр стандарт шаардлагыг хангаж ажиллах ёстой.

Ингэж нөгөө болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж байхгүй бол ниргэсэн хойно хашхирав гээд сүүлд нь юу болдог билээ. Тэрийг хатуу санаж анхаарч ажиллацгаагаарай.

Ийм учраас сар болгон танилцуулж байх тухай тэр хуулийн заалт тийм юм билээ. Тэгээд Компанийн тухай хуулиа Эдийн засгийн байнгын хороо яаралтай. Төрийн өмчийн компанийн тухай хуулиа яаралтай баталж гаргах хэрэгтэй байна. Тэгээд энэ хууль чинь бас түүгээр үйлчлэл нь зогсож байгаа.

Тэгэхээр тэр хугацаанаас өмнө амжиж энэ компанийн удирдлага, зохион байгуулалт, менежментээ сайн болгож, ийм жишиг тогтоохгүй бол бас

болзошгүй эрсдэлийг байнга санаж явах хэрэгтэйг анхааруулж байна.

Ингээд “Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Амжилт хүсье.

Манай Ж.Ганбат дарга сайн ажиллаж байгаа. Манай бүрэн эрхт

төлөөлөгч сайн ажиллаж байгаа. Одоо ажлаа улам сайжруулах хэрэгтэй.

Ингээд дараагийн асуудалд орно.

Энд гурван Ганбаа байлаа. Жигжидийн Ганбат, Бямбажавын Ганбат, Сайнхүүгийн Ганбаатар гээд тэгээд гурвууланг нь хэлж байна гээд ойлгочихъё.

Энэ органик үндэсний хууль байсан чинь алга болчихсон юм уу. Хойшлуулчих уу.

Тав.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 7 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолд мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрт хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог

нэмэгдүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтүүдийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, роол хүнсний зөв зохистой соёлтой, хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээнүүдийн хүрээнд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, баталгаат хүнсээр хангах асуудал үндэсний аюулгүй

байдлын чухал хэсгийн нэг бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан тогтоох судалгаа, шинжилгээний ажил эрчимтэй хөгжиж, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын түвшинд үйлдвэрлэлийн чиг хандлагад өөрчлөлт орж байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүнийг дэмжиж байна.

Энэхүү өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ нь халдварт болон халдварт бус өвчний хүчний хүчин зүйл, түүнээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлтэй холбоотой ба Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн дэх заалт “Хүн амьд явах эрхтэй” гэсэн суурь зарчимд хамаарна.

Монгол Улсын хүн амын нас баралтад амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зүрх судасны тогтолцоо, хавдар болон хоол боловсруулах эрхтний өвчин зонхилж статистик мэдээгээр 2021 оны байдлаар 65 хувийг эзэлж байна.

Хоол, хүнс өдөрт түвшний хэрэглээ чанартай, баталгаатай байна гэдэг нь биологи, хими, физикийн аливаа хорт бодисоор бохирдоогүй байх асуудал юм.

Хүн зөв зохистой хооллох, хоол хүнсний чанар, баталгаажилт, хаяг шошгын талаарх мэдлэг мэдээллийг авах органик үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих нь чухал юм.

Хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 дугаар судалгааны дүгнэлтэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, тэжээллэг, хүнд ээлтэй байгалийн гаралтай органик үйлдвэрлэлийг дэмжих,

олон нийтэд сурталчлах, мэдлэгийг сайжруулах, органик брэнд бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох чадвартай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эд боловсруулах, баталгаажуулах, хяналт тавих, бүртгэл, мэдээллийн сан байгуулах тогтолцоо бүрдүүлэх нь хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Манай улс 2030 он гэхэд нийт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилт тавьсан бөгөөд энэ зорилт нь 2016 онд батлагдсан.

Манай улс 2022 оны байдлаар 715 органик бүтээгдэхүүнийг 348 органик үйлдвэрлэл эрхлэгч үйлдвэрлэсэн бөгөөд үүнийг тухайн заасан сайтад бүртгүүлсэн байна.

Эдгээр органик бүтээгдэхүүний дийлэнх хувийг газар тариалангийн бүтээгдэхүүн эзэлж байгаа ба чанар, орлогын хэмжээ харилцан адилгүй.

Өнөөдрийн байдлаар албан ёсны тооцоо, судалгаа гараагүй байна.

Мөн иргэд органик бүтээгдэхүүний ашиг тусыг ойлгох нь дутмаг, дэмжлэг, урамшууллын тогтолцоо хангалтгүй, органик бүтээгдэхүүний эрх зүйн таатай орчин бүрдэхгүй байгаагаас шалтгаалан төдийлөн хөгжиж чадахгүй байна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн 50 хувиас дээш хэсэгт өөрчлөлт оруулсан тул шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр боловсрууллаа.

Органик хүнсний тухай хууль гэснийг Органик бүтээгдэхүүний тухай хууль гэж зохицуулах харилцаа, хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөн эх орны үйлдвэрлэлийн органик бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлсэн болно.

Хуулийн төсөл нь 5 бүлэг, 18 зүйлтэй.

1 дүгээр бүлэг. Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, органик үйлдвэрлэлийн зарчим.

2 дугаар бүлэг. Органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйлс орно.

3 дугаар бүлэг. Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагын үүрэг, шошгололт, бүртгэл мэдээлэл.

4 дүгээр бүлэг. Органик бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал.

5 дугаар бүлэг. Органик үйлдвэрлэл, органик бүтээгдэхүүнд тавих хяналт харилцааны тогтолцоог тус тус тусгаж өглөө.

Органик бүтээгдэхүүний тухай хууль батлагдсанаар байгаль орчин, эко систем, хүний эрүүл мэндэд ээлтэй органик үйлдвэрлэлийг дэмжин зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах, бүс, орон нутгийг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр бий болгох, органик хүнс, бүтээгдэхүүнээр хүн амаа хангах, экспортод гарах боломж бүрдэх юм.

Ингэснээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” болон Монгол Улсын урт

хугацааны бодлого “Алсын хараа-2050”-д дэвшүүлсэн зорилтуудад хүрэх юм.

Ингээд Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.
Ч.Ундрэм гишүүнд.

Одоо төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт хүрч байна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм нарын 7 гишүүнээс 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага хангасан, экологид ээлтэй хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хүнснээс бусад хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, сурталчлах, экспортлох органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг

хангахтай холбогдуулан харилцааг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Органик бүтээгдэхүүний тухай хууль батлагдсанаар байгаль орчин, эко систем, хүний эрүүл мэндэд ээлтэй органик үйлдвэрлэлийг дэмжих, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах, бүс, орон нутгийг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр бий болгох, органик хүнс, бүтээгдэхүүнээр хүн амаа хангах, экспортод гаргах боломж бүрдэнэ гэж төсөл санаачлагчид үзэн төслийг боловсруулж, **D-Parliament.mn** цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун Органик хүнсний тухай хуулийг Органик бүтээгдэхүүний тухай хууль гэж хүрээг нь өргөн агуулгатай болгосноор гол зорилго чиглэл нь хангагдаж байгаа эсэх, генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүний импортыг хязгаарлах талаар,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг төсөлд газар тариалангийн бүтээгдэхүүнийг эрэмбэлэн хамруулсныг дэмжиж байгаагаа илэрхийлээд мах, сүү зэрэг хөдөө аж ахуйн органик бүтээгдэхүүнийг хамруулах, үйлдвэрлэл эрхлэгчийг төрөөс татварын бодлогоор дэмжих, нөлөөлөх нөхцөл боломжийн талаар асуулт асууж хариулт авлаа.

Түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир хүнсний аюулгүй байдлыг анхаарах, органик цэвэр хүнсээр хүн амаа хангах эрх зүйн орчныг бүрдүүлснээр органик хүнс үйлдвэрлэгч, газар тариалан эрхлэгчийг дэмжих, татварын таатай

орчин бүрдүүлэх, энэхүү хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж,

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун органик бүтээгдэхүүний асуудлыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд бүлэг болгон оруулж болох, органик бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөх асуудлаар Засгийн газраас зөвшөөрөл авсан эсэх,

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам энэ хууль батлагдсанаар эдийн засгийг солонгоруулах, экспортоо нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх, аялал жуулчлалын салбарт ч чухал нөлөө үзүүлэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын салшгүй чухал хэсэг бөгөөд Монгол Улсын Их Хурлаас баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын хүрээнд энэ хуулийн төслийг өргөн мэдүүлснийг онцолж, органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн тэмдэг хэрэглэх, сурталчлах, худалдаалах, органик үйлдвэрлэл, хэрэглэгчид дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан зэрэг санал хэлсэн болно.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 90 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэгийн урилгаар Говьсүмбэр аймгийн 1 дүгээр сургуулийн 11 дүгээр ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт багш, сурагчид Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Сурах чиглэлийг эрхэм болговоос хандах зүг чинь өөрөө тогтоно гэдэг үгийг санаж яваарай.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Даваагийн Тунгалаг тус яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Жамбалын Төмөрхуяг тус яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Балганы Алтанцэцэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн төслийн менежер, Лхүндэвжамцын Тунгалаг “Тохирлын үнэлгээний байгууллагын хөгжлийн төв” төрийн бус байгууллагын захирал.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

О.Цогтгэрэл гишүүнээр, Г.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Би хуулийн төсөлтэй холбогдуулан хууль санаачлагчаас дөрвөн зүйлийг асууя гэж бодож байна. Их тодорхой зүйлүүд.

Энэ хуулийг уншихаар би энэ “органик бүтээгдэхүүн” гэж ямар бүтээгдэхүүн юм бэ гэдгийг л би олж харж чадсангүй. Яг ямар бүтээгдэхүүнийг

“органик бүтээгдэхүүн” гээд байгаа юм бэ?

Хуульд ийм ийм шат дамжлагаар явсан гээд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны технологи биччихээд байгаа юм.

Би ойлгохдоо ийм бүтээгдэхүүнийг органик гэнэ гээд. Эсвэл ийм стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг органик гэнэ гээд ингээд тодорхойлолт байх болов уу гэтэл огт байхгүй байгаад байгаа юм.

Тэгээд би ямар бүтээгдэхүүнийг органик бүтээгдэхүүн гэх вэ гэдгийг нэгдүгээрт нь асуумаар байна.

Хоёрдугаарт нь, органик бүтээгдэхүүний хууль гарснаараа бидэнд ямар давуу тал бий болох юм бэ? Ямар давуу тал бий болох юм.

Энэ органик бүтээгдэхүүний хууль гарснаараа манай экспорт болон үндэсний үйлдвэрлэлд ямар давуу тал бий болох вэ?

Хууль гараад заавал Монгол Улсын үйлдвэрлэлд, бид экспортод заавал энэ хууль гарснаар бид ач холбогдол гаргах ёстой. Гэтэл энэ хууль гарснаар ямар ач холбогдол гаргах гээд байна вэ гэдэг асуудал.

Гурав. Энэ хуулийг ингээд хараад уншихаар энэ хуулийг дагасан хуулийг ч гэсэн. Энэ хууль гарахад асар өндөр зардал шаардах гээд байгаа юм. Тухайлбал маш их хэмжээний татварын хөнгөлөлт, чөлөөлөлт байна. Хөнгөлөлт, чөлөөлөлт байна.

Энэ органик бүтээгдэхүүний хуулийг экспортолсон тохиолдолд хүүгийн 50-иас доошгүй хувийг хүртэл

өгөхөөр байна. Тийм. Энэ асар их зардалтай байгаад байгаа байхгүй юу.

Энэ зардалтай холбоотой асуудлаар Засгийн газрын саналыг авсан уу? Энэ материал дээр Засгийн газрын санал тусгагдаагүй байна л даа. Бид хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудал дээр заавал Засгийн газрын саналыг авч байх ёстой. Тэрийг тусгаж байх ёстой. Тэгээд энэ хуулийн төсөл дээр алга байна л даа. Энэ материал дээр

Тэгэхээр Засгийн газар юу гэж үзсэн юм бэ? Энэ саналыг. Энэ хөрөнгө мөнгө шаардлагатай юм.

Ер нь Та бүхний тооцож байгаагаар жилд ямар хэмжээний санхүүгийн эх үүсвэр шаардлагатай юм бэ? Энэ хууль гарснаараа. Үүнийг би гуравдугаарт нь асууя гэж бодож байна.

Дөрөв дэх асуудал нь юу байна вэ гэхээр органик бүтээгдэхүүн. Би хамгийн түрүүнд монгол малын мах гэж бодоод байгаа байхгүй юу. Монгол малын мах.

Гэтэл энэ монгол малын мах маань сүүлийн үед нөгөө идэж байгаа ургамлаасаа шалтгаалаад органик байх уу, үгүй юу гэдэг асуудал бий болчихоод байгаа байхгүй юу.

Хэрэглэж байгаа тариа, идэж байгаа зүйлээсээ хамаараад. Сүүлийн үед ургамлын бүтцэд маш их хэмжээний өөрчлөлт орсон. Энэ уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн талхлалдтай холбоотойгоор. Идэж байгаа хүнсний бүтээгдэхүүнд өөрчлөлт орчихсон.

Гэтэл үүнийг органик гэж үзэх үү, үгүй юу гээд л ингээд эхэлж байгаа байхгүй юу. Гэтэл үүнийг хөгжүүлэхийн тулд юу хийх гэж байна вэ

гэдэг. Тодорхой зүйл жишээлбэл багтаж байна уу?

Уур амьсгалын өөрчлөлт тарианд ч нөлөөлнө, мал аж ахуйн салбарт ч нөлөөлнө. Уур амьсгалын өөрчлөлтийг, бэлчээрийн талхлагдлыг, ургамлын бүтцийг сайжруулахын тулд ер нь юу хийх гээд энэ хуульд ийм юм хийх шаардлага байна гэж тусгаж байна.

Өөрөөр хэлбэл органик бүтээгдэхүүнийхээ үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд ийм ийм юм байна гэсэн тодорхой зүйл байна уу гэсэн ийм дөрвөн зүйл дээр хариулт авъя гэж бод бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах юм. Чинбатын Ундрэм. Хууль санаачлагч хариулыа.

Ч.Ундрэм: Нэгдүгээр асуулт. Органик бүтээгдэхүүн гэж органик үйлдвэрлэлийн үр дүнд бий болж байгаа бүтээгдэхүүнийг л хэлж байгаа юм. Д.Тогтохсүрэн дарга аа.

Тэгэхээр органик үйлдвэрлэлийн үр дүнд болж байгаа бүтээгдэхүүн гэдэг нь боловсруулалт, бэлтгэл, хадгалалт, тээвэрлэлт, худалдааны болон одоо бүх үе шат нь органик байж нөгөө гарч байгаа бүтээгдэхүүн нь органик байна гэсэн үг.

Одоо жишээлэх юм бол та түрүүн малын жишээг ярьж байна л даа.

Тэгэхээр тэр малын идэж байгаа тэжээлээс авхуулаад ямар нэгэн пестицид, химийн хортой бордоо огт хэрэглээгүй тэжээл тухайн мал нь тийм тэжээлээр тэжээгдэх ёстой.

Мөн хэрэглэж байгаа вакцин болон эм тариа нь бүгдээрээ органик байх ёстой.

Мөн тухайн махыг бэлтгэж байгаа аргууд нь ч гэсэн мал амьтанд ээлтэй тийм арга технологи байх ёстой.

Тэгээд бүтээгдэхүүний савлаж байгаа сав нь ч гэсэн хүний биед хоргүй тийм сав, хадгалах юманд хадгалагдаад, тээвэрлэгдээд хэрэглэгчийн гар дээр очтолоо бүх энэ процесс нь органик байж тухайн бүтээгдэхүүнийг органик гэж ойлгоно.

Энэ процессыг хөндлөнгийн баталгаажуулах болон хамтын баталгаажуулалт гэсэн тэр баталгаажуулах технологийн дагуу баталгаажуулаад органик мөн байна гээд шошгыг өгч байгаа юм.

Тэгэхээр энэ органик үйлдвэрлэлийн үр дүнд бий болж байгаа бүтээгдэхүүнийг органик бүтээгдэхүүн гэж хэлнэ гэж ойлгож болох нь ээ.

Энэ хууль гарснаар ямар үр дүн гарах вэ гэж байгаа юм.

Нэгдүгээрт, энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой үр дүн гарна гэж бодож байгаа.

Өнөөдөр Монгол Улсад үйлдвэрлэгдэж байгаа нийт хүнсний нэг хувь ч хүрэхгүй нь органик бүтээгдэхүүн гэдэг баталгаажуулалтыг авч өнөөдөр худалдаа, борлуулалт, эдийн засгийн эргэлтэд орсон байгаа. Бусад 99 гаруй хувь нь дандаа ямар ч баталгаажуулалтад ороогүй. Органик үгүй, ямар нь мэдэгдэхгүй, ямар химийн хортой бодис хэрэглэж үйлдвэрлэгдсэн нь мэдэгдэхгүй тийм бүтээгдэхүүнүүдийг бид хэрэглэж байгаа гэсэн үг байх нь байна.

Тэгэхээр нэгдүгээрт энэ бид хүнсний аюулгүй байдлаа хангахын тулд

бидний идэж хэрэглэж байгаа бүтээгдэхүүн нь органик мөн юм уу, биш юм уу гэдгийг хэрэглэгч мэддэг болох нь байна.

Хоёрдугаарт, илүү үүнийг мэддэг болсноор болон энэ хуулийн үр дүнд илүү олон үйлдвэрлэгч янз бүрийн дэмжлэгүүд энэ хуулийг болон дагалдаж гарч байгаа хуульд орсон учраас илүү олон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн тоо нэмэгдэнэ гэж бодож байгаа.

Ингээд нэгдүгээрт хүнсний аюулгүй байдал хангагдаж, эрүүл мэндийн ач холбогдолтой.

Хоёрдугаарт, эдийн засгийн ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Энэ хууль бий болсноор бид гадаад руу органик хүнсээ баталгаажуулаад хоёр улсын баталгаажуулалтыг хүлээн зөвшөөрүүлээд экспортлох боломж бүрдэж байгаа.

Ингэснээр эдийн засгаа бид солонгоруулах, экспортоо нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөлөл гарна гэж үзэж байгаа.

Гуравдугаарт, энэ байгаль орчны эерэг нөлөөтэй юм. Органик хүнс бол хөрс органик эрүүл байж байж органик хүнс бий болдог. Хөрсийг бид хамгийн нэгдүгээрт хамгаалах юм. Хөрсөнд янз бүрийн хортой химийн бодис бордоо гэдэг нэрийн доор хэрэглэхээ болино гэсэн үг.

Тэгэхээр энэ илүү байгаль орчинд ээлтэй ийм зүйл болно гэсэн үг.

Тэгэхээр эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчинд ээлтэй ийм үр дүн гарна гэж бодож байгаа.

Гуравдугаарт, энэ бол асар их зардал гарахгүй. Өнөөдөр нийт хүнс үйлдвэрлэлийн нэг хувь ч хүрэхгүй органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа хүмүүс маань бид нар илүү их өртгөөр энэ органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг. Одоо жишээлбэл ногоо тарьж байна гэхэд тэр хөрсөө 3 жил бэлддэг. Ямар нэгэн химийн хортой бордоо хэрэглэхгүйгээр хөрсөө 3 жил бэлдээд гараараа бүх юмаа тариад, зэрлэгээ гараараа зулгаагаад ингээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Товч тодорхой хариулаарай.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Сайнбуянгийн Амарсайхан нарын урилгаар Төв аймгийн Баяндэлгэр сумын бөхийн холбооны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс спорт, урлагийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн сайхныг хүсье. /алга ташив/

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Одоо яг Улсын Их Хурлын гишүүд үүнийг дэмжих ёстой хууль юм байгаа юм шүү.

Улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол одоо хүнстэй холбоотой болчихсон.

Тэгэхээр энэ хүнстэй холбоотой энэ хуулийг би санаж байна. 2012-2016 онд Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун үүнийг бас дэмжиж оруулж ирж генийн өөрчлөлттэй

бүтээгдэхүүнүүдээс яаж ард түмнээ хамгаалах вэ тухай бид бас хөөцөлдөж явж байсан.

Тэгээд энэ тухай хууль ороод ирсэн байна.

2016 онд энэ хууль батлагдсан. Яг Органик хүнсний тухай хууль. Одоо бол органик бүтээгдэхүүний тухай гэж өргөжүүлж, улам эх орны бүтээгдэхүүн гэдэг байдлаар нь оруулж ирж байгаа.

Дээр нь нэмээд 2016 онд энэ хууль батлагдаж байхад 2030 он гэхэд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 5 хувь органик баталгаажуулалтад хамруулна гэж зорилт тавьж байсан.

Манай орон ер нь ямар хол явж байна. 5-хан хувийг нь баталгаажуулах юм сан л гэж явж байна шүү дээ.

Манай ард түмэн өнөөдөр органик бус бүтээгдэхүүн хэрэглэж байгаа явдал үр хүүхэд, ирээдүйд энэ их ноцтой асуудал үүснэ. Ингээд энэ хуулийг дэмжиж байна.

Их Хурал яг энэ дээр л анхаарлаа тавих ёстой шүү дээ. Өнөөдөр ард иргэдийн ам руу юу орж байгаа вэ гэдгээс, бидний ам руу юу орж байгаа вэ гэдгээс бидний ирээдүй тусгаар тогтнол хараат болчихсон үед бид амьдарч байгаа.

Ингээд хуулийг дэмжээд. Түрүүн Д.Тогтохсүрэн гишүүний асуусан асуулттай төстөйдүү асуулт асуучихъя даа. Арай жоохон тодруулчихъя даа.

Ер нь хууль зардал, хөнгөлөлт, чөлөөлөлт нэлээд байх нь зөв өө. Энэ байхаас өөр аргагүй. Төр анхаарч л байгаа бол. Тэгэхгүй зүгээр тунхгийн чанартай органик гоё шүү гээд хаячих

биш. Хариуцагч тодорхой болговол энэ хууль их биелэх бодит үндэслэл болно гэж би итгэж байна.

15.1.1.шилжилтийн үеийн баталгаажуулалтын зардал. Яг хэн хариуцах вэ? Хэдэн төгрөг вэ?

15.1-д органик үйлдвэрлэл эрхлэгчийн дараах үйл ажиллагааг доор дурдсан мөнгөн дэмжлэг үзүүлнэ гэж байгаа.

15.2.олон улсын хэмжээнд зохион байгуулж байгаа үзэсгэлэн худалдаанд оролцуулах зардал. Хэн хариуцах юм?

15.1.3.органик бордоог үйлдвэрлэхэд. Хэн хариуцах вэ?

Дараа нь, 50 хувиас дээшгүй зээлийн хөнгөлөлт үзүүлэх юм байна. 75 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний нэг удаагийн улсын төсвийн дэмжлэг байна. Хэн хариуцах вэ? Хэдэн төгрөг болох вэ гэдэг дээр энэ 15.2.5, 15.2.4, 15.2.3 гээд 7 заалтад надад хариулт өгөөч. Нэг.

Хоёр дахь асуулт байна. Сонирхсон асуулт. Одоо энэ компост бордооны тухай л ярьсан юм шиг байна. Энэ дээр мэргэжлийн хүмүүс нь хариулах биз. Яамныхан.

8.1.3-д айл өрх болон үйлдвэр аж ахуйн газар бохир хот суурины цэвэрлэх байгууламжийн лаг ашиглах гээд үг орчихсон байна шүү. Органик үйлдвэрт хориглох зүйл гэж байна.

Энэ дээр яг ямар технологиор яаж хориглож байгаа вэ? Энэ би дэмжиж байгаа зүйл.

Энэ лагийг тэгвэл яаж бид устгалд оруулах вэ гэдэг дээр процессын янз бүрийн саналууд байгаа юу? Үүнийг би

дэмжиж, одоо яг процесс нь яаж байгаа вэ? Зүгээр тунхгийн чанар болохгүй талаасаа яаж анхаарч байгаа вэ?

Би хоёр асуултдаа хариулт авъя.

Г.Занданшатар: Чинбатын
Ундрэм гишүүн хариулна.

Ч.Ундрэм: Энэ органик бүтээгдэхүүний тухай хуулийг бид анх боловсруулахад маш олон улсын туршлагаудыг судалсан байгаа.

Тэгээд Европын холбоо гэхэд л нийт үйлдвэрлэлийнхээ 30 хувийг органик болгоно гээд бодлогын арга хэмжээнүүд Засгийн газраасаа авч байгаа.

Одоо Бутан Улс гэхэд 100 хувь органик болно гээд. Энэ бол манай аялал жуулчлалаас авхуулаад бусад бүх эдийн засгийн болон байгаль орчинд хэрэгтэй юм гээд 100 хувь органик гээд дэвшүүлчихсэн улс орнууд хүртэл байдаг юм билээ.

Тэгээд энэ органик үйлдвэрлэлийг нэмэхийн тулд маш их хэмжээний төрийн бодлого, татварын бодлого. Тийм ээ. Олон талын ийм дэмжлэгүүд байж байж органик үйлдвэрлэл өөрөө урагшаа явдаг юм билээ.

Яагаад вэ гэхээр органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь өөрөө маш их хэмжээний хөдөлмөр, мөн өртөг шингэж байж энэ бүтээгдэхүүнийг бий болгодог. Жишээлбэл, ногоо тарья гэхэд л хөрсөө 3 жил бэлдэх. Тэгээд ногоогоо тариад зэрлэгээ гараараа зулгаах, янз бүрийн химийн бордоо хэрэглэдэггүй. Тэгээд ногоогоо хураах, савлах, тээвэрлэх гээд бүх процесст нь их хэмжээний өртөг шингэдэг учраас органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчтэйгээ очоод уулзахаар бид ингэж ингэж зовж үйлдвэрлэхээд тэгээд

яг адилхан үнээр очоод зарахаар бид нарт ашиггүй байна. Тэгсэнд орвол химийн бордоо ашиглаад органик бишээр үйлдвэрлээд маш их хэмжээнээр том хэмжээтэй үйлдвэрлээд ингээд зарах юм бол бид нарт илүү ашигтай байна.

Тийм учраас бид нарыг ямар нэгэн байдлаар бодлогоор дэмжих шаардлагатай байна гэдгийн үндсэн дээр энэ 15 дугаар зүйл төрөөс органик үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг гээд энэ дэмжлэгүүд орж ирсэн байгаад байна.

Тэгэхээр энэ шилжилтийн үеийн баталгаажуулалтын зардал. Гадаадад жилд удаа ч юм уу энэ олон улсын органик үзэсгэлэн гэж зохион байгуулагддаг. Энд нь оролцоход нь тэр зөгийн бал үйлдвэрлэдэг хүмүүсээ, органикаар боловсруулж гаргасан Монгол гоо сайхны бүтээгдэхүүн, малын арьс, ширээр хийсэн бүтээгдэхүүн, ноос ноолуур гээд органик брэнд гээд Говь дээр хүртэл байж байна шүү дээ. Эд нарыгаа бид оролцоход нь тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлчихье гээд.

Энэ дэмжлэгүүдийг төр төсвийн тухай хуульд тусгаад төрөөс дэмжлэгийг үзүүлбэ гэж байгаа юм.

Тэгээд энэ нийт дэмжлэг нь нэг тэрбум төгрөг л болно. Яагаад гэвэл бид нарын органик үйлдвэрлэл өнөөдөр хүнсний бүтээгдэхүүний нэг хувьд ч хүрэхгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр бид тодорхой дэмжлэгүүд болон татварын хөнгөлөлт нь бүгд нийлээд нэг тэрбум төгрөг болох юм байна. Цаашлаад эргүүлээд Монголд оруулж ирэх тэр орлого нь маш илүү байна гэж үзэж байгаа юм.

Тэгээд Засгийн газраас бид санал авсан байгаа. Энэ дээр. Засгийн газраас үүний эсрэг яг энэ татварын болон бусад дэмжлэг, мөнгөн дэмжлэгүүдэд ямар нэгэн эсэргүүцсэн хариулт огт ирээгүй байгаа. Өөр зүгээр процесс үг, агуулга, нэр, томъёотой холбоотой ганц хоёр санал ирснийг бид хуульдаа тусгаад өргөн барьсан байгаа.

Хоёр дахь асуудалтай холбоотой манай ажлын хэсгийн гишүүд хариулна.

Г.Занданшатар: 85. Д.Есөн-Эрдэнэ.

Тэр Шаамар суманд амласан тэр хүлэмж шийдсэн үү. Тэрийг хариулаадаа даа.

Д.Есөн-Эрдэнэ: Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ байна.

Шаамар суманд өнгөрсөн жил хүлэмжийн тендер зарласан. 27-нд нээхээр байгаа. Тийм. 400 сая төгрөгийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахаар.

Г.Занданшатар: Хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулж байгаа. Сайн байна.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хуулийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа гэдгээ хэлье.

Надад хоёр, гурван тодорхой асуулт байгаа. Асуугаад орхиё.

Нэгдүгээрт, энэ хуулийн төслийн 5 дугаар зүйл 5.1.1 хөрс, ус, агаар, ургамал,

амьтан, хүн амын оршин тогтнох эрүүл аюулгүй байдлыг хамгаалсан байх гээд ингээд заачихсан байна.

Тэгэхээр Та бүхэн маань энэ хуулийн төслийг боловсруулахдаа хуулийн төсөл, шийдвэрүүд боловсруулах тэр үндсэн зарчмын дагуу нэлээн судалгаа хийсэн болов уу гэж би ингэж үзээд байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр манай улсын хөрс, ус, агаар ямар түвшинд байна аа? Энэ дээр даацтай судалгаа хийсэн ийм зүйлүүд байна уу?

Одоо уул уурхайн хууль зах замбараагүй үйл ажиллагаанууд явагдсан. Үүний тодорхой жишээ бол энэ алтны уурхайнууд. Бүр цианит натри хүртэл ашиглаж байсан. Тэр нь гол хүний цэвэр ундны усны эх үүсвэр, гол мөрний эх бүрэлдэх энэ хэсгүүд дээр үйл ажиллагаа явуулж байсан шүү дээ.

Тэгээд бид 2009 онд урт нэртэй гэж нэрлэгддэг хуулийг баталж, энэ гол мөрний эхийг бохирдуулж байгаа, хорт бодис ашиглаж байгаа энэ уул уурхайн үйл ажиллагаанд хязгаарлалт тавьсан.

Маш их эсэргүүцэлтэй, маш их гүтгэлэг, доромжлол дунд явж ирсэн гэдгийг мэдэж байгаа.

Цаашлах юм бол аюултай хог хаягдлууд байна. Ашигласан батарей байна. Одоо приус машины энэ хосолмол хабрид машинуудын зай хураагуур. Ингээд цаашаа ярих юм бол олон энэ хөрс, агаар, усыг бохирдуулж байгаа ийм хүчин зүйлүүд байх юм.

Энэ дээр тодорхой судалгаа хийсэн ийм зүйлүүд байна уу?

Цаашлах юм бол хуванцар сав, суулгатай холбоотой хэрэглээ, энэ аюулгүй хэрэглээтэй холбоотой та нар маань үзэж харж байгаа юм байна уу?

Цаашлах юм бол энэ хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуйд газар тариалан гэхэд химийн бордоо ашигладаг, мал аж ахуйд тарилга, туулга, вакцин, энэ эм бэлдмэлээс өгсүүлээд анхаарал татах асуудлууд байна.

Тэгээд та нар маань энэ органик хууль гэдэг энэ гадна үг, энэ чамирхлаар асуудалд хандаж байна уу? Энэ монгол нэр томъёогоор оруулах бололцоо байгаагүй юм уу? Тухайлах юм бол байгалийн цэвэр бүтээгдэхүүн ч гэдэг юм уу. Энэ талаас нь анхаарч үзсэн ийм зүйлүүд байх уу, үгүй юу гэж.

Нөгөө талынх нь асуух гээд байгаа зүйл бол энэ гаднаас орж ирж байгаа үр, энэ үрээр үрлэж тариалсан газар тариалангийн хүнсний ногоо, үр тариа ийм зүйлүүд чинь одоо Та бүхний хэлж байгаа энэ байгалийн гаралтай цэвэр бүтээгдэхүүний ангилалд орох уу?

Мал байна. Мал гаднаас импортоор авч байгаа. Эрлийз мал. Гарал үүслийн хувьд. Цаашлах юм бол үр байна. Хөврөл. Одоо зохиомол хээлтүүлэг хийж байгаа шүү дээ. Үүнтэй холбоотой тодорхой зүйлүүдийг хэлж болох уу, үгүй юу гэж.

Хамгийн сүүлд асуух гээд байгаа нэг зүйл бол зөвхөн хүнсний бүтээгдэхүүнээр хязгаарлаж байна уу?

Ер нь хүний хэрэглээний бүтээгдэхүүнийг хамруулж оруулж байна уу? Үүнийг тодорхой ангилж ялгаж байна уу? Тухайлах юм бол ноос, ноолуураас эхлээд арьс, ширэн бүтээгдэхүүн.

Энд чинь аймшигтай тогтоогдоогүй асуудлууд байж болно шүү дээ.

Мод, модон эдлэл байж болно. Гэх мэтчилнээр анхаарсан зүйлүүд байна уу? Өргөн хүрээнд авч үзсэн зүйл байна уу?

Г.Занданшатар: Чинбатын Ундрам гишүүн. Хууль санаачлагч асуултад хариулъя.

Ч.Ундром: Б.Бат-Эрдэнэ гишүүн маш чухал асуудал хөндөж тавьж байна.

Энэ хуулийн гол зарчим нь байгаль дэлхий, хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүн амын оршин тогтнох эрүүл аюулгүй байдлыг хамгаалсан байх гэсэн үндсэн гол зарчим байгаад байгаа.

Тэгээд энэ хууль бол түрүүн хэлснээр нэгдүгээрт хүн амын эрүүл мэндтэй холбоотой.

Хоёрдугаарт. Энэ байгаль орчинтой холбоотой асуудал юм.

Тэгээд органик үйлдвэрлэлийг ярихын тулд нэгдүгээрт хөрс эрүүл байж хүнс эрүүл байх юм билээ.

Тэгэхээр хөрсийг эрүүл байлгахын тулд одоо энэ хуулийн дагуу ер нь хөрсөө төрүүлж 3 жил бэлтгэх, янз бүрийн химийн хортой бодисын нөлөөнд автуулахгүй байлгах гэх мэтчилэн ингэж бэлдэж байж дараа дараагийн үйлдвэрлэл нь хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой ингээд явагддаг ийм байгаа.

Тийм учраас тухайн орон нутгууд органик бүс гэж бүсээ тогтоогоод тухайн бүстээ энэ органик хүнс бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг явуулна.

Тэгээд энэ хууль нь өргөн хүрээнд авч үзэж байгаа юм. Өмнөх 2017 оноос хэрэгжсэн хууль нь Органик хүнсний тухай хууль байсан бол одоо бид нар Бүтээгдэхүүний тухай хууль гээд.

Нэгэнт органикаар өсөж үржүүлж байгаа мал аж ахуй байлаа гэхэд зөвхөн мах, сүүг нь бид органик гэхээд арьс шир, ноос, ноолуурыг нь органик биш гэж үзэхээр манайд эдийн засгийн хувьд хохиролтой болчхож байгаа юм.

Тийм учраас дагалдаж гарч байгаа арьс шир, ноос ноолуурыг нь бид бүгдийг нь органик гэдгээр баталгаажуулж олон улсад хоёр орны баталгаажуулалтаа хүлээн зөвшөөрснөөр **“органик”** гэдэг ангиллын доор илүү өндөр үнэтэйгээр экспортлох боломж нь бүрдэх учраас бид **“органик бүтээгдэхүүн”** гэж өргөн хүрээнд энэ асуудлыг оруулж ирж байгаа юм.

Тэгээд энэ дээр гоо сайхны бүтээгдэхүүн гээд маш өргөн, бүх төрлийн. Тэгэхдээ яг органикаар анхнаасаа авхуулаад хэрэглэгчдийн гар дээр хүртэл бүх процесс нь органик хүнсний үйлдвэрлэлийн зарчимд нийцэж байж органик гэж хүлээн зөвшөөрөгдөж, тэр шошгыг авч, тэр нэрийн доор борлуулагдах боломж нь бүрдэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас нөгөө малын вакцин, эм тариа, туулга гээд эдгээр бүх хэрэглэж байгаа зүйлүүд нь органик л байж байж тухайн мал аж ахуйг болон тухайн малаас гарч байгаа бүтээгдэхүүнийг органик гэж хүлээн зөвшөөрөх юм билээ.

Энэ хуулийн дагуу манай улсын органик гэж баталгаажуулж байгаа энэ процессыг гадаад улсын органик гэж баталгаажуулж байгаа процесстой

хоёуланг нь холбож харилцан хүлээн зөвшөөрүүлэх ажлыг бас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд энэ ажлыг бид даалгаж байгаа. Энэ хуулийн дагуу.

Ингэсний дагуу органик гэдэг нэрийн доор манай малчид илүү өндөр өртөгтэйгөөр махаа, арьс ширээ, ноос, ноолуураа борлуулах.

Цаашилбал, эцсийн бүтээгдэхүүн говийн органик гээд ноолууран бүтээгдэхүүн өнөөдөр яг энэ хуульд хамрагдаж чадахгүй байгаа.

Яагаад гэвэл органик хүнс гэхихсэн байгаа болохоор. бүтээгдэхүүн гэдэгт нь хамрагдаад экспортлох бүрэн боломж гарч байгаа.

Энэ малын үүлдрүүд болон төмс, хүнсний ногоо ч гэдэг юм уу, буудайны үр одоо бас импортоор орж ирж байгаа. Энэ импортоор орж ирж байгаа бүтээгдэхүүнүүд нь өөрсдөө бас яг органикаар бий болсон уу, үгүй юу гэдгийг манай улс ч гэсэн үүнийг баталгаажуулж байж органик гэж хүлээн зөвшөөрөх юм.

Тэрнээс энэ бий болсон процесс нь органик биш гений өөрчлөлттэй байх юм бол органик гэж бид хүлээн зөвшөөрөхгүй. Энэ хуульд хамрагдахгүй. Энэ хуулиар эдлэх хөнгөлөлтүүд болон төрийн дэмжлэгүүдийг эдлэх ямар ч боломжгүй болно гэсэн үг.

Манай ажлын хэсгээс бас нэмэлт.../минут дуусав/

Г.Занданшатар: 84.

Д.Тунгалаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн асуултад хариулъя.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын энэ хохирол үзэж доройтсон талбайн хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд 2.8 сая га-гаар буюу 45.7 хуиар нэмэгдсэн байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд.

Мөн нийт хохирол учирсан хөдөө аж ахуйн эдэлбэр газрын талбайн хэмжээ 6.3 сая га-д хүрсэн байгаа юм.

Тэгэхээр органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрдэмтдийн 15 жилийн хугацаанд хийсэн судалгаагаар органик тариалалт нь урт хугацаандаа хөрсний үржил шим, хүнсний ногооны ургацыг эрс сайжруулдаг. Тухайлбал, уламжлалт тариалалттай харьцуулахад хөрсний ялзмаг, азот, фосфор, калийн хэмжээ тус бүрдээ дахин нэмэгдсэн ийм үзүүлэлт байна.

Энэ дээр яах вэ, калийн хэмжээ арай бага. Бусад бордооны шимт бодисын хэмжээ нэмэгдсэн байгаа юм.

Тэгэхээр органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ялангуяа газар тариалангийн үйлдвэрлэл урт хугацаандаа манай хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хөрсний чанарыг сайжруулах, улмаар байгаль орчны энэ нөлөөг эрс сайжруулах боломжтой юм гэж үзэж байна.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Би хариултаа их тодорхой авч чадахгүй л байна л даа.

Та нар маань судалгаа хийгээд. Жишээлбэл 6.3 сая га газар доройтсон гэж яриад байгаа. Энэ 6.3 сая га газар чинь бохирдсон, химийн хорт бодис байдаг юм уу, ямар нэгэн байдлаар

бохирлогдсон тэр талбайд байгалийн цэвэр гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоогүй гэж ингэж заагласан, ялгасан ийм зүйл байна уу?

Энэ үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа, энэ юмнуудыг тодорхой зааглаад энэ энэ бүс нутагт нь энэ нь явагдана. Яг үүнээс өөр газарт нь ийм үйл ажиллагаануудыг явуулна гэсэн юмыг л би Та бүхэн энэ хуулиар зохицуулаасай.

Тэгээд хүмүүсийн хэрэглээ байна шүү дээ. Химийн хорт бодис, аюултай хог хаягдал. Одоо жишээлэх юм бол энэ хуулийн зохицуулалтаар чинь тэр миний хэлээд байгаа хабрид машины зай хураагуураас эхлээд энгийн хэрэглээний батарей ийм юмыг авдаг. Үүнийг нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо энэ батарей, аккумуляторын хаягдал, тэгээд тэрийг нь дахин боловсруулж байгаа байдал стандартын шаардлага хангахгүй. Хөрс, ус бохирдуулж байгаа маш том эмгэнэл болоод байгаа шүү дээ. Тийм ээ.

Үүнийг ер нь их анхаарч ажилламаар байгаа юм.

87. Тодорхой хариул гээд байна шүү дээ. Тэр 6.3 сая яг юугаар бохирдсон гэж та нар үзээд байгаа юм.

Б.Алтанцэцэг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Химийн хорт бодис, аюултай зай хураагуур гэх мэтчилэн энэ химийн гаралтай бодис, түүний үлдэгдэл, сав баглаа боодлын хаягдлыг Хог хаягдлын тухай болон Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулж байгаа.

Энэ хуульд заасны дагуу тусгайлсан цэг дээр энэ чиглэлийн зүйлийг хэрэглэсэн бол хэрэглэгч нь хүлээлгэж өгөөд, тэгээд тэрийгээ бүртгэж оруулдаг ийм үүрэгтэй байгаа.

Органик бол харин үүний эсрэг. Эдгээр зүйлийг үйлдвэрлэлдээ болон үйл ажиллагаандаа хэрэглэхийг хориглосон байгаа.

Түүнээс гадна цацрагийн бохирдолгүй байх гэсэн шаардлагуудыг тавьж байгаа. Эргээд байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэндэд ээлтэй, хөрсөндөө ээлтэй, бэлчээртээ ээлтэй ийм мал аж ахуйн болон газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхийг дэмжсэн хууль.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ Органик бүтээгдэхүүний хууль гээд. Өмнө нь Органик хүнсний хууль гэж байсан.

Тэгээд энэ дээрээ яг ямар тийм зарчмын том өөрчлөлт болоод ингээд анхдагч хууль болоод орж ирж байгаа юм.

Зүгээр хуулийн төслийг уншиж үзэхээр тийм том хэмжээний өөрчлөлт, дэвшил энд харагдахгүй л байгаад байна л даа.

Өмнөх хуулийн хэрэгжилт, үр нөлөөг яг юу гэж дүгнэсэн юм? Тэгэнгүүт энд одоо орж ирж байгаа хууль чинь тийм зарчмын яг органик хүнс гэдэг дээр тийм зарчмын түлхэц өгсөн зүйл яг үнэндээ харагдахгүй л байгаад байна л даа.

Ер нь энэ бүтээгдэхүүн чинь өөрөө байгалийн гаралтай, экологийн гаралтай,

органик гээд энэ чинь өөрөө ингээд бүгд үе шатуудтай.

Яг өнөөдөр манай Монгол Улсад та нар хувь нь органик байна гэж байна. Яг үнэндээ баталгаажсан бүтээгдэхүүн байхгүй шүү дээ. Яг бодит байдал дээр органик гээд хүлээн зөвшөөрчихсөн.

Тэр тусмаа энэ хуулийн төсөл дээрээс олж харахгүй байгаа зүйлс нь органик гэдгийг яг яаж баталгаажуулах юм, үүнд яаж итгэх юм? Энэ бусад орнууд манай Монголын бүтээгдэхүүнийг органик гэдэгт яаж итгэх юм?

Тэр тусмаа яг өнөөдрийн байдлаар миний санаж байгаагаар дэлхий нийтэд ISO энэ тэр гээд ингээд дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрөөд баталгаажуулалт явдаг шиг энэ органик юм аа, органик мөн юм аа гэдгийг баталгаажуулалт хийдэг нэгдсэн стандарт, дүрэм, журам, нэгдсэн тийм олон улсын байгууллага байдаггүй шиг би санагдаад байна.

Тэгэхээр та нар үүнийг манай Хөдөө аж ахуйн яам батлаад, Хөдөө аж ахуйн сайд журам баталж байгаад үүнийг энэ органик юм гээд биччихээр яг үнэндээ энэ чинь хүлээн зөвшөөрөгдөх юм уу? Үүн дээр яг ямар гарц, дүрэм, журам харж байгаа юм?

Та нарын энэ хууль дээр тиймэрхүү л гарц харагдана лээ. Тэгээд лаборатори гэдэг зүйл үүнийг дагалдаж явах ёстой. Тэр гаднын бодис, химийн нэмэлт бодисууд, бордоо энэ бүгд үнэхээр байхгүй гэдгийг яаж баталгаажуулах юм?

Манайд өнөөдөр энэ олон зүйлүүд чинь ингээд ийм цогцоороо асуудал байхгүй учраас өмнө нь гарсан хуулийн чинь хэрэгжилт гэдэг юм байхгүй. Одоо

үндсэндээ нэг ийм нэр солигдсон маягийн хууль. Яагаад үүнийг нэмэлт, өөрчлөлт, аль эсвэл Их Хурлын тогтоолын төсөл хэлбэрээр орж ирэх ёстой байж уу гэж л харагдаж байгаа юм.

Өөр энэ хууль дээр ингээд харагдаж байгаа нэг том чухал зүйл нь органик болоход зарцуулсан тэр зардал, банкны хүү, үзэсгэлэнд оролцсон гээд олон зүйлийг шууд хөнгөлөх тухай заалт байна л даа.

Одоо би жишээ нь энэ салбарыг бас тодорхой хэмжээнд гадарладаг хүний хувьд дахиад энэ төрийн бодлого шийдвэрийн үүднээс харсан ч гэсэн. Ийм урамшуулал, олон зүйлүүдийг үр дүнтэй нь холбож, үнэхээр органик болоод зах зээлд гараад борлуулалт хийсэн бол, бүтээгдэхүүн борлуулсан бол, тэрнээс бүтээгдэхүүн борлуулаагүй баахан органик болгохын төлөө би ийм үзэсгэлэнд оролцсон, баахан ийм банкны хүү авсан, ийм хөрөнгө оруулалт хийсэн. Үр дүнтэй холбоогүй баахан зардал, хөнгөлөлт, чөлөөлөлтийн юм ингээд оруулаад өгчихөөр дахиад л энэ чинь гажуудал шүү дээ. Социалист маягийн.

Одоо бүтээгдэхүүн байхгүй баахан органик болгоход хөгжүүлэлтэд гарсан зардал гээд л улсын төсөвт баахан юм сууна.

Энэ хуулийг харахаар 07 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ гэсэн байна лээ.

Энэ төсөв төлөвлөгөөнд яг энэ органиктайгаа холбоотой ямар зардал, нийтдээ ямар зардал гарна, хэчнээн бүтээгдэхүүн энэ баталгаажилт, энэ зардалд авна. Улсын төсвөөс ямар зардал гарна гэж тооцсон юм?

Энэ бүгдийг харахаар би одоо энэ хуулийг хууль хоёр гараа өргөөд дэмжих

ёстой хүн ч гэсэн яг ингээд боловсруулалтын түвшин, олон зүйлийг харахаар надад зүгээр өмнөх хууль дээрээ зарим зүйл дээр нэмэлт, өөрчлөлт оруулаад л ингээд сайжруулалт хийнэ биз.

Яг үнэндээ ахиц дэвшлийн тийм зүйл, заалтууд тааруухан л харагдаад байна.

Тэгээд саяын зүйлүүд дээр. Хамгийн гол нь тэр баталгаажуулалтыг яг яаж хийх гэж байгаа юм. Монголын бүтээгдэхүүн органик гэдгийг бусад орон яаж хүлээн зөвшөөрөх юм?

Манай нэг сайдын гаргасан журмаар энэ органик юмаа гээд тамга дарчихаар би тэрийг чинь бусад оронд чинь хүлээн зөвшөөрөхгүй байх л гэж бодож байна.

Г.Занданшатар: Ч.Ундрам гишүүн хууль санаачлагч хариулья.

Ч.Ундрам: Органик хүнсний тухай хууль 2016 онд батлагдаад, 2017 оноос эхэлж хэрэгжээд 5 жил хэрэгжсэн байдаг.

Энэ Органик бүтээгдэхүүний тухай хуулийн дагуу тухайн бүтээгдэхүүнийг органик гэж баталгаажуулдаг процесс нь Монголд нэлээн бий болоод эхнээсээ 200 гаруй компаниуд бүтээгдэхүүнээ органик гэж баталгаажуулаад хөндлөнгийн болон хамтын баталгаажуулах процессоор баталгааждаг.

Тэгээд зах зээлд органик бүтээгдэхүүнээ нийлүүлээд ингээд тодорхой хэмжээнд тогтчихсон байгаад байгаа.

Энэ хуулийн төслийн 3 дугаар бүлгийг та харах юм бол органик бүтээгдэхүүний баталгаажуулалт, шошгололт, бүртгэл гэсэн ийм хэсэг байгаад байгаа юм.

Олон улсад органик бүтээгдэхүүнийг баталгаажуулдаг тийм тогтсон процесс байдаг. Яг энэ процесстой адилхан Монголд хөндлөнгийн болон хамтын баталгаажуулалт нь хийгдээд явж байгаа.

Одоо үүнийг бид “бүтээгдэхүүн” гэж өргөжүүлж байгаа. Энэ нь ганцхан хүнсний биш, дагалдах. Жишээлбэл, мал дээр ярихад малын арьс шир, ноос ноолуур гээд бүтээгдэхүүнээр нь бид органик гэдгийг нь баталгаажуулаад.

Мөн яамнаас үүнийг гадаад улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудлыг хариуцдаг яамтай баталгаажуулах процессоо харилцан хүлээн зөвшөөрчих юм бол “органик” гэдэг нэрийн доор тухайн улс одоо тэр “органик” гэсэн шошгыг нь тавиад тэгээд илүү өндөр үнээр гадагшаа экспортлох бүрэн боломж бүрдэж байгаа юм.

Тийм болохоор ялангуяа танай компанид гэхэд маш их хэмжээний тийм боломжуудыг олгоно гэж би бодож байгаа.

Тэгээд яг энэ баталгаажуулалтад ороод органик гэдэг нь баталгаажуулалтад Монголын органик гэдэг шошгыг авчихсан тохиолдолд энэ хуулиар олгож байгаа хөнгөлөлтүүдийг эдлүүлэх юм.

Одоо жишээлбэл аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг хөнгөлөх.

Мөн гадаадын үзэсгэлэнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх,

хөнгөлөлттэй зээл авахад нь дэмжлэг үзүүлэх, олон нийтэд органик хүнс яагаад чухал юм бэ гэдгийг сурталчлах гэх мэтчилэн олон дэмжлэгүүдийг баталгаажсаны дараа өгнө.

Мэдээж баталгаажъя гээд хүсэлтээ гаргаад ир. Баталгаажих процессын зардлыг тодорхой хэмжээнд улсаас үүнийг хариуцъя гэж байгаа юм. Яагаад гэвэл малчид маань одоо жишээлбэл мал аж ахуйгаа органик гэдгийг баталгаажуулах тэр асуудал маш хүндрэлтэй байдаг учраас бид энэ хэмжээний дэмжлэгийг эхний ээлжид өгье гэж байгаа юм.

Тэгээд хамгийн зах зээлд бүрэн шилжсэн капиталист орнууд органикт яг манайх шиг ийм тусламж, дэмжлэгийг өгөөд явдаг юм байна лээ.

Жишээлбэл, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс байна, Америк байна гээд. Энэ зах зээл рүү аль эрт шилжсэн улс орнууд чинь “органик” гэдэг хүний эрүүл мэндэд, хүнс, хүнсний аюулгүй байдалд, эдийн засагт болон байгаль орчинд ямар чухал юм бэ гэдгийг нь мэдээд органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх ямар хэцүү байдаг юм бэ гэдгийг нь, ямар өндөр өртөгтэй байдаг юм бэ гэдгийг нь мэддэг учраас ингэж бодлогын дэмжлэгүүдийг өгдөг учраас бид яг тэр жишгийн дагуу.

Мэдээж бүр яг Герман шиг тийм их дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа ч гэсэн тодорхой хэмжээгээр энд оруулж өгсөн байгаа.

Тэгэхээр одоо яг үр дүнтэй нь холбогдсон тийм дэмжлэгүүд энд орсон гэж үзэж байгаа. Тэгээд нийт хуулийн ихэнх хэсэгт энэ өөрчлөлтүүд орсон учраас энэ шинэчилсэн найруулга гээд орж байгаа.

Мэдээж хууль 5 жил хэрэгжсэн учраас бид хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгээд өмнөх хууль маань мэдээж органик бүтээгдэхүүнийг бид өөрсдөө үйлдвэрлэдэг болох анхны алхмыг бий болгосон ч гэсэн илүү тунхгийн тийм шинж чанартай байгаа учраас бид бодит дэмжлэгийг энэ хуулиар олгох ёстой юм байна гэдэг ийм дүгнэлт гарсны үндсэн дээр хуулиа боловсруулаад Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэмжлэгтэйгээр олон хэлэлцүүлгүүдийг хийгээд өргөн барьсан байгаа.

Г.Занданшатар: 86.

Л.Тунгалаг: Гишүүний асуултад өмнөх хуулиасаа энэ хууль маань ялгаа нь гээд.

Хамгийн гол зарчмын ялгаа нь бол энэ хамрах хүрээнд. Зөвхөн хүнс хамрагдаж байсан бол одоо бусад хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүд хамрагдах боломжтой болсон.

Тэгэхээр иймэрхүү Монгол Улсыг ер нь гадна талдаа ч гэсэн харьцангуй органик. Органик гэдэг маань юу гэсэн үг юм гэхээр ер нь байгаль, амьд, байгалийн гаралтай гэсэн олон улсын үгнээс гаралтай. Олон улсад энэ нэр томъёог ашиглаж байгаа. Монгол Улс ч гэсэн ийм нэр томъёог ашиглаж байгаа.

Тийм учраас энэ хамрах хүрээний хувьд. Нөгөө талаасаа органик үйлдвэрлэлийг хүмүүс ойлгоод ер нь хэрэглээ бий болчихсон, зах зээл дээр бий болчихсон. Үүнийг авъя гэсэн хүмүүс бий болчихсон. Харин үйлдвэрлэгч талаасаа их хомс байгаад байдаг, ганцхан хувь байгаад байдаг. Тийм ээ.

Тийм учраас үүнийг ингээд дэмжиж өгөхгүй бол. Ийм үйлдвэрлэл эрхэлнэ гэдэг нь өөрөө цаанаа байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн ач холбогдолтой, хүний эрүүл энэ дээр ач холбогдолтой гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа учраас энэ үйлдвэрлэлийн түвшинд үүнийг нь дэмжиж өгөхгүй бол энэ рүүгээ үйлдвэрлэгчид маань орж өгөхгүй байна.

Тийм учраас шинэ хуулийн хувьд үүнийг сургамаар байна, сургалтын зардлууд ормоор байна. Одоо бас баталгаажуулах зардал нь хэрэгтэй байна.

Тэгээд энэ баталгаажуулалтын хувьд та яг гоё асуулт асууж байгаа нь Монгол Улс баталгаажуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр яг олон улсын бүх зарчмын дагуу мундаг хуультай. Яг орчин үеийн ийм зарчмын дагуу.

Тэгэхээр Монгол Улсад энэ хуулийн дагуу баталгаажуулалтын байгууллагууд нь бий болчихсон.

Тэгэхдээ мянга баталгаажуулалтын байгууллага бий боллоо гэхэд үйлдвэрлэгчид өөрсдөө дэмжигдэж орж ирэхгүй болохоор энэ баталгаажуулалт сул явагдаж байгаа.

Тийм болохоор энэ хууль гарч ирснээр баталгаажуулалт нь илүү эрчимтэй болно.

Яагаад гэвэл баталгаажуулалт гэхээр хүмүүс та нар харж байгаа бол өөрийнхөө бүтээгдэхүүнийг. Би органик юм үйлдвэрлэдэг, иддэг, хэрэглэдэг гэж ярьж байгаа боловч хэн үүнийг нотолчихсон юм бэ гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр албан ёсны баталгаажуулдаг ийм байгууллагуудын талаар одоохондоо мэдлэг сул байна.

Тэгээд яваандаа энэ нь цаашдаа бий болоод явчихна.

Тэгээд өөр хэлэх зүйл нь юу вэ гэхээр Монгол Улсын органик гэдгийг Монгол Улсынхаа хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулчихсан бүтээгдэхүүнүүд гадагшаа гарахаар танайх яахаараа, танайхыг зөвшөөрнө, зөвшөөрөхгүй, хүлээн зөвшөөрнө гэдэг асуудлууд маш их гардаг учраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэмжлэгтэйгээр Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Монгол Улсын энэ органик гээд ингээд тавьчихсан байгаа шаардлагууд олон улсын түвшинд, ижил түвшинд ойлгогдож хүлээн зөвшөөрч байгаа.

Баталгаажуулалтын байгууллагууд нь ижил түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна гэдэг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаанууд явагдаад магадгүй энэ жилдээ багтаагаад бид Монголын органик бүтээгдэхүүнүүдийг гадна талдаа ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх ийм нөхцөлүүд уже бүрдчихсэн байж байгаа.

Тэгэхээр өмнөх хууль дээр энэ зохицуулалт нь сайн тавигдаагүй байсан. Одоо шинэ хууль дээр яаманд энэ эрхийг нь өгчихсөн байгаа. Тийм ээ.

Тэгэхээр гол түншлэгч, импортлогч, Монгол Улсаас импортлогч улс орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулах эрхийг нь өгдөг. Хүлээн зөвшөөрүүлэх.

Одоо Хятад Улсын органикийн хууль гэж байгаа. Тийм ээ. Энэ хууль Монгол Улсын органикийн хуультай яаж дүйцэж байгаа юм. Тэгээд үүнийг ямар түвшинд хүлээн зөвшөөрөх ёстой юм гэдэг энэ зохицуулалтуудыг энэ шинэ хуульд оруулж өгсөн.

Г.Занданшатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууна.

Г.Мөнхцэцэг: Органик бүтээгдэхүүний тухай хууль гээд ингээд хууль орж ирж байгаа.

Энэ хуулийг зарчмынх нь хувьд дэмжиж байгаа юм. Тэгээд бид бас Байнгын хороон дээрээ нэлээд зүйлүүдийг ярьсан. Зарим нэг зүйлүүд дээр тодорхой хэмжээгээр асуултуудад тодорхой хариулт аваагүй учраас тодруулж асууя гэж энэ асуултыг тавьж байгаа юм.

Яах вэ ер нь ингээд бид Органик хүнсний тухай хууль, Бүтээгдэхүүний хүнсний тухай хууль байсан. Энэ хуулиа өргөжүүлээд “бүтээгдэхүүн” болгоод ингээд өргөжүүлж байгаа нь сайн хэрэг.

Тэгэхээр бид яах вэ, хүнс дээрээ тодорхой хэмжээгээр стандарт тогтоогоод ч юм уу, тэгээд энэ бараа, бүтээгдэхүүний шошго юмнуудаа сайн хараад энэ органик бүтээгдэхүүн мөн байна гээд ингээд авч хэрэглээндээ нэлээн аваад ирчихсэн ийм зүйлүүдүүд байгаа.

Бүтээгдэхүүн болоод ингээд өргөжөөд яваад ирэхээр яг одоо энэ бүтээгдэхүүн мөн байна, органик бүтээгдэхүүн юм гэдэг энэ стандартыг нь яаж тогтоох юм бэ? Энэ хуулиар тийм шинэчилсэн оруулж ирж байгаа зүйл, заалтууд байна уу, үгүй юу гэж.

Мөн дээрээс нь энэ аж ахуйн нэгжүүд хүн амын орлогын татвараас 90 хувь чөлөөлнө гээд байгаа. Ийм органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийг.

Тэгээд ирэхээр яг ийм хэмжээнд очтол нь. Одоо бол 50 хувьтай байгаа

байх. Тийм ээ. Яг 90 хувьд нь чөлөөлөх ийм бололцоо нөхцөлүүд нь байна уу, үгүй юу?

Яг ийм бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд маань манай улсын хэмжээнд хэд байдаг билээ. Тийм ээ. Ард иргэд, ялангуяа малчид маань өөрсдөө өрхийн үйлдвэрлэлийг маш их явуулж байгаа. Сүү, цагаагаа өөрсдөө бэлтгэж байна. Арьс ширээ өөрсдөө боловсруулж байна. Тодорхой хэмжээгээр зах зээлд гаргаад ингээд боловсруулаад явж байгаа.

Эд нарт маань энэ хууль өөрсдөө яаж үйлчлэх вэ? Тийм ээ. Ямар хөнгөлөлтүүд ирэх вэ? Энэ дээр зүйлчилж заасан зүйл, заалт байна уу, үгүй юу гэж.

Манайд Хүнсний аюулгүй байдлын тухай хууль гэж бий. Хүнсний хууль гэж бий. Энэ хуулиудтай уялдаж байгаа зүйлүүд нь байна уу, үгүй юу. Тийм ээ.

Бидэнд хамгийн гол нь генетикийн өөрчлөлттэй ийм Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийг нэн тэргүүнд оруулж ирэх шаардлагатай гэж би бас ингэж хардаг.

Ийм хуулиудад уялдах зүйлүүд нь хэр байгаа вэ? Энэ хуулиар зохицуулалтууд бий юу, үгүй юу гэдэг ийм асуултуудыг нэмж авч тодруулга авъя. Тавьж байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Чинбатын Ундрам гишүүн. Хууль санаачлагч хариулья.

Ч.Ундрам: Г.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Хамгийн их энэ хуульд хамрагдах хүмүүс бол би манай малчид гэж харж байгаа. Хэрвээ манай малчид тухайн мал

аж ахуйгаа органик гээд баталгаажуулчих юм бол хүн амын орлогын албан татварын 90 хувийн хөнгөлөлтөд хамрагдахаас гадна төрийн худалдан авалт, ерөнхий боловсролын сургуулийн “**Үдийн цай**” хөтөлбөрийг манай эмэгтэй гишүүд санаачлаад “**Үдийн хоол**” хөтөлбөр болгосон.

Тэгэхээр энэ ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөр болон бусад төрийн худалдан авалтад давуу эрхтэйгээр бүтээгдэхүүнээ зарах боломж олгогдож байгаа.

Мөн органик гэдгээ баталгаажуулчих юм бол гадагшаа махаа экспортлох, арьс шир, ноос ноолуураа “органик” гэдэг нэрийн доор экспортлох тэр боломжууд алсдаа бүрдээд илүү өндөр орлоготой органик тийм аж ахуй эрхэлдэг. Энэ бол олон улсад бүр тийм нэр хүндтэй ийм бизнес эрхлэгч болох боломжтой гэж үзэж байгаа.

Тэгээд Хүнсний тухай хуулийн их чухал органик гэсэн хэсэг нь энэ хууль уялдаж орж байгаа. Гэхдээ энэ хууль маань өөрөө зөвхөн хүнсээр хязгаарлагдахгүй.

Түрүүн миний хэлсэн малын бусад дагалдах бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур нь энд орно гэж үзэж байгаа учраас хүнсний органик бүтээгдэхүүний тухай хууль гэж ингэж оруулж байгаа юм.

Тэгээд энд мэдээж нөгөө генетикийн өөрчлөлт ороогүй бүтээгдэхүүн байж байж энэ Органик хүнсний тухай хуульд хамрагдана. Тэгээд энэ бол одоо бусад хүнсний тухай, генетик өөрчлөлттэй бүтээгдэхүүний тухай холбогдох бүх хуультай уялдаж ингэж гарч ирж байгаа ийм хууль байгаа.

Тэгээд үүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Швейцарын хөгжлийн агентлаг, манай улс органик бүтээгдэхүүний тухай хуулиа улам сайжруулж улам өргөн хүрээнд авч үзэж баталгаажуулалт болон төрийн дэмжлэгийг оруулж өгч байгаагаараа маш чухал юм гэдгийг аль аль нь илэрхийлж явж байгааг ташрамд дурдмаар байна.

Манай ажлын дэд хэсгээс хариулна.

Г.Занданшатар: 87 хариулья.

Л.Тунгалаг: Г.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Энэ хууль маань Хүнсний тухай хуультай уялдаж байгаа. Тухайлах юм бол Хүнсний тухай хуулийн 3.1.5 дээр органик хүнс гэж мал аж ахуй газар тариалангийн органик үйлдвэрлэлийн болон цэвэр байгалийн гаралтай Монгол Улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүнийг хэлнэ гээд томьёолчихсон байгаа.

Түүнээс гадна Органик хүнсний тухай хуулийг тусгайлсан хуулиар зохицуулна гээд энэ Хүнсний тухай хууль дээр бас тусгасан байдаг. Энэ хүрээндээ өмнөх хууль маань гарч явж байсан байна.

Түүнээс гадна органик үйлдвэрлэл өөрөө байгаль орчинд ээлтэй ийм үйлдвэрлэл. Дээрээс нь хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлагыг давхар хангахыг шаарддаг.

Тэгэхээр энэ хууль Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуультай уялдсан гэж хэлж болно.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад яг нөгөө органик бүртгэл мэдээллийн сан, цахим сан 2019 оноос эхлээд ингээд ажиллаад яг ямар аж ахуйн нэгжүүд, ямар өрхийн аж ахуй органик үйлдвэрлэл эрхлээд ямар бүтээгдэхүүн үйлдвэрлээд тэрийг нь хэн баталгаажуулаад байгаа юм бэ гэдэг энэ мэдээллийг гаргадаг байгаа. Энэ нь бас иргэнд нээлттэй.

Тэгэхээр зэрэг энэ сайтад мэдээлснээр өнөөдөр 172 иргэн, аж ахуйн нэгж байгаа. Үүнээс 24-хөн аж ахуйн нэгж органик болох бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн гэдгээ баталгаажуулсан байгаа.

Үлдсэн 148 нь иргэн байгаа. Тэгээд эдгээр аж ахуйн нэгжүүд 2016 оноос хойш маш ийм удаашралтай байгаа.

Тэгээд органикт өөрөө үйлдвэрлэл эрхлэгч сайн дурын үндсэн дээр шилжих ийм зохицуулалттай байдаг.

Тэгээд тэр дэмжлэг урамшууллын асуудлыг яг нарийвчилсан шалгуур үзүүлэлтүүдийг нь журмаар зохицуулахаар ингээд органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд тусгасан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Органик бүтээгдэхүүний тухай хуулийг дэмжиж байна.

Монгол Улсын эдийн засгийн том салбарын нэг бол энэ хөдөө аж ахуйн салбар. Уул уурхайтай өрсөлдөхүйц. Харамсалтай нь бид өнгөрсөн хугацаанд энэ салбараа өөд нь татаж уул уурхайдаа

өрсөлдөх хэмжээний ийм боломж, ийм нөхцөлийг бүрдүүлж чадаагүй.

Энэ бол одоо бид органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм бол энэ хажууд асар том зах зээл байна. Монголд ургуулсан бүгдийг авъя гэж байгаа шүү дээ. Тийм ээ. Тариа будаа, төмс, хүнсний ногоо, мах. Сая сая тонн чаддаг юм бол тэрийг чинь л авъя гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм их боломж зах зээл байгаа.

Энд хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх чиглэлд их зүйлийг хийх. Энд энэ органик бүтээгдэхүүний энэ хууль бол бас түлхэц өгч тодорхой хэмжээний улсын сан хөмрөгийг бүрдүүлэх, аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэхэд маш их чухал ийм ач холбогдолтой ийм хуулийн төсөл орж ирж байна.

Дэлхий ертөнцийн хандлага бол өнөөдөр органик бүтээгдэхүүнийг худалдаж авч байна шүү дээ.

Одоо эд нар чинь ингээд Америк гээд л ярьцгаадаг. Америк чинь нөгөө органик мах нь 40-өөс 50 доллар байхад органик ус нь 10-аас 20 доллар байгаа шүү дээ. Тийм ээ. Гэх жишээний одоо ийм байгаа.

Сүүлийн үед Австрали, Шинэ Зеландын органик хонины мах, Австрали, Уругвайн органик үхрийн мах гээд дэлхийн зах зээл дээр асар их өндөр үнэтэй болсон ийм байдалтай байгаа юм.

Тэгээд органик бүтээгдэхүүнийг төрийн оновчтой бодлого, зохицуулалтууд их хэрэгтэй. Хувийн хэвшил үйлдвэрлэнэ. Газрын

менежментийн асуудлыг их сайн шийдэж өгөх ёстой.

Урт хугацаатай, богино бага хүүтэй зээл өгөх ёстой. Татварын оновчтой бодлогууд энд хийгдэх ёстой. Их татвараас чөлөөлчхөж байна гэж байна. Одоо үүнээс их айгаад хэрэггүй.

Өнөөдөр үүнээс орж ирдэг татвар ер нь бага шүү дээ.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийг нь эхний ээлжид худалдаж авах ёстой. Тендер гээд байх ерөөсөө шаардлага байхгүй. Шууд худалдаж авдаг байх ёстой.

Энэ органик бүтээгдэхүүн чинь мэдлэг, хөдөлмөр шингэнэ л дээ. Тэгээд үүнийг яах вэ, хэлэлцэх явц дунд нь тодруулах байх. Сайжруулах янз бүрийн асуудлууд байхыг үгүйсгэхгүй.

Ер нь органик бүтээгдэхүүн гэдэгт тэр 95-аас дээш хувь нь органик байж органик гэж байгаа шүү дээ. Тийм ээ. Тэгээд энд хүрэхэд тодорхой хэмжээний хугацаа гээд янз бүрийн юмнууд бас орох байх л даа.

Гурван асуулт байна. Нэгдүгээрт нь, манай энэ хөгжлийн баримт бичигт 2030 он гэхэд нийт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулна гээд заачихсан.

Яг өнөөдөр 2023 оны байдлаар хэдэн хувь болж байгаа вэ гэсэн ийм асуулт байгаа.

Дараагийн асуудал юу гэхээр органик бүтээгдэхүүнийг хуурамч бүтээгдэхүүнээс ялгах асуудал орхигдчихсон гээд л ингээд яваад байдаг юм л даа.

Тэгээд яг үүнийг энэ хуульдаа яаж оруулж ирж байгаа вэ? Нөгөө хөрсгүй технологи гээд. Тийм ээ. **Hydroponics** билүү? Тийм ээ.

Тэрийг дэлхий нийтээрээ хориглож байгаа шүү дээ. Энд. Тийм ээ. Тэгээд энэ чиглэл яаж байгаа юм?

Төгсгөлийн асуулт. Энэ хөдөө аж ахуйн сайд байна. Би асууя.

Саяхан ярьж байгаад энэ ээмэгжүүлнэ гээд баахан хүмүүс шүүмжлээд бариад ингээд яачихлаа. Энэ ээмэгжүүлнэ гэдэг чинь одоо яах вэ, үхэрт яг тэр бүртгэлийн системийг нь тавьдаг юм нь бол одоо чихэнд нь л тавина л даа.

Дээр үед нэг ээмэгжүүлэлт гээд социализмын үед. Түүгээрээ ойлгоод хүмүүс ингээд байдаг.

Энэ ээмэгжүүлэх ажил маш чухал. Энэ чинь бүртгэл шүү дээ. Үүнийг хийснээр юу гэхээр хэдийд вакцинжуулсан юм, хэдийд ямар үйлчилгээ хийсэн юм. Жинхэнэ нөгөө органик мах гэдэг юм чинь эндээс.../минут дуусав/

Г.Занданшатар: Органик хууль хэлэлцэж байгаа учраас. Ээмэгний асуудлыг дараа жич хариулна биз.

Энэ хариултын дараа санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглана уу. Танхимд 21, 22 гишүүн байна.

Хэн хариулах вэ? Яах вэ хэлэлцэх эсэхээ шийдчихээд дараа нь тэгээд татварын асуудлыг жич.

Заалтууд дээр бол хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа явж байна.

Д.Тогтохсүрэн дарга аа, хэлэлцэх эсэхээ шийдчихээд дараа нь яг тухайн тийм заалтуудыг Засгийн газраас тусдаа саналаа өгөх ёстой. Тухайн заалтууд дээр нь хэлэлцэгдэнэ. Дэгээрээ тийм байгаа. Хуулиараа.

Ч.Ундрэм гишүүн хариулна. Дараа нь санал хураалттай.

Ч.Ундрэм: Б.Баттөмөр гишүүнтэй бүрэн санал нийлж байна.

Энэ бол хүн амын эрүүл мэндээс гадна манай эдийн засагт маш чухал хууль гэж бид үзэж байгаа.

Тэгээд манай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг илүү өндөр үнэ цэнтэйгээр гадаад улс руу экспортлоход энэ органик гэдэг баталгаажуулалтыг хийгээд хоёр улсын баталгаажуулалт нь хоорондоо харилцан хүлээн зөвшөөрөгдөөд явах юм бол манай малчид, төмс, хүнсний ногоо болон бусад тариаланчид маань илүү өндөр үнээр бүтээгдэхүүнээ зарах ийм боломж бүрдэнэ.

Тэгээд энэ хуульд нөгөө “хөрсгүй технологи” буюу “hydroponic” арга ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг органик үйлдвэрлэлд хориглоно гэж оруулсан байгаа.

Үүнийг олон улсын чиг хандлагууд нь хориглочихсон байгаа юм билээ.

Тэгээд мөн энэ дагалдах хууль дээр нь төрийн тендерийн тухай хуульд Төрийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авах тухай хуульд бид органик бүтээгдэхүүн байх юм бол илүү давуу эрх

олгоё гэдэг дагалдах хуулийг оруулж ирсэн байгаа.

Мөн уул уурхайн тухай хуульд нөхөн сэргээлтийг органик бордоогоор хийе гэсэн ийм давуу эрх олгосон байгаа.

Тэгээд энэ төрийн хөнгөлөлт нь өөрөө одоо угаасаа улсад Хүнсний тухай хуулиараа 50 хувийг хүнсний бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон хүн амын орлогын албан татвараас чөлөөлж байгаа.

Энэ дээр нэмээд 40 гээд яг органикт нь зориулаад 40-ийг нэмчхэж байгаа юм. Энэ нь бол одоо нийлбэр 1 тэрбум төгрөг хүрэхгүй ийм хөнгөлөлт байгаа шүү. Учир нь манай органик хүнс үйлдвэрлэл нийт хүнсний үйлдвэрлэлийн 1 хувьд ч хүрэхгүй байгаа учраас их хэмжээний зардал энэ дээр гарахгүй.

Тэгээд олон улсын чиг хандлага өрөөсөө органик руу явж байгаа учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ Та бүхнийг энэ хуулийг дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна.

Сайжруулах шаардлагатай зүйлийг нэгэнт хэлэлцэх эсэх нь шийдэгдээд ажлын хэсэг байгуулагдаад сайжруулах бүрэн боломжтой юм гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

“Эм интернэйшнл” ХХК-ийн хамт олон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс хамт олон Та бүхэнд

эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо санал хураалт явуулна. Шууд санал хураалт явуулчихвал.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Дэмжсэн дэмжээгүй үг хэлэх хүн байна уу? Б.Саранчимэг гишүүнээр тасаллаа.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнийг нэмээд, Ш.Адъяаа гишүүнийг хаслаа.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Би түрүүн асуултдаа огт хариулж авч чадаагүй л дээ.

Би нэгдүгээрт органик бүтээгдэхүүн яг ямар бүтээгдэхүүн хэлээд байгаа юм бэ? Тодорхой бүтээгдэхүүний нэр төрлөөр нь хэлээч ээ гэсэн огт надад нэрлэж хэлээгүй.

Импортыг хэлээд байгаа юм уу, экспортод гаргаснаа ярих юм уу гэдэг асуудал байхгүй юу.

Хоёрдугаарт, манай уламжлалт үйлдвэрлэлүүд, хүнсний үйлдвэрлэлүүд энэ юунд чинь орох юм уу гэдэг асуудал байхгүй юу. Органикт чинь.

Хоёр дахь юм нь би Засгийн газар ямар санал өгсөн юм бэ? Энэ хуулийн төсөл хавсаргаагүй. Засгийн газрын саналыг байнга хавсаргаж байх ёстой. Асар олон зардал байгаа байхгүй юу.

Нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвар. Хамгийн захын жишээ, хоёрхон жишээ хэлэхэд л энэ чинь ийм юм байгаа байхгүй юу.

Органик бүтээгдэхүүн экспортолсон тохиолдолд хөрөнгө оруулалтад зориулсан арилжааны банкнаас авсан зээлийн 50-иас доошгүй хувийг чөлөөлнө гэж байгаа байхгүй юу. Хүүгийн. Хэдэн төгрөг гэж тооцож байгаа юм. Зардлын тооцоо байхгүй байгаа байхгүй юу.

Дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн тохиолдолд түүний судалгаа, хөгжилтөд нь зарцуулсан зардлын 75 хувийг нөхөж олгоно гэж байгаа байхгүй юу.

Тэгээд НӨАТ-аас чөлөөлнө, гаалиас чөлөөлнө гээд асар олон юм байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийгээ бид ний нуугүй хэлэхэд ялгаж чадахгүй байхгүй юу. Органик, органик бус хоёроо. Зүгээр л энэ бол зүгээр нэг хуулийн цоорхой хийж дараа нь баахан хөрөнгө мөнгө яасан ийм л асуудал болно гэж би үзээд байгаа байхгүй юу.

Тийм учраас би ийм хууль дээр Засгийн газрын санал юу гэж байгаа юм бэ? Энэ их олон хөрөнгө зардлыг Засгийн газар зөвшөөрсөн юм уу гэж асуугаад байгаа юм.

Хуулийнхаа төсөлд ч үүнийг хавсаргаагүй мөртлөө хариулт ч хэлэхгүй байгаа байхгүй юу. Үгүй зөвшөөрсөн гэж тэр нь хаана байгаа юм. Алга байна шүү дээ. Энэ дээр.

Бидэнд үүнийг тараах ёстой байхгүй юу. Үүнийг тараагаагүй байхгүй юу. Ийм зардлыг энэ жилийн төсвийн дундуур Засгийн газар огт зөвшөөрөхгүй л дээ. Энэ тодорхой зүйл байхгүй юу.

Г.Занданшатар: Үүнийг хойшлуулах юм уу? Яршиг зүгээр.

Батсүхийн Саранчимэг гишүүн. Дэмжээгүй үг хэллээ.

Б.Саранчимэг: Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжийн тал дээр тодорхой саналууд, санаачилгууд гаргаад Улсын Их Хурал дээр хийгдэх арга хэмжээний талаар хөтөлбөрийг баталсан байгаа.

Тэгэхээр энэ хөтөлбөрийнхөө хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангахын тулд манай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр танилцуулагдаж байгаа 10-аад хууль орж ирэх.

Тэгээд тэр хуулийн бас нэг болох энэ Органик хүнсний хууль орж ирж байгааг дэмжиж байгаа юм.

Санаачлагч хүний хувьд ч тэр, ер нь органик хүнс өнөөдөр өөрөө дэлхий нийтээр бас яг энэ хандлага руу явчихсан байна шүү дээ.

Олон улсын хэмжээнд тэр. Одоо Канад Улс гэхэд чинь газар тариалангаа 30 хувийг нь яг органик хүнс. Ямар нэгэн химийн бордоогүй. Химийн бордооноос болоод хүмүүсийн гормонд өөрчлөлт орж байна.

Мөн цаашилбал эрүүл мэндэд маш сөргөөр нөлөөлж байгааг энэ судалгаа харуулсан.

Тэгэхээр олон улсын байгууллагууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагуудтай хамтраад энэ судалгаануудыг хийгээд, хэлэлцүүлгүүдийг хийгээд энэ хууль зайлшгүй улс оронд хэрэгтэй гэдэг

үндэслэл дээр өнөөдрийн хууль орж ирж байгааг үнэхээр дэмжиж байгаа юм.

Тийм учраас энэ хууль өнөөдөр ингээд алдаа оноотойг гишүүд хэлж байна. Гол нь энэ хуулиа хэдүүлээ хэлэлцэж, хэлэлцэхийг нь шийдээд ажлын хэсэг дээрээ илүү их өөрчлөөд сайжруулаад явах бүрэн боломжтой байгаа учраас гишүүдийгээ энэ хуулийг хэлэлцэх дээр нь дэмжиж өгөөч ээ гэж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын хувьд бас саналаа илэрхийлж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Би хуулийн төслийг хэлэлцээд явах нь зүйтэй гэж үзэж байна. Яг л ач холбогдлын хувьд тийм юм гэж.

Ер нь яах вэ, бид одоо бол энэ шинжлэх ухаан, техникийн технологийн хөгжлөөр хол хаягдчихсан.

Машин тэрэг, компьютер яриад байвал ямар ч нэмэр байхгүй. Гар утас хийх битгий хэл зүү, тэвэн ч хийж чаддаггүй улс юм чинь.

Тийм учраас одоо бид нарын энэ уул уурхайгаас өөр чадах юм бол хөдөө аж ахуйн гаралтай органик хүнс л байгаа юм.

Ялангуяа манай урд хөршид бол одоо дунджаас дээш орлоготой иргэд их болж байна. Эд нар чанарлаг хүнс буюу органик хүнс хэрэглэнэ. Хятад хамгийн том дутагдалтай юм бол хүүхдийн сүү байна. Жилдээ 40 сая хүүхэд төрөхөд ихэвчлэн хүүхдийн сүүгээ хангаж, ялангуяа баян иргэд нь гаднаас авдаг. Хонконг, Макао гэж авдаг.

Гэтэл бид нарт хүүхдийн сүү үйлдвэрлэх боломж байна уу байна. Арчаагүйдээ л өнөөдөр ингээд л алтаа зараад л, тэгээд л дийлэнх нь гуйлгачин царайлаад сууж байгаа нь бидний арчаагүйнх.

Хөдөө аж ахуйг яриад суугаад байж болохгүй. Хөдөө аж ахуйг энэ органик хүнсний үйлдвэрлэлийг бид эрс өөрчлөх ёстой.

Одоо та нар ингээд Европын орнуудаар, Америкаар яваад үзээрэй. 3, 4, 5 доллар гээд нөгөө нэг өвсний мах чинь, бордооны мах чинь тийм үнэтэй байгаа.

Одоо ингээд юу гэдэг юм Уругвай гэдэг юм уу, Аргентин, Шинэ Зеландын органик мах гээд та нар килограмм нь ямар үнэтэй гээд үзээрэй. 40 доллар байгаа. 1 килограмм органик мах 40 доллар. Монгол төгрөгөөр хэд вэ. 140, 150 мянган төгрөг гэсэн үг шүү дээ.

Тэгвэл тэнд иргэд яаж байна вэ манай махыг 40, 50 доллароор авч идэж байна. Тэгэхдээ тэр чинь ядуу иргэн авч идэж чадахгүй шүү дээ. Орлоготой иргэд нь авч иднэ.

Тэгэхээр би бас энэ гишүүд санаачлаад ийм болгоё. Органик хүнсээ гадаад зах зээлд гаргая гэж байгааг нулимж болохгүй. Энэ маш зөв.

Бид нарын цаашдаа хийж чадах бизнес ерөөсөө л энэ хөдөө аж ахуй. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэ, махаа үйлдвэрлэ.

Харин тэр дотроо бас тэр зарим тодорхойлж болохгүй байгаа татварынхаа асуудлуудыг та хэд явцынхаа дунд янзалчих. Энэ бол нэг алхам.

Ер нь бид нарын давуу тал бол энэ. Хийж чадах юм бол энэ. Өөр юу ч хийж чадахгүй. Юу ч хийж чаддаггүй шүү дээ. Бид нар. Хадаас ч хийж чаддаггүй шүү дээ. Үгүй тийм биз дээ.

Тэгээд юугаараа амьдрах гээд байгаа юм. Хэрэлдэж чаддаг. Нэгнийгээ үгүйсгэж чаддаг. Юмнаас бултаж чаддаг.

Тийм учраас чадаж байгаа энэ нэг хөдөө аж ахуй эрхэлж байгаа энэ хэдийгээ дэмжээд явахад ерөөсөө болохгүй юм бол байхгүй.

Харин яаж үүнийг нь зөв дэмжих вэ гэдэг асуудал.

Махны үнэ өснө. Хотын иргэдээ яах вэ. Тэгвэл органик хүнс үйлдвэрлэж байгаа улсуудаа гадаад оронд яадаг вэ. Дотаци өгдөг. Хотынхонд мах нийлүүлж байгаа малчид яах нь вэ. Дотаци өгдөг. Тэгж байж нөгөө махны үнийн зөрүүг нь гаргадаг.

Энэ органик мах үйлдвэрлэж байгаа бүх орон тийм байгаа. Манай тариа будаа бүх юм органик байна шүү дээ. Байгалийн бүтээгдэхүүн биш. Химийн юм ороогүйг органик хүнс гээд байгаа юм.

Тэгэхээр химийн юм ороогүй юм чинь энэ байгалийн бүтээгдэхүүн хүнд чинь хэрэгтэй байхгүй юу. Түүнээс биш тэр хиймэл, хими орчихсон юм хүнд тодорхой сөрөг нөлөөлөл өгч байгаа.

Тэгэхээр органик хүнс бол бидний цаашдын хөгжих орлого олох, амьдрах зам.

Тэгээд энэ рүүгээ одоо тэгээд ямар байдлаар алхам алхмаар урагшил. Тэгээд тэр болж бүтэхгүй байгаа юмыг нь

хэлэлцүүлгийн явцдаа засаад яв. Засаад яв. Мэдээж бас ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар.

Ер нь энэ Зүүн Хойд Азийн бүс нутагт төдийгүй, Азийн хэмжээнд хүнсний чанар, аюулгүй байдлын асуудал чухлаар тавигдаж байгаа.

Манай урд хөрш Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дундаж давхарга 300 саяад хүрч, чанартай хүнс, органик хүнсний эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа.

Монгол Улсын онгон дагшин байгаль, газар зүйн нөхцөл байдал энэ органик хүнсний экспортлогч улс болох бүрэн боломжийг бий болгож байгаа. Дэлхий нийтийн чиг хандлага тийшээ явж байна.

Тийм учраас энэ хууль чухал. Тэгээд дотор нь байгаа асуудлуудыг хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа ажлын хэсэг байгуулаад хэлэлцээд явж болох бололцоотой гэж бодож байгаа юм.

Ингээд Байнгын хорооны саналаар Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай.

Хоёрт нь, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

Гуравт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах

тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

28 гишүүн дэмжиж, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна.

Ингээд өнөөдрийн үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан завсарлаж байна.

ЗАВСАРЛАГА

Зургаа.Ерөнхий сайдын мэдээлэл: Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар, стандартыг сайжруулах талаар

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар стандартыг сайжруулах талаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Мэдээллийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Жамьянхорлоогийн Сүхбаатар хийнэ.

Ж.Сүхбаатар сайдыг индэрт урьж байна.

Ж.Сүхбаатар: Монгол Улсын Ерөнхий сайдаас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын нэгдсэн мэдээллийг Та бүхэнд миний бие төлөөлөн хийе.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааны Засгийн газрын цагаар нээлттэй сонсголоор Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болон нийслэл Улаанбаатар хотын зүгээс хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний нэгдсэн мэдээллийг Та бүхэнд танилцуулъя.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийн

өнөөгийн байдал ба Засгийн газраас баримталж буй бодлого, чиглэл.

Дэлхийн хотуудын хувьд авто замын түгжрэл томоохон сорилт болж байдаг. Авто замын түгжрэл нь үүсэж буй шалтгаан нөхцөлөөсөө үл хамааран нийгмийн хөдөлмөрийн бүтээмж ба иргэдийн амьдралын чанарыг дордуулж хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж байдаг ийм сөрөг үр дагавартай.

Улаанбаатар хотын авто замын сүлжээний урт сүүлийн 10 жилийн хугацаанд 954 километрээс 1136 километр болж 19 хувиар нэмэгдсэн бол тээврийн хэрэгслийн тоо 234.2 мянгаас 624.8 мянга болж 2.4 дахин нэмэгдээд байна.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөнд 570 орчим мянган машин оролцож байгаа нь улсын хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 80 орчим хувь бөгөөд оргил цагийн ачааллын үед авто тээврийн хэрэгслийн дундаж хурд нь 8.9-өөс 10.8 километр цаг байна.

Эндээс үзэхэд 2030 онд 5 километр цаг, 2040 онд дээд цэгтээ хүрч бүтэн өдрөөр түгжрэх нөхцөл үүснэ гэсэн урьдчилсан судалгааг Олон улсын ЖАЙКА байгууллагаас гаргаад байна.

Нийслэлчүүдийн өмнө тулгамдаж буй авто замын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн үндсэн дээр түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулахад Монгол Улсын Засгийн газар онцгойлон анхаарч нэгдсэн нэг бодлогын доор үйл ажиллагаагаа явуулан цаг алдалгүй үр дүн гаргах зорилгоор 2022 оны 341 дүгээр тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын авто замыг түгжрэлийг бууруулах Үндэсний хороог байгуулсан.

Мөн Засгийн газрын 2021 оны 146 дугаар тогтоолыг батлан нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээнд жил бүр 420 тэрбум төгрөгөөс доошгүй санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2024 оны улсын төсөвт тусган үе шаттайгаар хэрэгжүүлэхийг шийдвэрлээд байна.

Үүнтэй холбоотой Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2021 оны 180 дугаар тогтоол батлан Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн Засгийн газрын хэлэлцээр, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах болон улс, нийслэлийн төсвийн санхүүжилттэй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулан ажиллаж байна.

Хоёр.Хот, хөдөөгийн сэргэлт.

Өнөөдрийн байдлаар манай улс нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд нэгдүгээрт ордог.

Гэтэл Монгол Улсын газар нутгийн 0.3 хувьд нь байршдаг Улаанбаатар хотод нийт хүн амын 47.6 хувь амьдардаг.

Улаанбаатар хотод их дээд сургуулиудын 90, худалдаа үйлчилгээний 84.2 нийт хадгаламжийн 76.5, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 70.4 хувь нь төвлөрч байна.

Монгол Улсын төсөвт орлого оруулдаг 6 аймаг байгаа бол төсвөөс дэмжлэг авдаг 15 аймаг байна.

Шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтуудын нэг болох Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Улаанбаатар хотоос орон нутгийн шилжин суурьшигчдын амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх төрийн бодлогоор бодитой дэмжих төлөвлөлтийг Засгийн газар хэрэгжүүлэхээр шийдвэр тогтоолоо гаргаж бэлтгэл зохион байгуулалтаа хангаад байна.

2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 419 дүгээр тогтоол, 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Хот, хөдөөгийн сэргэлтийн тухай авах зарим арга хэмжээний тухай гэсэн хоёр томоохон тогтоолыг Засгийн газар гаргасан.

Дээрх тогтоолуудад тусгагдсан Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, алслагдсан дүүрэг, Багануур, Багахангай анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг эхлүүлэхээр бэлтгэл ажил хангагдаад байна.

Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих 1 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд Засгийн газар хариуцан төлөх хүүгийн дотацийн хэмжээг арилжааны банкуудтай хэлэлцээрийн замаар санхүүжилтийн гэрээ байгуулж үйл ажиллагааг нь эрчимжүүлэхээр ажиллаж байгаа.

Мөн татан буугдсан мэргэжлийн хяналтын байгууллагын эзэмшлийн зарим аймаг дахь газрыг орон нутагт

шилжин суурьшсан иргэдэд зориулан орон сууцын барилга барих, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зориулалттай шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эхлүүлээд байна.

Шинээр үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн бус аж ахуйн нэгжүүдэд татварын дэмжлэг үзүүлнэ.

Дулаан цахилгаан үйлдүүлсэн төслүүдэд орлого олж эхэлсний дараачаас эхний 3 жил нь 90 хувь, дараагийн 3 жил 50 хувь чөлөөлөх зэрэг боломжийг Засгийн газар хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Гурав.2022-2023 онд хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлт, үр дүн.

Улаанбаатар хотыг олон төвд хотын загварт шилжүүлэх хөгжүүлэх бодлоготой уялдуулан авто замын түгжрэл болон нийтийн тээвэрт тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, олон төрөлт нийтийн тээврийг хөгжүүлэх зорилгоор 2022 онд авто зам, нийтийн тээвэр, хот байгуулалт, зам тээврийн хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр 12 багц арга хэмжээг төлөвлөсөн.

Эдгээр төсөл, арга хэмжээ 837 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 96 хувь нь буюу 803.5 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

2022 онд санхүүжүүлэхээр төсөвлөгдсөн 411.8 тэрбум төгрөгөөс 65 хувь буюу 269.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Үүнээс 33.0 хувь буюу 138.3 тэрбум төгрөгийг он дамжуулан санхүүжүүлэх болно.

2023 оны хувьд нийслэлийн төсвөөс Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх, нийтийн тээврийн парк шинэчлэл, явган болон дугуйн зарим хэсгийг санхүүжүүлэхээр 15.1 тэрбум төгрөг, гол гудамж, замын бүтээн байгуулалтад 29.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн яваа.

Улсын төсвийн тухайд нийт 408 тэрбум төгрөгийг нийслэл Улаанбаатар хотын авто замыг түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын багцад тусган баталсан байгаа.

Дөрөв.Авто замын сүлжээг өргөтгөх шинэчлэх чиглэлээр.

Нийслэл Улаанбаатар хотод авто зам шинээр барих, өргөтгөх, шинэчлэх ажлыг нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх, дунд, урт хугацааны мастер төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу авто замын түгжрэлийг бууруулахад үзүүлэх нөлөөллөөр эрэмбэлэх оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ хүрээнд 2022-2023 онд нийт 11 байршилд 16.45 километр авто зам, 963.7 метр урттай гүүр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэнээр 2024 онд хоногт нийт 184 мянга 910 машин нэвтэрч автомашины түгжрэл 9 хувиар бууруулахаар тооцсон.

Авто замын сүлжээг өргөтгөх, шинэчлэх чиглэлээр гадаадын зээл тусламжийн хүрээнд хэрэгжүүлж эхлээд байгаа 2 төсөл байна. Үүнд:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 1 тэрбум

ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Улаанбаатар хотын төмөр зам дагуух авто замын нүхэн гарц барих төслийг эхлүүлж Сонгинохайрхан дүүрэг, 5 шарын төмөр замын гармаас Баянгол дүүрэг, Нарны зам болон Их хүрээний гудамжны уулзвар хүртэл төмөр зам дагуу 4 байршилд нүхэн гарц барихаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зураг төслийг боловсруулж байна.

2023 оны 4 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг улсын экспертизээр батлуулахаар ажиллаж байна.

Төслийг хэрэгжүүлснээр нүхэн гарцуудын уулзвар дээр хөдөлгөөний нэвтрүүлэх чадвар 20-иос 40 хувь болж гэрлэн дээрх тээврийн хэрэгслийн хүлээлтийн хугацаа 25 хувиар буурна.

2.Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар “Нийслэл Улаанбаатар хотод тогтвортой авто зам тээвэр нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар хотын тогтвортой зам, тээврийн урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулахаас гадна оновчтой төлөвлөлт, авто зогсоолын болон замын хөдөлгөөний удирдлагын ухаалаг систем бүхий иж бүрэн гудамж, замыг байгуулахаар ажиллаж байна.

Төслийн дүнд Улаанбаатар хотын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гудамж, замын одоо байгаа сүлжээг засварлах, шинэчлэх, шинээр авто зам барих Замын хөдөлгөөний удирдлагын төвийг шинэчилж нэгдсэн систем бий болгох юм.

Эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэн дэмжсэн **“Шинэ тойрог**

зам” төслийн хүрээнд нэг төвт хотоос олон төвт хотыг хөгжүүлэх эхлэл буюу хот тойрсон авто замын хөдөлгөөнийг 2 жилийн хугацаанд бий болгохоор төлөвлөсөн.

Хотын хойд хэсэгт 42.4 километр, урд хэсэгт 33 километр, босоо чиглэлд 17.3 километр, нийт 93 километр тойрог замыг үүсгэснээр хотын гол замуудын ачааллыг 20-иос 30 хувиар бууруулахаар тооцож байгаа.

Мөн хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой “Сэлбэ сэргэлт” төсөл судалгааны шатдаа орж зураг төсөв нь боловсруулагдаж байгаа.

Урьдчилсан тооцооллоор Сэлбэ, Дунд голын дагуу шинээр 21.6 километр авто зам, түүнийг дагасан 18 туслах гүүр, 4 гүүр гүүрэн байгууламж, 9 нүхэн гарц, 42.3 километр явган болон унадаг дугуйн зам, 68 нийтийн тээврийн зогсоол бүхий тусгай замын нийтийн тээврийн чиглэлийг үүсгэнэ.

Үүний үр дүнд авто замын идэвхгүй бүс болох 63 уулзвар гарцыг хөдөлгөөн эрчимжиж гол замын ачааллыг хуваалцах юм.

Тав.Олон төрөлт нийтийн тээврийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр.

Нийслэлийн нийтийн тээвэрт 2009 оноос хойш дорвитой парк шинэчлэл хийгдээгүй бөгөөд парк шинэчлэлт 1400 орчим нийтийн тээвэр шаардлагатай байгаа гэсэн тооцоо, судалгаа гараад байгаа.

Өнөөдрийн байдлаар өдөр тутам 500 гаруй мянган иргэнд нийт 107 чиглэлээр 996 автобус үйлчилж байгаа ч

энэ автобуснуудын 68 хувь нь 10-аас дээш жилийн насжилттай байна.

Улаанбаатар хотын нийтийн тээврийн салбарыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах нь эн тэргүүний асуудал бөгөөд түгжрэлийн эсрэг авах арга хэмжээний суурь нөхцөл гэж үзэж байгаа юм.

Тиймээс 2023 онд нийтийн тээврийн парк шинэчлэлтийг 80 хувьд хүргэж 2024 он гэхэд 100 хувьд хүргэх зорилт тавьж, их багтаамжийн евро-5 стандартын шаардлага хангасан 600 автобус, дунд багтаамжийн 50 автобус, цахилгаан хөдөлгүүртэй 160 автобус худалдан авахаар төлөвлөсөн.

Монгол Улсын сайд бөгөөд Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын багцад энэ онд нийтийн тээврийн парк шинэчлэлтэд 272.0 тэрбум төгрөгийг батлаад байна.

Одоогоор автобус худалдан авах гэрээний хүрээнд энэ оны 6 дугаар сараас эхний ээлжийн автобусыг оруулж ирэхээр төлөвлөөд байна.

Мөн нийтийн тээврийн авто паркийн барилгыг Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт барьж байгуулах ажил эхлүүлээд байгаа.

2024 онд нийтийн тээврийн парк шинэчлэлтийг 100 хувьд хүргэж, насжилт ихтэй автобусыг ашиглалтаас гарган урсгал зардал болон агаар орчны бохирдлыг бууруулахаас гадна 150 автобусны багтаамжтай гадна зогсоол, 220 автобусны багтаамжтай дулаан зогсоол, иж бүрэн сервис үйлчилгээний сувгийг хамт ашиглалтад оруулж, нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг

шинэ шатад гаргаж иргэдэд ая тухтай зорчих боломжийг бүрдүүлэх юм.

Нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад зээл, тусламжийн хүрээнд эхлүүлж байгаа 2 төсөл байна. Үүнд:

1. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийг эхлүүлж, 2 дугаар шугам болох Яармаг, Шинэ хотын захиргаанаас Хархорин автобусны буудал хүртэлх 4.2 километр дүүжин замыг 2024 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Төслийг хэрэгжүүлснээр 2024 онд нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотын дэд төвүүдийг хооронд нь холбох, авто замын түгжрэлийг бууруулах, агаарын бохирдлыг багасгах, аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ гэж тооцоолж байна

2. Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл нь Чингэлтэй дүүргийн 17, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрийг дамнасан Чингэлтэйн замын 5.1 километр коридорт хэрэгжиж байна.

Төслийн үр дүнд 2024 онд Чингэлтэйн замын чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ сайжирч, хүртээмжтэй төлөвлөлтийн зарчим болон хүрээлэн буй орчны онцлогт нийцсэн аюулгүй, хүртээмжтэй автобусны зогсоол, явган зорчигчийн жишиг загвар бий болно.

Эдгээрээс гадна Засгийн газраас төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэн дэмжсэн Улаанбаатар хотын нийтийн тээврийн

үйлчилгээнд тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэгний үйлчилгээг нэвтрүүлж, нэгдүгээр шугам буюу Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооноос Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо хүртэл нийт 15 буудалтайгаар ТЭЗҮ боловсруулж, төслийн суурь судалгаа хийсэн байгаа.

Мөн нийслэлийн нийтийн тээвэр тусгай замын их багтаамжийн автобусыг нэвтрүүлэх төсөл судалгааны шатдаа байна.

Урьдчилсан тооцооллоор Энхтайваны өргөн чөлөө дагуу Толгойтоос Амгалангийн автобусны буудал хүртэлх авто замыг ашиглан тусгай эгнээгээр их багтаамжийн автобусыг нэвтрүүлснээр нийтийн тээврийн зорчих хурд нэмэгдэж, нарийвчилсан цагийн хуваарийн дагуу шуурхай үйлчилгээ үзүүлдэг нийтийн тээврийн төрлийг бий болгох юм.

Зургаа.Хот байгуулалтын чиглэлээр.

Нийслэл Улаанбаатар хотод өдөрт 2.9 сая зорчилт хөдөлгөөн хийгдэж байгаагаас 50 хувь нь ажилдаа ирж очих, 30 хувь нь хүүхэд сургууль, цэцэрлэгт автомашинаар хүргэж өгөх, 20 хувь нь бусад зорилготой зорчилт хөдөлгөөн байна гэсэн судалгаа байдаг.

Иймд хамран сурах тойргийн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төвийн бус сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулах замаар нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлэхийг зорьж байна.

2022-2023 онд нийслэл Улаанбаатар хотын авто замын

түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний хүрээнд сургуулийн 7 барилга, цэцэрлэгийн 11 барилга, бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын 9 барилгын ажлыг хэрэгжүүлнэ.

Ийнхүү сургуулийн хүртээмжийг 5780 суудлаар, цэцэрлэгийн хүртээмжийг 3455 ороор өсгөж, хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлснээр авто замын хөдөлгөөнийг 20-иос 30 хувь бууруулах боломжтой гэсэн судалгаа бий.

Мөн хотын төвийн авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор хотын төвийн 6 дүүрэгт 28 боломжит байршлыг тодорхойлж, эхний ээлжид Сүхбаатар дүүргийн 2 болон 7 дугаар хороонд нийт 468 машины багтаамжтай ухаалаг системээр тоногдсон их багтаамжийн авто зогсоолыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн журмаар барьж байгуулахаар судалгаа тооцооллыг гаргасан.

Үүний дүнд ойролцоогоор замын ачаалал 20-иос 30 хувь буурах юм.

Үүнээс гадна иргэдийн ая тухтай орчинд алхах, дугуйгаараа зорчих хэвшлийг дэмжих зорилгоор Бага тойруу бүсэд явган замыг өргөтгөн ногоон байгууламжийн хамт тохижуулах, нийтийн нийтийн эзэмшлийн талбайгаас гараж, хайс, хашлагыг буулган явган болон дугуйн замыг нэмэгдүүлэх зэргээр ажиллаж байна.

Онцолбол энэ онд Энхтайваны өргөн чөлөөгөөс Маршалын гүүр хүртэлх гүүрэн байгууламж болон дугуйн замыг төлөвлөж байна.

Нийт гүүрэн байгууламжийн урт 1.68 километр, нэг түвшний дугуйн зам

3.19 километр замыг өргөтгөн 31.8 тэрбум төгрөгөөр байгуулахаар байгаа.

Системд динамик загварчлалын тооцооллоор Чингисийн өргөн чөлөө болон Их Монгол Улсын гудамжны замын хөдөлгөөнөөс 5675 автомашин, 34 мянга 270 зорчилт хасагдаж, хотын дундаж хурд 11.2 километр хүрч нэмэгдсэнээр түгжрэл 3 хувиар буурахаар тооцоолж байна.

Долоо.Зам, тээврийн хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр.

Зам тээврийн ухаалаг системийг нэвтрүүлж, технологийн тусламжтайгаар авто зам, тээврийн хэрэгслийн бодит мэдээллийг боловсруулж, өгөгдөл дээр суурилсан тооцоо, судалгаа хийх, бодит цаг хугацааны тандалт дээр суурилж замын хөдөлгөөнийг удирдах зохицуулах боломжийг бий болгох, авто замын сүлжээний ачааллыг бууруулах ажлын нэгдүгээр үе шатыг амжилттай хэрэгжүүлсэн.

2023-2024 онд 2 дугаар үе шатыг хэрэгжүүлснээр тээврийн хэрэгслийн бодит цагийн нэгдсэн дата цуглаж, авто зам болон тээврийн зохицуулалтыг хийнэ.

Гэрлэн дохиогоор тоноглогдсон уулзваруудад бодит цаг хугацааны тандалт хийж, замын хөдөлгөөнийг удирдах, зохицуулах боломжтой болно.

Мөн замын хөдөлгөөний хяналтыг 40 хувиар сайжруулж, авто замын хөдөлгөөний ачааллыг 20 хүртэл хувиар бууруулна.

Ухаалаг авто зогсоол, цахим төлбөр тооцооны систем нэвтэрч, иргэдийн цагийг хэмнэх юм.

Шалган нэвтрүүлэх товчоод явуулын хяналтын цагдаагийн машинууд хоорондоо ухаалаг терминалуудаар холбогдож, мэдээллийг шуурхай солилцох боломж бүрдэнэ.

Мөн хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр Зайсан тойрууг нэг чигийн болгох, Олимпын гүүрний ойролцоох хөдөлгөөнийг буцаж эргэх зэрэг зохион байгуулалтыг үе шаттай хэрэгжүүлсэн.

Үр дүн эхнээсээ гарч байгаа. Цаашид ч бид хотын төв хэсгийн бусад хэсэгт үүнийг хийж хэрэгжүүлэх болно.

Найм.Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төрийн оролцоог хангах чиглэлээр.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, иргэд, олон нийтэд авто замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах арга зам, шийдлийн талаар сурталчлан таниулах, иргэн аж ахуйн нэгжийн оролцоог хангах, дэмжих бодлогыг баримталж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар хуралдааны тэмдэглэлээр нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулахтай холбогдуулан хуулийн төсөл боловсруулахыг үүрэг болгосон.

Авто замын хэт ач ачаалалтай бүсийг бий болгох, түүнд төлбөр ноогдуулах, энэхүү төлбөрийг Нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлэх ерөнхий зарчмын дагуу төслийг бэлтгэн Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэлээ ханган ажиллаж байна.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад төрийн байгууллага болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог хангах зорилгоор Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны 2022 оны 01 дүгээр зөвлөмжийг баталсан.

Энэхүү хүрээнд зөвлөмжийн биелэлтийг сар бүр нэгтгэн олон нийтэд мэдээлж, авто замын түгжрэлийг бууруулах идэвх санаачилга, оролцоог дэмжин сурталчлан ажиллана.

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэмд заасан хүн ам, барилгажилтын тооцоо, нягтралын хязгаарыг давсан байршилд зөвшөөрөл олгосон барилгын ажлын хуульд заасан норм шаардлага, стандартыг хангуулах, шинээр баригдах хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль төлөвлөх, барьж ашиглалтад оруулах.

Түгжрэлийг сааруулахад шаардагдах өөрчлөлтүүдийг тусган хэрэгжүүлэх Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэмд заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршлуудыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Ес.Дүгнэлт.

Өнөөдрийн байдлаар иргэд нийслэлийн авто замын түгжрэлд өдөрт дунджаар 2.5 цаг, жилд 35 өдрийг өнгөрүүлдэг.

Энэ алдаж байгаа боломжуудын нийт өртөг нь 2.7 их наяд төгрөг байгааг

олон улсын мэргэжлийн байгууллага судлан тогтоосон.

Энэ алдагдсан боломжийн өртгийг бууруулахын тулд нийслэл 2022 онд Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулахад гол нөлөө үзүүлэх суурь судалгаануудаа хийсэн.

Авто замын сүлжээг нэмэгдүүлэх, зорчилтын бөөгнөрлийг задлах боломжуудыг тодорхойлсон байгаа.

Мөн гэр хорооллын бүсэд сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургууль дагасан зорчилт хөдөлгөөнийг бууруулах хувилбаруудыг тооцон гаргасан.

Түүнчлэн Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гэр хорооллын бүсэд амьдарч байгаа нийтийн тээврийн хүртээмжгүй 425 мянган хүн амд зориулан жижиг, дунд оврын автобус явуулах. Мөн автобусны дундаж хурдыг нэмэгдүүлэх үүднээс Чингисийн өргөн чөлөө, Наадамчдын өргөн чөлөөний нэгдүгээр эгнээг үе шаттай чөлөөлөх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах хүрээнд илүү оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж байгаа. Тухайлах юм бол Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр бид хууль эрх зүйн орчин боловсронгуй болгон 2023-2024 онд төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр авто замын түгжрэл 50 хүртэл хувиар буурах боломжтой гэж дүгнэж үзэж байгаа.

Товчоор нэгтгээд хэлэх юм бол нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг 50 хүртэл хувиар бууруулах зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх

ажлын 18-аас 20 хувь нь 2022 онд амжилттай гүйцэтгэсэн гэж ингэж үзэж байгаа.

Энэ нь 2023-2024 онд нийт хийгдэх ажлын суурь дэвсгэр болж байгаа тул 2023 онд 60 хувь, 2024 онд үлдсэн 20 хувийн гүйцэтгэл хийснээр Нийслэл хотын түгжрэлийг дурдсан хувиар бууруулна гэж үзэж байгаа юм.

Улс орон том хотуудын эдийн засгийн хөгжлийн хурд нь авто замын хөдөлгөөний хурдаас хамааралтай гэж үздэг.

Түүнчлэн дэлхийн эдийн засагчид хотын авто замын түгжрэлийг эдийн засгийн өсөлт, тэлэлттэй шууд холбон авч үздэг байна.

Иймд Засгийн газраас нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлын явц, үр дүнтэй долоо хоног болгон танилцаж, шаардлагатай шийдвэрүүдийг цаг алдалгүй авч байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Мэдээлэлтэй холбогдуулж Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн бүлгийн гишүүд нэрээ өгнө үү.

Мэдээлэлтэй холбогдуулж цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Монгол Улсын Их Хурлын дарга аа, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд асуудал, бэрхшээлээр дүүрэн, ахиц шийдлээр дутмаг ээлжит нэгэн мэдээллийг хийж байна.

Хүн амын талаас илүү хувь нь оршин суудаг нийслэл Улаанбаатар хотод авто замын түгжрэлийн асуудал гамшгийн хэмжээнд хүрч, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрх нь зөрчигдсөөр олон жилийн нүүр үзэж байна.

Үүний буруутан нь хэн бэ гэдгийг Монголчууд бүгдээрээ л мэдэх тул улс төржилгүйгээр гол асуудал руугаа орёе.

Түгжрэл улс төржсөн шийдвэрүүд, намчирхсан томилгоонууд, авлигажсан газар олголтуудын төлөөс, тэдгээрийн толин тусгал нь юм.

Бид алт, зэс, нүүрсээ ухаж, багахан валют олдог. Олсон орлогынхоо ихэнхийг машин, сэлбэг, шатахуун авахад зарцуулдаг.

Хүн ам, эдийн засгийн 60 хувь нь нэг хотдоо ингээд төвлөрсөн ийм л бүтэцтэй нэг улс.

Япон машиндаа Орос бензин дүүргээд хотын гудамжиндаа бөглөрч, шатахуун болсон доллароор бүгдээрээ шатаацгаана.

Үр дүнд нь нийтээрээ стресстсэн, хорт хавдраараа тэргүүлдэг жагсаалтууд ингээд цааш цааш нэмэгдсээр. Өдөр бүр 3 цагийг бүгдээрээ түгжрэлд үрж байна.

Энэ бол хүүхдийн хүмүүжил, боловсролдоо анхаарах аав ээжийн алтан 3 цаг, зам дээр яваа галын, түргэний, онцгойгийн машины хувьд хүний амиар хэмжигдэхүүнтэй цаг, минут аа.

Асуудлыг цогцоор харж, арга хэмжээ авч, томоохон өөрчлөлт хийхгүй бол гал унтраах байдлаар зам өргөтгөөд, автобус шинэчлээд, аль эсвэл захиргааны арга хэмжээг аваад түгжрэл буурахгүй нь тодорхой харагдаж байна.

Оношоо зөв олж, суурь шалтгаан, нөхцөлийг нь өөрчлөхөөс шийдлүүд гарах ёстой.

Түгжрэлийн шийдэл бол зөвхөн автобус, нийтийн тээврийн асуудал биш олон олон бодлогуудын огтлолцол дээрээс гарна.

Монгол Улсын хүн ам зүйн нутагшил, байршил суурьшлын бодлого, татварын, тэр тусмаа онцгой татвар, импортын татвар, гаалийн татваруудын бодлого, хотжилт, соёлын өөрчлөлт, төлбөрийн системүүдийн шийдэл зэргээс хамаарах асуудлыг цогцоогоор харж байж шийдэл гарна.

Улаанбаатар хот ямар хот байх вэ. Суурьшил хотхон, хороолол, гудамжнууд нь хаана хаанаа яаж төвлөн хөгжих вэ.

Түүнийх нь ажлууд залууст ямар ажлын байр бий болж, хэдэн алхмын цаана сургууль, цэцэрлэг байх вэ гэх мэт хот төлөвлөлтийн бодлогоо гаргаж чанд мөрдөхөөс нутагшил суурьшлын бодлого, төлөвлөлтдөө суулгаж, энэ бүгд хот төлөвлөлтийн баримт бичгээ зөв гаргаж, чанд мөрдөхөөс л эхлэх ёстой.

Хатуу дэд бүтцийн дутагдлаас л болж түгжрэл их ихсэж байгаа мэтээр Та

бүхэн сурталчилж мөнгө, төсөв нэмэхийг, шийдэхийг цаг ямагт нэхдэг.

Материалист үүднээс асуудлыг харалгүйгээр иргэдийн оюун санаа руу хандсан шийдлүүд одоо хэвшил болон тогтсон дугаарын хязгаарлалт, нийтийн тээврийн эгнээ байрын зорчилт гэх мэт оновчтой зохицуулалт, зан үйл, соёл амьдралын хэв маягийн өөрчлөлт гэх зэрэг зөөлөн софт гэж хэлдэг зөөлөн дэд бүтцийн асуудлуудад бага анхаарч олон алдаа гаргаж байна.

Олсон багахан орлого, олдсон боломж, цаг хугацаагаа цементэн зам дээр стресс бухимдлаар чимэглэн дэмий түгжрэлд хүрэхгүй байхыг нийт монголчууд хүсэж байгааг энд уламжилъя.

Хотжилт эргэлт буцалтгүй процесс. 100 жилийн өмнө дэлхийн хүн амын 30 хүрэхгүй хувь нь хотод суурьшин амьдарч байсан бол энэ тоо өнөөдөр 60 гаруй хувьд хүрчхэж. 2 дахин нэмэгдэж.

Манайхаас хэд дахин том 10, 20 сая хүн амтай мега хотууд ч хотжих процессыг, түгжрэх аюулыг аль алиныг нь туулаад зөв бодлого барьсан учраас даваад гарчээ.

Мэдээж зарим улс орон нь түгжрэлтэйгээ байлдаж л байгаа. Гэхдээ тэдгээрийн түгжрэл ихэнх нь хөгжлийн түгжрэл байгаа болохоос биш манайх шиг ийм хоцрогдлын түгжрэл биш ээ.

Эрх баригч Та бүхэн Замын цагдаагийн газрын хажуугийн ганцхан гүүрийг 46 сая доллар буюу 160-аад тэрбум төгрөгөөр барьсан бол өмнөх засгийн үед яг ийм дүнтэй мөнгөөр төмөр замын 11 нүхэн гарц гарахаар жишээ нь төлөвлөж байжээ.

Тэр цагт мөн тэг зогсож, таг гацсан хотын замд автомашиныг хурдлах олон цогц шилүүдийг гарган хэрэгжүүлж, ганцхан жилийн дотор 50 тэрбум төгрөгөөр 20 уулзварыг өөрчлөн сайжруулж байж.

Улам бүр удаашран буй түгжрэлийн эсрэг бодитой үр дүнд хүрч болохуйц ганц ажил нь гагц тэр үед бас олон олон шийдлүүд, тэр тусмаа тийм зөөлөн маягийн шийдлүүд гарч байсныг сануулья.

Түгжрэлийн хороо, Түгжрэлийн сайд гэх мэтээр албан тушаал нэмэгдэж, улс нийслэлээс жил бүхэн хагас их наядын мөнгө зарлагадаж буй ч ахиц гардаггүй, асуудал нь улам бүр хуримтлагдан буй нөхцөл байдалтай дүгнэлт хийж түгжрэлийн асуудалд түлхэц болохуйц шийдлүүдийг гарган үр дүнтэй ажиллахыг эрх баригчид Та бүхнээс хичээнгүйлэн хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо асуулт, хариултдаа орно.

Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хоёр хамт явж байгаа.

Б.Бейсен: Энэ нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмж, чанар, стандартыг сайжруулах талаар мэдээллийг сонслоо. Хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор одоо Яармагийн шинэ хотын захиргаанаас Хархорин автобусны буудал

хүртэл 4.2 километр дүүжин зам барина гэж байна.

Энэ 4.2 километрт хэдэн дүүжин кабин явуулах вэ? Нэг дүүжин кабинд чинь одоо хэдэн хүний багтаамжтай юм? Энэ чиглэлийн ачаалал хэдэн хувиар буурна гэж тооцож байна вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нийтийн тээврийн хүртээмжийн талаар ярихад автобусны тоо нэмэх, автобус баазыг сайжруулах талаар яригддаг.

Метроны талаар ерөөсөө яригддаггүй.

Нөгөө талаар гүүрэн гарцууд байна шүү дээ. Зөрлөгүүд дээр. 4 зам ч юм уу, баруун, зүүн 4 зам. Тэр талаар огт яригдахгүй байна.

Ядахдаа Улаанбаатарын хоёр чиглэлээр нэмэх хэлбэрээр уртаашаа, өргөнөөрөө метро барих талаар яригдсан уу? Одоо Хятадаас их хэмжээний зээл мөнгөн хэлбэрээр аваад түүгээрээ яахын оронд метро барьж болдоггүй юм уу? Энэ талаар бодож байгаа, бодолцож байгаа санал бодол байна уу? Энэ талаар асууя.

Г.Занданшатар:

Жамьянхорлоогийн Сүхбаатар сайд хариулна.

Ж.Сүхбаатар: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Дүүжин тээврийн тухайд энэ бас сүүлийн хоёр, гурван жил энэ асуудал маань жоохон тийм зогссон байдалтай. Өмнө нь Нийслэлийн Засаг дарга Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан дарга байх үедээ энэ асуудлыг ярьж, хэлж эхлүүлж байсан.

Тэгээд төслийн талаар олон нийтийн дунд эргэлзээ, шүүмжлэл гараад. Дээр нь манай хотын удирдлага, Сангийн яаман дээр КОВИД-ын үе ч таарсан байсан.

Тэгээд энэ дээр бас энэ төслийн асуудал эцэслэн шийдэгдэхгүй явж байсан.

Би сайдаар томилогдсон 9 сараасаа эхлээд нийтийн тээврийн дүүжин замын тээврийн төслийг тэр зогсчихсон байгаа ажлыг гүйцээж явуулья гээд одоо барьж авсан.

Ер нь манай Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ юу хэлж байгаа вэ гэхээр зэрэг олон улсын байгууллагатай тохирсон гэрээ, хэлцэл, тэр зүйлүүдээ ёсоор нь гүйцэтгэж байх ёстой. “За гэсэн бол ёогүй” ингээд хийдэг л байх ёстой.

Хулхиддаг, худлаа хэлдэг, гацаадаг энэ байдлаар ажил явахгүй гэдэг ийм зарчим баримталж байгаа юм.

Би ч гэсэн энэ нийтийн тээврийн дүүжин замын тээврийг хөгжүүлэх төсөл манай түгжрэлийг бууруулахад стратегийн хувьд ач холбогдолтой.

Бид зөвхөн нэг автобус, метро гэж биш бүх чиглэлээр энэ нийт тээврийн хэрэгслийг, төслүүдийг дэмжих, явуулах шаардлагатай.

Дэлхий хотууд одоо ч гэсэн явж байгаа түгжрэлтэй бүгд л тэмцэж л байна л даа.

Ер нь түгжрэл гэдэг гадаадын орнуудын дийлэнхэд нь энэ эерэг хандлагаараа эдийн засгийн өсөлт, хотын хүн амын өсөлттэй холбоотой авч үздэг. Манайд газрын наймаа ч гэдэг юм уу, хот

төлөвлөлт нэгдсэн бодлогогүй явж ирсэн гэдэг сөрөг талаасаа үр дагавар нь илүү байгаа.

Ер нь том хотууд томрохынхоо хэрээр л зовлон, түгжрэлийн индекс нь нэмэгдэж байгаа.

Тэгэхээр дүүжин замын тээврийн асуудал дээр бид ямар ч байсан энэ үл итгэх байдлыг алга болгох, хамгийн боломжтой шугам буюу 2 дугаар шугам гэсэн энэ шугамыг сонгож аваад тэгээд ирэх онд ашиглалтад оруулна гэдэг тохиролцоо хийсэн.

Өчигдөр би жишээлбэл үүнийг гүйцэтгэгч Францын “ПОМА” /Pomagalski S.A./ компанийн Ерөнхийлөгчтэй уулзсан. Францын талтай удаа дараа энэ асуудал яригдсан. Одоо саатахгүйгээр энэ төслийг хэрэгжүүлнэ гэж үзэж байгаа.

Энэ бол цагт 1200-аас 1500 хүн тээвэрлэнэ гэсэн ийм тооцоотой. Зарим тохиолдолд манайхан 2000 ч гэдэг.

Тэгээд энэ дотроо халдаг ийм суудалтай. Дотроо энэ чинь 15-аас 20 хүн байх аа. Гийм ээ. 15-аас 20 хүн. Энэ ердийн нөгөө аялал жуулчлалын зориулалттай яг хольж хутгах юм байхгүй.

Нийтийн тээврийн хэрэгслийн нөхцөлөөр одоо ингээд ажиллах боломжтой. Францын технологи. Өвлийн хүйтэн. Энэ нөхцөл байдлуудыг нь тооцсон ийм асуудал байгаа юм.

Тэгээд энэ ч гэсэн нэг тэр дүүжин тээврийн кабинаар явах бол 35 автобусаар явах хэмжээний агаарын бохирдлыг багасгах ийм л тооцоололтой байгаа шүү дээ.

Тэр хоёрдугаар асуудалд, метроны асуудлаар 10-аад жилийн өмнө ЖАЙКА-гийн хийсэн судалгаа, тооцоо байдаг юм билээ.

Ерөнхийдөө 1.5 миллиард доллар зарцуулагдана гэж яригддаг. Гэхдээ Энхтайваны өргөн чөлөө гэж авч үздэг юм билээ. Ер нь энэ ярьж байгаа улсууд.

Гэтэл яг одоо манай мэргэжлийн хүмүүс судалгаа, тооцоо хийгээд үзэхээр Энхтайваны өргөн чөлөөн доор шугам сүлжээ ойрхон. Тэрнээс бүүр гүнд хийнэ гэхээр зардал нэмэгдэх. Мөн ойр орчмын барилгажилтад эрсдэлтэй байдал байдаг гэж дүгнээд өөр хэлбэрүүдийг эхний ээлжид авч хэрэгжүүлэх санал тавьсан байдаг юм.

Манай Үндэсний хорооны тухайд метрог үгүйсгэх юм байхгүй байгаа. Би яг гаднын мэргэжилтнүүдтэй ярьсан.

Одоогийн 1.5 миллиард доллар гэдэг бол үндсэндээ одоогийн нөхцөлд бараг 3 тэрбум долларт очих ийм багцаалал бол тэгэх юм билээ.

Дээр нь тасралтгүй барилаа гэхэд 4 жилийн хугацаа шаардах юм билээ. Тэгэхээр метроны асуудал дээр бид... /минут дуусав/

Энэ цаг нь дуусаж байна. Үргэлжлүүлээд юу яачих уу?

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. Ж.Сүхбаатар сайд.

Ж.Сүхбаатар: Метроны асуудал дээр олон хүн асуудал тавьж байгаа.

Иргэдийн зүгээс, мэргэжилтнүүдийн зүгээс, улс төрчдийн зүгээс метротой больё гэдэг. Энэ бол сүүлийн 10 жил тасралтгүй яригдаж

байгаа ийм асуудал. Зүгээр бидний хувьд метрог хэрэгжүүлэх тухай бодлогыг одоо шууд авч хэрэгжүүлэхээсээ илүүтэй энэ яригдаад байгаа дүүжин тээвэр, нийтийн тээвэр эд нар.

Одоо манай нийтийн тээврийн салбар гэхэд түрүүн та асууж байсан. Нийтийн тээврийн салбар үндсэндээ уналтын хамгийн доод цэгтээ хүрчихсэн байгаа.

Тэгэхээр үүнийгээ эхлээд шийдэх талд нь анхаарахгүй бол хамгийн суурь болсон нийтийн тээврийн сүлжээ хөгжөөгүй байхад метроны асуудлыг шийдэх нь учир дутагдалтай юм билээ.

Гаднын мэргэжилтэн надад хэлсэн л дээ. Метро барьснаараа түгжрэл шууд буурна гэж ойлгож болохгүй. Яагаад гэвэл метроноос буугаад л таксидаад юм уу, одоо машинаар явах нөхцөл бүрдчих л юм бол энэ буруудна.

Тэгэхээр метро барилаа гэхэд юун түрүүнд нийтийн тээврийн маш сайн сүлжээтэй байх ёстой гэдэг ийм зүйлийг зөвлөж байгаа.

Тэгэхдээ метро гэдгийг бид уламжлалт ойлголтоороо бас хандаж болохгүй. Жишээлбэл, тэр LRT гээд байгаа чинь үндсэндээ бас л хөнгөн хэлбэрийн метротой. Зарим хэсэг нь газар доогуур яваад л, зарим хэсэг нь ил явдаг шүү дээ.

Тэгэхээр бид метро гэдгийг арай Монголынхоо нөхцөлд тохирсон хэлбэрээр авч хэрэгжүүлэх хэрэгтэй юм байна гэж.

Тэгээд хажуугаар нь BRT гэдэг төсөл байгаа. Тусгай эгнээний автобусны шугамын асуудал.

Үүнийг Азийн хөгжлийн банкны нэгэнт авна гэж тооцсон зээлийн хүрээнд BRT нь илүү хурдан хэрэгжихээр байгаа. Тусгай замаар.

Одоо “Сэлбэ сэргэлт” төслийн хүрээнд бид энэ замыг тооцож байна.

Мөн Энхтайваны өргөн чөлөө, бусад чиглэлд байж болох уу гэдэг энэ судалгаа, тооцооллууд нь одоо ид хийгдээд явж байна.

Тэгэхээр бид наана нь хийх ёстой юмнуудаа хийх.

Метро бол ер нь маш их зардал, хугацаа шаардсан, хүч шаардсан ажил байгаа. Гэхдээ үүнийг үгүйсгэхгүй байгаа. Манай зарим Их Хурлын гишүүд ч гэсэн надтай санал солилцож байгаа.

Оюу Толгой дээр хонгил манайхан чинь газрын гүнд ухаад 200 километр урт зам тавьчихсан байна.

Тэгэхээр ухах бол амархан байна шүү дээ гээд ингээд л ярьж л байгаа.

Тэгэхээр би өнөөдөр Үндэсний хороон дээр метроны чиглэлээр бид яг одоо тодорхой арга хэмжээ авъя гэдгээр биш. Харин Улаанбаатар хот дээр Нийслэлийн Засаг дарга бол сүүлийн үед харин энэ метроны чиглэлийн асуудал дээрээ ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа гэж би ойлгосон.

Ер нь энэ метроны асуудлын талаар цаашид бид цэгцтэй бас нэг байр сууриа илэрхийлье гэж бодож байгаа.

Гэхдээ энэ нь илүү улс төрчдийн амлалт, сайхан тийм төсөөллөөс илүүтэй мэргэжлийн хүмүүсийнхээ судалгаа, тооцоог яагаад аль үе шатад нь бид

метроны асуудлаа явах юм бэ гэдэг асуудлаа тодорхойлмоор байгаа.

Ер нь олон хүн энэ талаар ярилцаж байгаа учраас хэрэгцээ шаардлагыг ойлгож байгаа.

Улаанбаатар хот том хот болж байгаа учраас бидэнд метро хэрэгтэй болох нь гарцаагүй.

Метро ч хэрэгтэй, BRT нь ч хэрэгтэй, LRT нь ч хэрэгтэй. Тэгээд унадаг дугуй, явган хүний замаа ч нэмэгдүүлэх хэрэгтэй. Цаашдаа трамвайгаа ч авч үзэх хэрэгтэй гээд ингээд бүх төрлөөр нь хөгжүүлбэ гэдэг бодлого гарчихсан явж байгаа.

Метроны тухайд өнөөдрийн байдлаар ингэж л хэлье.

Хүмүүс намайг ч гэсэн ингээд хараад сууж байгаа байх. Метроны тухайд эсэргүүцээд байгаа зүйлгүй шүү. Энэ бол маш их хэмжээний хөрөнгө мөнгө шаардсан. Манай улсын төсвөөс давсан хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан.

Тэгээд маш их судалгаа, тооцооллыг дахиж нягтлах шаардлагатай ийм ажил байгаа учраас энэ дээр тэр утгаар нь хандаж байгаа болохоос биш метро бариулахгүй, барихгүй гээд яваад байгаа тийм бодлого байхгүй.

Г.Занданшатар: 83.

Ч.Батзориг: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах төслийн нэгж”-ийн захирал Ч.Батзориг.

Дүүжин тээврийн талаар 4.2 километр урттай, 2 үндсэн буудалтай. Нийтдээ эхний ээлжид 28 кабинтай. Кабинд нэг бүр нь 10 хүн суух хүчин чадалтай. 4 төрлийн кабин байна.

Цаашдаа 4.2 километр 86 ширхэг тулгуур байна. Тулгуур хоорондын зай нь 25-аас 70 метрийн өндөр урттай байна.

Ойролцоогоор 1.2-оос 1.5 мянган хүнийг цагт тээвэрлэх хүчин чадалтай.

Цаашдаа 73 кабинаар өргөтгөхөөр хүчин чадалтай хийгдэж байгаа. 2 дугаар байршлын хувьд.

Хоёр дахь асуудал нь, гүүрэн гарцын хувьд Улаанбаатар хотын 4 байршилд нүхэн гарцыг нийтдээ 27-оос 32 метрийн өргөнтэйгөөр ирэх 2 жилд хийж эхлэхээр төлөвлөсөн.

Энэ оны 7 сард барилга, угсралтын ажил нь эхэлнэ.

Байршлын хувьд Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хамаарагдсан нийтдээ 4 нүхэн гарцыг барьж байгуулна.

Энэ нүхэн гарцын хажуугаар манайх улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ Баянзүрх дүүрэг болон Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 21, 22 дугаар хороонуудад 2 нүхэн гарцыг барьж ашиглалтад оруулсан.

Ингээд төмөр зам дагуух нийтдээ 6 нүхэн гарцыг 2024 онд үндсэндээ барьж байгуулна.

Энэ нь нийт замын ачааллын 13.8 хувийг авахаар тооцоололтой байж байгаа.

Метроны хувьд үндсэн 3 чиглэлийг хийхээр төлөвлөсөн.

Чиглэлийн хувьд нийтдээ 41.8 километрийн урттай. Чиглэлийг босоо, хэвтээ чиглэлээр хийхээр төлөвлөсөн.

Масс транзитын хувьд хөнгөн галт тэрэг байх уу, метроны чиглэл байх уу гэдэг хөрөнгийн асуудал дээр асуудалтай байгаа учраас урт хугацааны бодлогод орсон байж байгаа. Хариулж дууслаа.

Г.Занданшатар: Одоо Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна. Алга байна. Хасла.

Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Түгжрэлийн асуудал үнэхээр эдийн засгийн, хотын гэхээсээ бүр ингээд нийгмийн гамшиг болчихсон байгаа л асуудал л даа.

Ер нь Монгол улсыг томоор нь гэхүүдээ аваад үзэх юм бол жоохон түүхий эдээ элс шороотой нь нүүрс, зэс ухаж гаргадаг. Жоохон доллар олдог. Үүнийгээ машинд, түүний сэлбэгэнд болоод, орос руу тэрний бензинд энэ жоохон доллароо явуулдаг.

Үүнийгээ авчраад нийтээрээ, хотоороо Улаанбаатар хотдоо түгжрээд суудаг. Энэ хотод нь хүн амынх нь 60 хувь нь амьдардаг. Түүнээс гарах нийгмийн бухимдал, стресс. Магадгүй түүнээс гарч байгаа өвчлөл, олон зүйлийг дагасан гамшгийн түвшинд оччихсон нэг ийм л асуудал хуримтлагдаж байна л даа.

Тэгээд сая энэ тайланг сонсохоор ерөнхийдөө нэг шийдэл бол тэр дүүжин

тээвэрээр хэдэн хүн тээгээд ямар юм. Тэр чинь аялал жуулчлалын л юм байх. Хэдэн автобус орж ирэх юм байна.

Тэгээд энэ хүрээнд энэ асуудал яг үнэндээ шийдэгдэх юм уу?

Асуудал хүн амын суурьшлаа бодсон ч Улаанбаатар хотод 5 жилийн дараа, 10 жилийн дараа хүн амын өсөлт ер нь хэд болох юм? Жилдээ 30, 40 байна уу, 50 мянга байна уу. Бараг нэг жижиг аймгийн хэмжээтэй хүн нүүж ирж байдаг. 30 мянган автомашин жилдээ нэмэгдэж байдаг. Нэг, хоёр гүүр бариад, хэдэн километр зам тавиад энэ хэрэгцээг чинь, энэ механик өсөлтийг хойноос нь хөөж гүйцэх юм уу?

Яг одоо бид нарын яриад байгаа энэ шийдэлд ямарваа нэгэн үр дүн ер нь байна уу? Надад одоо байхгүй юм шиг л харагдаж байгаа юм.

Энд нэлээн тийм чухал зүйл бол мэдээж ажил юм чинь тэгээд явах л байх. Чухал зүйл бол тэр нэг ийм материаллаг зүйл, арматур, цементийн асуудлаасаа гадна тэр нэг софт зүйл рүүгээ илүү анхаарвал яасан юм бэ.

Одоо жишээ нь, энэ софт зүйл, энэ бодлогын асуудал гэдэгт ялгаатай бодлогууд. Хот гэдэг чинь өөрөө асар их тэнд мөнгө эргэлдэж байдаг. Үүний цаана тэр мөнгө байгаа газар ялгаатай бодлогууд, эдийн засгийн шийдлүүд, хотын эдийн засаг гэдэг тэр бодлогын шийдлүүдээ энд яаралтай гаргаж тавих ёстой юм шиг.

Жишээ нь, Улаанбаатар хотод үл хөдлөхийн татварууд ялгаатай байдаг билүү. Төвийн газруудад үл хөдлөхийн татварыг нь өндөр тавья л даа. Тэгээд заавал үүнийг барина, барихгүй гэдэг механик захиргааны шийдэл биш, эдийн

засгийн аргаар нь энэ бүгдийг зохицуулж, гадагшаага тэлэлт явагддаг энэ бодлогууд нь тогтвортой байдаг олон зүйлүүд энд баймаар байна шүү дээ.

Одоо дэлхий нийтээрээ цахимжиж байна гээд байна. Бүх зүйл сайн сайхан болох бололцоо бүх газар энд нэвтрээд байна. Манай хотод яг үнэндээ цахимжилтын үр нөлөө өнөөдөр байхгүй л байгаа шүү дээ.

Тэр хүргэлтийн бизнес, коммерс бизнесүүд нь хөгжих гэсэн чинь хаягжилт байдаггүй. Хүргэлтийн компаниуд нь ажиллаж чаддаггүй. Тэнд нэг мотоцикл, мопедоороо хүргээд явах байтал одоо тэр бүгдээрээ приустээ сууж аваад түгжрээд л явна.

Гэтэл хот жоохон мөнгөөр энэ хаягжилтын асуудлыг нь үр дүнтэй нь шийдээд өгчихвөл тэр бусад бизнесүүд чинь тэр аппликэйшнээ хийгээд, хүргэлтээ хийгээд, цахимаар тэр бүх зүйлээ аваад явчихад энд асар их тийм нөөц бололцоо үүний цаана байж байна шүү дээ.

Тэр хаягжилт шийдэгдэхгүй болохоор бараг цахим худалдааны бүх моделиуд чинь бүгдээрээ үүний цаана ажиллахаа байчхаж байгаа юм.

Тэгэхээр бид энэ арга барилын хувьд жоохон ийм нэг цемент, арматур, гүүр, зам гэдэг энэ олон зүйлүүдээсээ жаахан өөрөөр хандмаар байна.

Тэгээд төгсгөлд нь энэ хэдэн автобус. Мэдээж эд нар ингээд хийгдээд автобусны 2 жилийн дараа ашиглалтаас гараад. Одоо орж ирж байгаа хэд нь 3 жилийн дараа дахиад л байхгүй л болоод л ингээд л явж таарна.

Ер нь томоохон яг бодлогын шийдлүүд нь аль нь юм? Тэр метро, LRT, элдэв дээдийн зөндөө л юм яригддаг. Яг томоохон тийм том өөрчлөлт гаргах гэж байгаа, Та нарын зорьж байгаа, одоо бэлтгэл ажилдаа ороод явж байгаа тэр том шийдлүүд чинь яг аль нь юм?

Лав л наад хэдэн автобус чинь шийдэл биш л байх. 3 жилийн дараа бүгдээрээ л тэгээд л ашиглалтаас гараад л явна шүү дээ.

Г.Занданшатар:

Жамьянхорлоогийн Сүхбаатар сайд хариулна.

Ж.Сүхбаатар:

О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Түгжрэлийг бууруулах асуудал эцсийн дүндээ цаад үг нь юу юм бэ гэхээр зэрэг нийслэл Улаанбаатар хот, бусад хотуудыг тэнцвэртэй зөв хөгжүүлэх явдал байгаа юм. Эцсийн шийдэл нь.

Тэгэхээр Ерөнхий сайдын **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ын хүрээнд хот, хөдөөгийн сэргэлт, аж үйлдвэрийн сэргэлт, ногоон хөгжлийн сэргэлт. Тэгээд бидний хамгийн гол тэр зорьж байгаа тэр сэргэлтийн бодлого нь **“Алсын хараа-2050”**-д одоо нийцсэн ийм бодлогыг явуулах байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөдөөг сэргээх нь чухал байгаад байгаа. Одоо таны сонгогдсон Увс аймаг жишээлбэл ажил амьдрал сайн байх юм тэндээс наашаа хүн нүүж ирэхгүй. Дархан руу, Улаанбаатар луу ч гэдэг юм уу.

Тэгэхээр тэр сэргэлтийн асуудлаар бид шийдвэр гаргасан. Гаргаж яваа. Анх удаа ер нь орон нутагт шилжин

суурьшиж байгаа иргэдэд ипотекийн зээлийн 3 хувийг олгоё гэж байгаа. Бизнесийнх нь зээл, татварынх нь хөнгөлөлтийг үзүүлбэ гэж байна.

Дээр нь эхнээсээ одоо жишээлбэл Өмнөговь аймагт технологийн коллеж, сургуулийг нээлээ. Тэнд 100 оюутан, 10 багш ажиллахаар болж байх жишээтэй.

Мөн удахгүй одоо бид Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал ярихаар зэрэг төрийн эрх барих дээд байгууллагаас бусад нь өөр газар байж болохоор нөхцөл бүрдүүлэх гэж байна.

Дарханд зарим нэг агентлагуудыг шилжүүлэх асуудлаар ажиллаж байна. Сангийн сайд энэ ажлын хэсгийг ахлаад ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл түгжрэлийг бууруулах бодлогын нөгөө тал нь төвлөрлийг сааруулах бодлого буюу хот, хөдөөгийн сэргэлт, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийн асуудлыг ярьж байгаа.

Тэгэхээр макро түвшний том бодлогын асуудлуудыг би энд детальчилж ярьсан. Энэ өөрөө том асуудлууд учраас улс орны төсвийн бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, төрийн удирдлагын асуудлуудтай холбоотой асуудал байгаа.

Энэ чиглэлээр бидний ажил явж байгаа. Тухайлах юм бол аймгийн Засаг дарга нарт бид чиглэл өгч байгаа. Өнөөдөр нутгаасаа хүн амаа явуулчхаад ажил хийж байна гээд яриад суугаад байгаа. Ажлын үзүүлэлт нь хэрхэн иргэдийнхээ тоог нэмэгдүүлж, зах зээлээ тэлж байна вэ гэдгээр нь хүртэл үнэлж дүгнэнэ гээд ингээд явж байгаа.

Хоёрдугаарт, ер нь Улаанбаатар хотын хувьд улсын төсөвт дандаа дулдуйдсан хэлбэрээр бүх хөрөнгө оруулалтууд нь явж ирсэн.

Тэгэхээр бид боломжийг нь олгоё гээд жишээлбэл анх удаа 420 тэрбумын эх үүсвэрийг нь үлдээе гээд өнгөрсөн жил өгсөн. Гэхдээ 420-ийг аваад хэрэглэчихсэн юм биш. Улаанбаатар.

Тэр 270 орчим тэрбум төгрөгөө одоо ингээд хэрэгжүүлж авч хэрэглэсэн. Гэхдээ нэлээд нь бас Засгийн газартайгаа хамтраад одоо энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмж, газар чөлөөлөлт рүү орчихсон.

Зам, гүүрэн байгууламж руу орсны ихэнх хэсэг нь энэ жил санхүүжүүлэх шаардлагатай байгаа юм.

Дээр нь энэ хэдэн автобус бол биш ээ. Энэ автобусаар чинь өдөрт 2 сая 800 мянган зорчилт хөдөлгөөний чинь 500-аас 600 мянган зорчилт хөдөлгөөн нь нийтийн тээврээр хийгдэж байгаа байхгүй юу.

Хувийн автомашинаараа 55 хувь нь явж байна. Та жишээлбэл нийтийн тээврийн зовлонг мэддэггүй байх л даа. Орж сууж үзээгүй байж магадгүй.

Гэтэл энэ чинь нийгмийнх нь нэг хэсэг. Хэрвээ түгжрэл буурья гэдэг чинь яадаг вэ гэхээр зэрэг автобусанд суугаад, явган яваад, унадаг дугуй унаад байх юм хувийн машинаараа л зорчих хөдөлгөөнөөсөө татгалзана шүү дээ.

Тэгэхээр замаа сайжруулъя, унадаг дугуйн замыг бид нэмэгдүүлбэ гээд сая шийдвэр гарсан. Энэ жил анх удаа гүүрэн байгууламжийг дугуйн замд зориулж хийх гэж байна.

Бид энэ **“Шинэ тойрог зам”** гээд олон жил яригдсан даа. Манай Ардчилсан нам засаглаж байх үед ч яригдаж байсан. “Шинэ тойрог зам”-ыг бид илүү дэвшилттэй хэлбэрээр нь энэ хурдны их тойруу гэсэн шинэ тойрог замын төслийг бид эхлүүлж байгаа.

Зураг төслийн ажил нь явж эхэлж байна. Эрчимтэй явуулж байна. **“Сэлбэ Сэргэлт”** гээд Улаанбаатар хотыг хойноос урагшаа холбосон хэсэг дээр бид Барилга, хот байгуулалтын сайд оролцсон, хотын удирдлагатай хамтарсан.

Бид дандаа хамтын ажиллагааны чиглэлээр явж байгаа. Энэ чиглэлээр явж байна.

Гуравт нь, тэр софт чиглэлийг би яг одоо баримталж ажиллаж байгаа. Одоо хуулийн төсөл дээр ажиллаж байна.

Соён гэгээрүүлэх ажлууд урьд өмнө нь сүрхий хийгдэж байсан юм... /минут дуусав/

Г.Занданшатар:

Жамьянхорлоогийн Сүхбаатар сайд гүйцээж хариулъя.

Ж.Сүхбаатар: Ер нь софт тэр хэсэг дээр яг хэлж байгаа. Соён гэгээрүүлэх ажил дээр би онцгой анхаарч байгаа.

Энэ оныг ер нь соён гэгээрүүлэх, иргэдийн сэтгэлгээ, албан тушаалтнуудын ажлын хандлагад өөрчлөлт оруулахад нь анхаарахгүй бол сэтгэлгээний түгжрэл илүү байна. Дүрэм журмын түгжрэл илүү байна.

Одоо нэг байранд байж хоорондоо хамтарч ажиллаж чадахгүй байна шүү дээ. Ямар сайндаа миний энэ албан

тушаал чинь шулуухан хэлэх юм бол холбогч буюу зохицуулагч сайд байхгүй юу даа.

Түүнээс биш түгжрэлийн асуудал гэдэг бол үр дагавар болохоос биш сургууль, цэцэрлэггүйн улмаас түгжирч байна. Сургууль, цэцэрлэгийнхээ юмыг зөв төлөвлөж хийхгүй баахан хотхон, барилгажуулснаас болж энэ түгжрэл хийгдэж байна. Газрын наймаанаас болж энэ түгжрэл чинь, энэ сөрөг үр дагавар чинь үүсэж байна. Бодлого, төлөвлөгөөгөө хуульчлаагүйгээс болж энэ үүсэж байна.

Ер нь хээл, хахууль, авлигатай чинь илүү холбоотой байна шүү дээ. Энэ түгжрэл чинь.

Тэгэхээр түгжрэлийн асуудал дээр соён гэгээрүүлэх асуудал чухал гэдэгтэй тантай санал нэг. Энэ чиглэлээр танд мэдрэгдэхүйц хэмжээний ажил хийнэ. Би эргэж тайлагнана.

Энэ жил манай Үндэсний хорооны төлөвлөгөөнд орсон ажлууд байгаа. Хуулийн төслийг оруулна. Засгийн газрын босгыг давчхаад, Их Хуралд орсны дараа Та бүхэн дэмжээрэй.

Энэ бол одоо хамгийн софт зах зээлийн эдийн засгийнх нь аргаар нь зохицуулна.

Түүрүүн Та хэлээд байна шүү дээ. Хотжилт бол эргэлт буцалтгүй үйл явц. Улам томорно. Улаанбаатар хотын хүн ам өснө. **“Улаанбаатар-2040”** хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг бид удахгүй Засгийн газарт оруулаад Их Хуралд танилцуулна.

Үүгээр бид зуу зуун мянгаар ингээд өсөөд л явна. Тав таван жилд.

Тэгэхээр энэ асуудал дээр түгжрэлийн индекс нэмэгддэг. Одоо бусад дэлхийн ямар ч хөгжилтэй мундаг асуудлаа шийдчихсэн гээд байгаа орнуудад түгжрэлд ажлаасаа буцах, ажилдаа очих замд дийлэнх нь түгжирч байгаа. Ямар ч трамвайтай, метротой, LRT-тай, нийтийн тээвэртэй нь.

Манайд яагаад нийтийн тээвэр дээр онцлоод байгаа гэхээр өнөөдрийн байгаа нийтийн тээврийн автобуснууд чинь дийлэнх нь ашиглалтаас гарах хэмжээнд орчихсон. Хот нь өөрөө алдагдалд орчихсон байхгүй юу.

500 төгрөг. Үүнийг чөлөөлдөггүй. Чөлөөлөх боломж ч бас муутай. Угаасаа алдагдалтай байдаг салбар.

Ингээд олон жил болоод ирэхээр парк шинэчлэлт хаа хаанаа хийж чадахгүй. Хувийн хэвшлийнхэн болохоор боломжоороо хийдэг. Энэ нь тэгэхдээ хуучирсан автобусууд байдаг.

Иргэд бас тэр ая тухаар нь голдог. Гологдоод байна гэдэг нь судалгаагаар гарчихсан. 75 хувь нь энэ автобуснууд чинь гологдоод байна, муу байна гээд дүгнэчихсэн.

Хэрвээ автобусаа та нар үнэхээр сайхан аятайхан автобус, сайн чанарын автобус оруулаад ирэх юм бол сууя гэдэг нь гуравны хоёр нь байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ байгаа боломжоо. Нийтийн тээврийн асуудал бол зүгээр суурь асуудал. Үүгээр шийдэх гээд байгаа юм биш.

Хот байгуулалт, замын хөдөлгөөн, замын сүлжээ, тээвэр ложистик, энэ нийтийн тээвэр гэдэг энэ бүх чиглэлээр чинь бүс нутгийг хөгжүүлэх асуудал

гэсэн энэ багц чиглэлээр ажиллаж байж энэ түгжрэл буурна.

Энэ түгжрэл гэдэг бол бидний авлигажсан, хүнд сурталжсан, сэтгэлгээний хөшүүн байдал, хариуцлагагүй байдал эд нар чинь л энэ түгжрэлийг бий болгож байгаа шүү дээ.

Түүнээс биш хүн нэмэгддэг, машин нэмэгддэг чинь хотжилтын сөрөг үр дагавар гэж хэлэхэд бас хэцүү. Энэ бол эдийн засгийн өсөлт, хүн амын өсөлтийн үр дүн.

Гол нь шийдэл нь үүнээсээ хоцроод, үүнийг шийдэх арга зам нь дутаад байна. Сэтгэл дутаад байсан.

Тийм учраас энэ удаагийн Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд намайг тохоон томилоод энэ холболтуудыг хийгээд, энэ олон байгууллагуудыг, олон арван, 20, 30 байгууллагуудыг нийлүүлээд холбоосыг нь хийгээч ээ.

Улаанбаатар хотод баригдаад байгаа олон замууд чинь хүртэл наана чинь холбогдохгүй юм. Энэ олон арван байгууллагууд хоорондоо холбогдож ажиллаж чадахгүй байна.

Тэгэхээр хамтын ажиллагааны соёл, хандлагыг бий болгоод өгөөч ээ гээд ингээд надад өгчихсөн үүрэг нь ингээд явж байгаа юм.

Тэгээд би энэ чиглэлээр миний хийж байгаа ажлын 80 хувь нь огт харагдахааргүй ажлууд байгаа. Дандаа өдөр болгон.

Жишээлбэл, замын цагдааг чинь би удирддаг хүн биш шүү дээ.

Гэтэл одоо энд байгаа Ч.Батболд эд нартай би байнга л харилцаж байгаа юм. Нийтийн тээврийн даргыг би удирддаггүй. Уг нь. Шууд. Гэхдээ би энэ асуудлыг байнга л харилцаад явж байгаа.

Одоо энэ газрын дарга байж байна. Ингээд манай Үндэсний хороонд оруулж байгаа. Эд нар чинь бүгд өөр өөрийн сайд, даргатай. Гэхдээ би зохих холбоос хийж холбогдох ажлыг хийхгүй бол манайд дутуу байна гэж харсан учраас энэ албан тушаал гарсан юм л даа.

Түүнээс биш би хүсэлт тавиад гаргачихсан асуудал биш. Ерөнхий сайд өөрөө олж харсан учраас.

Тийм учраас сүүлийн хагас жилийн хугацаанд би нэлээн ахиц гарч байгаа гэж.

Мэдээж 20 жил шийдэж чадахгүй байгаа улсуудын юмыг нэг жилийн дотор шийдэх гэж оролдоход хэцүү ч гэсэн бодлогын суурь, хандах зүгийг нь зөв тогтоогоод суурийг нь тавиад өгье.

Магадгүй та дараа энэ ажлыг хариуцах ч юм билүү. Тэрийг чинь би ядаж суурийг нь зөв тавиад өгчихье л дөө. Тэгвэл таны зовлон багасна шүү дээ. Та Улаанбаатар хотод их анхаарал хандуулдаг хүн. Улаанбаатар хотын асуудлаар гэсэн надаас бараг илүү мэдлэгтэй байх.

Тэгэхээр магадгүй та энэ асуудлыг Барилга, хот байгуулалтын сайд ч гэдэг юм уу, Зам, тээврийн сайд юм уу, эсвэл түгжрэлийн дараагийн сайд болж магадгүй шүү дээ.

Тэгэхээр би энэ суурийг нь дараа дараачийн нөхдүүдэд зориулаад эвтэйхэн тавиад өгөх үүднээс Зам, тээврийн сайд, Боловсролын сайд.

Одоо энэ чинь сургууль, цэцэрлэггүйн улмаас л 90 мянган гаруй мянган хүүхдүүд жишээлбэл өдөр тутам сургууль руугаа зөөгдөж байна шүү дээ. Сургууль, цэцэрлэг рүү.

Тэгэхээр асуудлууд нь хаана байна вэ гэхээр түгжрэл гэхээр чинь үр дагавар болохоос биш.

Тэгэхээр энэ үр дагавар дээр ажиллаж байгаа олон арван байгууллагуудын хамтын ажиллагааг л хөгжүүлж байж, иргэдийнхээ соён гэгээрүүлэх ажлыг хийж байж, албан тушаалтнуудын хандлагыг, өнцгийг өөрчилж байж явна гэдэг энэ юман дээр би санал нэгдэж байгаа учраас энэ чиглэлд урьд нь ямар ч арга хэмжээ авагдаж байгаагүй юм билээ.

Харин би энэ чиглэлд ажиллаад зүтгээд явж байна.

Түгжрэл бол Ардчилсан намын түгжрэл, Ардын намын түгжрэл гэж байхгүй. Энэ газрын авлига гэж ярих юм бол одоо энэ газрын чинь зөвшөөрлийг авсан улсуудыг ил болгож байгаа.

Тэгээд бүгд л хувь нэмрээ оруулж байгаа шүү дээ. Энэ чинь. Сургууль, цэцэрлэгээ барихгүй, замаа тооцохгүй байж баахан юм бариад байдаг. Энэ чинь л өөрөө асуудал үүсгээд.

Гэтэл түгжрэл чи бууруулсангүй гээд хүн загнаад байвал энэ чинь хэцүү шүү дээ. Өөрсдөө бүгд чиглэл чиглэл дээрээ анхаарах ёстой байхгүй юу.

Бид энэ олон улсын хандивлагч байгууллагуудын юман дээр ч гэсэн мэргэжлийн зөвлөгөө, тусламжуудыг авах чиглэлд нь ажиллаж байна, ярьж байна. Зөв чиглэлд байна гэж дүгнэж

байгаа шүү дээ. Ерөөсөө та нар буруу чиглэлд явж байгаа биш байна гээд.

Би хамгийн гол юм нь манай өмнөх нийтийн тээврийн салбарын жишээлбэл бодлого хаана байна вэ гээд эргээд үзэх гэхэд байхгүй байгаа байхгүй юу. Хоёр, гурван өгүүлбэртэй. Ерөнхийдөө ийм зарчим баримтална гэсэн.

Тэгэхээр энэ нийтийн тээврийн салбарын асуудал дээр бодлогынх нь юмыг нь гаргаж ирэх хэрэгтэй байна. Илэн далангүй үнэнийг нь хэлэх хэрэгтэй байна. 17 хувийн хэвшил, 2 орон нутгийн өмчит компани шугамаа булаацалдаад, маргалдаад. Тэгээд дотаци нь нэмэгдээд л. Одоо байгаа даа эвлэрцгээгээд л дуугүй явцгааж байна шүү дээ.

Үүнийг чинь гаргаж ирж асуудал байна гээд тавихаар зарим нь дургүйцээд л, шүүмжлээд л.

Нийтийн тээвэр яах вэ, наадах чинь асуудал биш гэж. Нийтийн тээвэр хөгжихгүй бол дараагийн шууд метро барьж чадахгүй, дараагийн тэр хотхонуудыг чинь яаж шинээр барих юм.

Хүн чинь нийтийн тээврээр л явж байж. Хотын хөгжлийг нийтийн тээврийн хөгжлөөр нь хэмждэг байхгүй юу.

Тэгэхээр нийтийн тээврээ хөгжүүлээгүй бол хотхон барьж чадахгүй. Нийтийн тээврээ хөгжүүлээгүй бол бусад асуудлуудыг шийднэ гэж байхгүй.

Тэгэхээр манайх хамгийн анхдагч нөхцөлийг хийж чадаагүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хийж чадаагүйг чинь өнөөдөр яриад хэрэггүй. Одоо бид

шийдэх гээд Монгол Улсын Засгийн газар өөрөө орж ирж байгаа байхгүй юу. Хуучин хотын асуудал гээд хаячихсан юм билээ.

Тэгэхээр үүнээс чинь болж хөрөнгө оруулалт орж ирэхгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын гол баримталж байгаа юм нь Улаанбаатар хотын 1 сая 600 мянган хүний асуудлыг орон нутгийн хотын асуудал гэж үзэхгүй. Энэ ужгирсан асуудлуудыг бид шийдэх ёстой.

Энэ бол жишээлбэл Хөшигийн хөндийн асуудал байгаа.

Шинэ Зуунмод, Хөшигийн хөндийн дагуул хотын асуудлууд. Цаашаа Аэро Сити, Майдар гээд л. Та хэд мэдэж байгаа шүү дээ. Энэ дагуул хотуудын асуудал дээр ч гэсэн бид анхаарал хандуулж Хөшигийн хөндийг хөгжүүлэх асуудал дээр онцгой анхаарал хандуулж байгаа.

Тэгэхээр энэ болгон бидний түгжрэлийн ачааллыг бууруулна. Мэдээж түгжрэл бол та биднийг яриад явж байхад ч гэсэн сар болгон хэдэн мянгаараа, 3, 4 мянгаараа автомашин бууж байгаа.

Тэгэхээр татварын бодлого дээр би зоригтой асуудал харин оруулж ирнэ гэж бодож байгаа. Иргэд, олон хүн дургүйцэх байх. Яагаад гэвэл бусад оронд түгжрэлийн эсрэг ийм томоохон арга хэмжээг ер нь ихэнхдээ эсэргүүцдэг юм байна лээ.

Тэр эсэргүүцлийг даван туулсны дараа өөрсдөө ойлгоод ингээд болдог. Тэр байтугай шүүхэд хүртэл асуудал өгч байсан тохиолдол Лондонд байдаг юм билээ. Түгжрэлийн бүс бий болгочихсон чинь эсэргүүцээд.

Гэтэл одоо Лондоны түгжрэлийн бүс хамгийн үлгэр жишээ бүсэд тооцогдож байгаа шүү дээ. Төлбөртэй бүс нь гэдэг ч юм уу.

Тэгэхээр түгжрэл өөрөө их зовлонтой асуудал. Нэг талдаа энэ бол хэдэн хүний ажил биш. Бид нарын ажил амьдралын хөдөлгөөн, хэв маягтай, хөгжлийн хандлагатай холбоотой асуудал гэж үзэж байгаа юм.

Үл хөдлөх хөрөнгийн татвар дээр би тантай санал нэг байгаа. Бид үл хөдлөх хөрөнгийн татварыг 3 хувь гээд явчихсан.

Ер нь бид маш сайн мэдэж байгаа. Тийм ээ. Татвар нэмэх, нэмэхгүй гээд л яриад байгаа болохоос боломжийг нь олгоод. Хотын төв илүү татвартай байдаг нь бүх хотуудын нийтлэг жишиг. Тэгж байж хотын зах руугаа, хотоос бүр хол тосгон, хотхонууд дээр тэр том моллууд, бусад юм байдаг.

Манайд хотын төв дээрээ одоо ингээд худалдааны төв, захууд нь төвлөрөөд байгаа нь үл хөдлөх хөрөнгийн татвар бага байгаатай холбоотой гэдэг нь үнэн.

Энэ мэтийн асуудлуудыг би дэвшүүлж тавихаар хуулийн төслүүд бэлдчихсэн байгаа. Харамсалтай нь нуугаад байх юм байхгүй.

Бид чинь Засгийн газар дотроо ярихаар мэдээж татвар төлбөрийн асуудлууд дээр хүмүүс эмзэг байна. Нийгмийн амьдрал хүнд байгаа учраас гээд үүнийгээ хойш тавья гэсэн хүмүүс нэлээдгүй байгаа нь үнэн.

Гэхдээ би энэ асуудлыг хариуцаж байгаа сайдын хувьд миний хувьд эсрэг байр суурьтай байгаа.

Зах зээлийнх нь зохицуулалт болсон татварын хөшүүргийг ашиглах нь иргэдэд өөрт нь ашигтай, хэрэгтэй. Тэгэхгүй бол иргэд үүнээс болоод жилд 35 өдөр түгжрээд 2.7 их наяд буюу удахгүй 1 тэрбум долларын алдагдал үүрч байгаа.

Жолооч нарын үүрч байгаа алдагдал бүр өндөр болчхоод байгаа байхгүй юу. 3000 доллар шахуу болчхоод байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны шинэ дэгийн дагуу намын бүлгүүдийг төлөөлж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-д заасны дагуу **D-Parliament.mn** цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулж иргэдээс ирсэн асуулт, саналууд. Тэднийг боловсруулж холбогдох байгууллагуудаас авсан саналуудынхаа дагуу Засгийн газрын гишүүнээс асуулт асууна.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан Засгийн газрын гишүүнээс асуулт асууна.

20 минут. Шууд үргэлжлээд явна.

Э.Бат-Амгалан: Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой иргэдээс ирсэн асуултууд нэлээд байгаа учраас асуултаа товчхон уншиж танилцуулъя.

Хариултаа ч гэсэн товчхон авъя. Саяын хуралдааны чуулганы дэгийн тухай хуулиар 20 минут байгаа.

Тийм учраас холбогдох сайд нар, холбогдох хотын удирдлагууд товчхон ойлгомжтой хариулбал зүгээр байна гэж ингэж бодож байна.

Нэгдүгээр асуулт. Пэлжээгийн Туяа. Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17 дугаар хороо. 2 асуулт ирүүлсэн байна.

1.Худалдаа, үйлчилгээний төвүүдэд ажиллагсад ойр орчмын зогсоолуудыг дүүргэн авто замын нэгдүгээр эгнээгээр машинаа байрлуулж байна. Энэ нь ачаалал их үүсгэж байна.

2.Тодорхой байршлуудад нэгдүгээр эгнээнд байрлуулсан машинуудыг чөлөөлөхгүй байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын байрны баруун талын авто замын нэгдүгээр эгнээнд Ж.Сүхбаатар дүүргийн цагдаагийн ажилтнуудын байрлуулсан машинуудыг огт ачдаггүй.

Энэ талаар үүрэг чиглэл өгч болох уу гэж. Энэ нэг асуулт байна.

Хоёрдугаар асуулт. Сүнэрийн Нямдорж. Увс аймгийн Давст сум, 2 дугаар баг.

Машины хэрэглээг бууруулж, түгжрэлийг бууруулах арга замыг хэрэгжүүлнэ үү. Хаалтан дотор энэ ялангуяа хуучин машинуудтай холбоотой гэж ингэж бичсэн байна.

Гурав. Баярсайханы Оюунтуяа. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 7 дугаар хороо.

Энхтайваны өргөн чөлөөний дагуу баруунаас зүүн дөрвөн зам руу явах замд зүүн гар тал руу эргүүлэхээ больсон. Энэ нь зам дээр зогсох хүмүүсийн цагийг улам нэмээд байгаа юм биш үү.

Их дэлгүүрийн урдаас Централ таувер орох гэж яваа хүн Монгол Улсын Боловсролын Их Сургуулиар эргээд Централ таувер орж байна.

Дөрөв. Чулуундоржийн Цогт-Очир. Сэлэнгэ аймгийн Сайхан сум, 3 дугаар баг.

Улаанбаатар хотын даргыг яаж сонгодог вэ? Түүнийг сонгуулийн зарчмаар сонгох боломж байдаг уу?

Монгол Улсын талаас илүү хүн ам оршин суун байгаа хамгийн том хотыг хариуцсан албан тушаалтан сонгуулиар сонгогдох боломжтой юу гэнэ.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудал биш байна.

Тав. Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны иргэн н.Баттөгс.

Замын цагдаа нар ялангуяа ажил тарах үеэр таталт хийдэг. Бид таталт гэж ярьдаг. Энэ таталт ер нь хэнд зориулсан таталт юм бэ? Жишээ нь, Сүхбаатарын талбайн баруун, зүүн талаар таталт хийгдэхгүй хэчнээн цагаар зогсдог.

Энэ дарга нарт зориулсан таталт юм биш биз дээ. Энэ дээр холбогдох хүмүүсээс хариулт авъя гэж байна.

Зургаа. Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо, н.Галцог.

Авто замын түгжрэлийг бууруулах төслийн хүрээнд хийгдсэн ямар ямар

ажлууд байна вэ? Ялангуяа Баянзүрх дүүрэг хүн амын хувьд ч тэр, газар нутгийн хувьд ч тэр хамгийн том дүүрэг.

Энэ дээр тодорхой хариулт авъя гэсэн байна.

Энэ 7 асуултад тодорхой товчхон хариултаа авчхаад Улсын Их Хурал дахь Улаанбаатар хотын хөгжлийн бодлого эрхэлсэн түр хороон даргын хувьд цаасаар ирсэн, бичгээр ирсэн хэдэн асуудал асуултууд байгаа. Түүн дээр ярилцъя гэж бодож байна.

Г.Занданшатар: Таны микрофон асаж байгаа. Шууд микрофондоо хэлээд явчих. 84. Шууд заагаад явчих. Тэгэхгүй бол цаг алдаад байна.

С.Адъяасүрэн: Э.Бат-Амгалан гишүүний асуултад хариулья.

Тээврийн хэрэгслийн зогсоолын хүртээмжгүй байгаа байдал өнөөдөр манай хотод тулгамдсан асуудал болчихсон байгаа. Бид зогсоолын үнэ, тарифт өөрчлөлт оруулахаар нийслэлийн иргэдийн Хуралд өргөн барьчихсан байгаа.

Ер нь дунджаар хүний зорьсон ажлаа гүйцээх цаг хугацаа 3 цаг орчмын хугацаа байдаг.

Тэгэхээр 3 цагт тодорхой хэмжээний бага тарифтай. 3-аас дээш цагт тариф нь өндөр байхаар байя гэж ингэж ярьж байгаа. Ажлууд явж байна.

Дээр нь ачилтын асуудал байнга хийгдэж байгаа. Улаанбаатар хотод 15 ачилтын үйл ажиллагаа явуулдаг байгууллага манай Удирдлагын төв, Тээврийн цагдаагийн албатай гэрээ байгуулчихсан ачилтын асуудлыг хариуцаад явж байгаа.

Ер нь ачилттай холбоотой нэлээн маргаан, гомдлууд их байдаг. Энэ талаар иргэдээс ирсэн саналын хүрээнд Хууль зүйн сайдын баталсан журамд өөрчлөлт оруулах саналаа хүргүүлчихсэн байгаа.

Зогсоолын тарифыг тодруулаад хэлэхэд эхний цаг нь мянга байя. Хоёр дахь цаг нь 1500, гурав дахь цаг нь 2000, дөрөв дэх цаг нь 4500 төгрөгөөр үйлчилгээ үзүүлнэ гэсэн ийм саналаа Нийслэлийн иргэдийн Хуралд өргөн мэдүүлчихсэн байгаа.

Зүүн эргэлт гэдэг бол замын хөдөлгөөний ачаалал ихтэй уулзвар замууд дээр зүүн эргэлтийг багасгах зарчмаар түгжрэлийг бууруулах ийм олон улсын аргачлал байдаг.

Ер нь давхар түвшний уулзварын огтлол, зүүн эргэлтийг хязгаарлах замаар тухайн уулзвар дээрх нэвтрэх чадварыг сайжруулах ийм ажлууд хийгддэг. Одоогоор тодорхой чиглэлүүдэд зүүн эргэлтийг нь хязгаарласан нийтдээ 18 уулзвар, байршлууд байна.

Тэгэхээр энэ бол дандаа тухайн цаг хугацаандаа тооцоогоо хийгээд ингээд гаргадаг байгаа.

Зөвхөн өнгөрсөн жил бид хийсэн нэг уулзварын талаар жишээ авч тайлбарлая.

Олимпын гүүр буюу одоо шинээр баригдсан гүүрний Натур луу эргэдэг, тэр уулзвар луу эргэдэг хэсгийн зүүн эргэлтийг хориглоод гүүрэн доогуураа буцаж эргэх ийм байдлаар хөдөлгөөн зохицуулалт хийсэн.

Үүний үр дүнд бид төлөвлөхдөө 3151 автомашин цагт нэвтэрч байсныг 3781 болно гэсэн. 20 хувиар нэвтрэх

чадвар сайжирна гэсэн тооцоо гаргасан. Одоогийн үр дүн 3846 буюу 22 хувиар уулзан нэвтрэх чадвар сайжирч байгаа юм.

Мөн тэнцвэртэй зорчилт гэж ярьдаг. Дөрвөн талаасаа гэрлэн дохионы зөвшөөрөл өгөгдөөд тэр чиглэлдээ зорчих тэнцвэртэй зорчилт уулзвар дээр 397 байсан. Одоо 689 удаа зорчилт хийгдэж байгаа.

Зүүн эргэлтийн хувьд ийм тайлбар өгье.

Таталтын асуудал гэж ярьдаг. Бид нарын зүгээс хөдөлгөөн зохион байгуулалтын ажил байгаа. Энэ нь тухайн өдрийн хөдөлгөөний оргил ачаалалтай үед гэрлэн дохио болон тээврийн цагдаагийн албан хаагчидтай хамтран төвлөрлийг сааруулах. Өглөө зорчин чиглэлд нь аль болох богино хугацаанд хүрэх зорилгоор хөдөлгөөн зохион байгуулалтын ажил хийдэг.

Энэ дээр дарга нар татах гэдэг ойлголт байхгүй.

Хөдөлгөөн зохион байгуулалт хийдэг 3 тохиолдол байдаг.

Нэгдүгээр тохиолдолд, уулзвар зам дээр саад, осол гарсан тохиолдолд хөдөлгөөнийг тойруулж зохицуулалт хийж байгаа.

Хоёрдугаар зохицуулалт нь, түргэний болон гал команд, яаралтай тусламжийн автомашинуудад зориулсан хөдөлгөөн зохицуулалт хийдэг.

Гурав дахь нь, хуулиар эрх олгогдсон тусгай хамгаалалтын зохицуулалтыг хийж ингэж явж байгаа.

Тэр дарга татдаг гэдэг ойлголт байхгүй.

Бид өнөөдрийн байдлаар Та бүхэнд хэлэхэд Улаанбаатар хот 25 цагаас дээш километр цагийн хурдтай явна гэж тооцвол хөдөлгөөнд 85 мянган машин л оролцох ёстой болж таараад байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр хөдөлгөөнд өдөр тутам орж байгаа автомашины тоо 198 мянгаас 233 мянга буюу тооцсон тооцооллоосоо хоёроос гурав дахин илүү ачаалал авчихсан. Замын нөхцөл байдал туйлын хүнд байдалтай байна.

Тэгээд энэ тохиолдолд хөдөлгөөний төвлөрлийг зорчсон чиглэлд нь аль болох явуулахын тулд энэ хөдөлгөөн зохион байгуулалтын ажлыг хийдэг олон улсын аргачлалынхаа дагуу л явж байгаа ийм ажил байна.

Г.Занданшатар: Машины хэрэглээ. Буруу рултэй. 83.

Тэр дарга нарын нэрийг бариад л худлаа таталт хийлгээд байдаг байдаг юм уу. Тэрнийг хянаж шалгана шүү. Тийм яриа гаргаад байдаг. 83.

Ч.Батзориг: Э.Бат-Амгалан гишүүний иргэдээс ирсэн зарим асуултыг хариулъя.

Улаанбаатар хотын автомашины хэрэглээн дээр нийтдээ хоёр үндсэн асуудлууд орж ирж байгаа.

Нэгдүгээрт нь, импортын татварын бодлого байгаа.

Өнгөрсөн жил гэхэд нийтдээ 76 мянган автомашин орж ирснээс үүнээс 56 мянга 800 автомашин нийслэлд бүртгэгдсэн. Үүнтэй холбогдуулаад

татварын бодлого дээр бид 5-аас 20 хувийн интервалтай нэмэгдүүлэхээр үндсэн тусгайлсан хууль дээрээ дагалдуулж оруулж ирж байна.

Нөгөөтээгүүр Улаанбаатар хотын авто зам ашигласны төлбөрийн хэмжээг бид мөн бүсчлэлээр оруулж ирж байгаа.

Одоогийн хэрэглэж байгаа 20 мянга, 40 гэсэн ийм тарифтай байгаа. Авто зам ашигласны төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэхээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд эхний хагас жилд өргөн барихаар бид бэлтгэлээ хангасан.

Дээрээс нь мөн **RFID**[Radio Frequency Identification]-ийн шинэчилсэн бүртгэлийн системүүд, уншигчуудыг бид нийтдээ 161 байршилд байршуулсан.

Үүнтэйгээ холбогдуулаад бүртгэлийн болоод автомашины зорчилт дээр бид бүрэн хяналтыг тавина гэж энэ дээр тодорхойлж байна.

Сүүлд нь тэр төсөл хэрэгжүүлж байгаа ямархуухан ажлууд хийгдсэн бэ гэж.

2022-2024 оны хугацаанд нийтдээ 4 бүлэг, 12 багц ажлыг 239 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжилт нь явж байна.

Өнөөдрийн байдлаар 2022 онд хийх ёстой ажлын хэрэгжилт 85 хувьтай явж байна. Баянзүрх дүүрэг дээр бүр тодруулж хийгдье гэж байна.

Баянзүрх дүүргийн хувьд авто зам, замын байгууламж дээр 2 төсөл, арга хэмжээ явж байгаа.

Энэ дээр хамгийн том нь Шар хадын автобусны буудлын эцсээс 4.2 километрийн урттай гүүрэн

байгууламжтай. Гүүр нь 197.3 метр урттай ийм үндсэн ба гол замыг холбох нэг зам явж байна.

Нөгөөдөх нь Цагдаагийн академиас уруудаж байгаа 68 дугаар сургуулийн баруун талаар явах өргөн чөлөөний холбоос замууд явж байна.

Нийтдээ Баянзүрх дүүрэгт 2022-2024 онд 16 цэцэрлэг, 7 сургуулийн шинэчлэлийн ажлыг хийгдэхээр төлөвлөгдсөн явж байна.

“Шинэ тойрог зам”-ын нийтдээ 12.5 километр зам нь Баянзүрх дүүргээр дайрч байна.

RFID[радио давтамжийг таних]-ийн нийтдээ 161 байршлаас Баянзүрх дүүрэгт 22 байршил нь орсон байна.

Нөгөөтээгүүр төвлөрлийг сааруулахтай холбоотой “**Шар хад дэд төв**”-ийн бүтээн байгуулалтын ажил явж байгаа. Үүн дээр мөн газар чөлөөлөлтийн ажлууд хийгдээд 2023 онд үргэлжлээд явна.

Нийтдээ энд баригдах томоохон барилга, байгууламжтай эрчим хүчний эх үүсвэрийн асуудал дээр Амгалан дулааны станц дээр 50 мегаваттын өргөтгөлийн ажил 2022 оноос ажил нь эхэлсэн. 2024 онд ашиглалтад орохоор байгаа.

Э.Бат-Амгалан: Дарга асуулт байна.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар багийн Ч.Цогт-Очир гэж хүн өнөөдрийн мэдээлэлтэй холбоотой асуулт биш байна лээ.

Үүнийг дараа нь бичгээр өгчхөж болох байх.

Өчигдөр нийслэл Улаанбаатар хотоос **“Улаанбаатар түншлэл”** гээд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, эдийн засгийн форумыг зохион байгуулсан.

Орой телевизээр Улаанбаатар хотын дарга Д.Сумъяабазарын өгсөн мэдээллийг үзсэн.

Тэндээс нэг ийм ойлголт авсан. Энэ Дорноговь аймагт хүрэн нүүрсний талбай байгаа. Үүнийг Улаанбаатар хот эзэмших эрх нь бий болсон. Үүнийг харин эдийн засгийн эргэлтэд яаж оруулж, Ж.Сүхбаатар сайдын мэдээлэл дээр гарсан тэр метроны асуудал, LRT-ны асуудал, тойрог замын асуудал гээд энэ хөрөнгө санхүү шаардсан томоохон ажлуудаа хийх ёстой гэсэн нэг иймэрхүү ярилцлагыг би товчхон үзсэн.

Тэгэхээр би Ж.Сүхбаатар сайдаас асуух гээд байгаа нь, энэ ер нь яг ямар шатдаа яваа юм бэ? Энэ хүрэн нүүрсний Дорноговьд байгаа талбай нь Улаанбаатар хотын эдийн засгийн эргэлтэд оруулахад Та бүхний яг өнөөдрийн байдлаар хийж хэрэгжүүлж байгаа ажлууд юу байна вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Засгийн газар Улсын Их Хурал дээр ямар ямар дэмжлэг авах шаардлагатай юм бэ?

Би өчигдрийн ярилцлагаас ерөөсөө л тэгж ойлгосон.

Энэ Улсын Их Хурлаар тодорхой хэмжээний шийдвэр гаргаж байж энэ нийслэл Улаанбаатар хотод Монгол Улсын хүн амын 50 хувь нь амьдарч байгаа энэ түгжрэлийн асуудал, энэ төвлөрлийг сааруулах асуудал, энэ утааны асуудал, энэ түлшний асуудлыг хийн газад шилжүүлэх асуудлуудыг хийх томоохон эдийн засгийн эргэлтийн

асуудлууд л яригдаад байна гэж ойлгож байгаа.

Түүрүүн О.Цогтгэрэл гишүүн ч гэсэн асууж байна лээ л дээ.

Өнөөдөр байгаа хэдэн төсвийнхөө мөнгөн дээр та нар эргэлдээд, баахан тооцоо, судалгаа хийгээд л яриад байдаг. Ахисан түвшний юм ерөөсөө байхгүй байна гэж. Би энэ чиглэл дээр санал нэг байгаа.

Тийм учраас энэ асуултыг асууж байгаа юм.

Энэ дээр тоймтой дорвитойхон шиг хариулт өгөөдөх өө.

Улсын Их Хурал дээр чинь урьд хожд байгаагүй Улаанбаатар хотыг дэмжих хөгжлийн бодлогын түр хороо гарчихсан. 24, 25 гишүүнтэй ажиллаж байгаа шүү дээ.

Шаардлагатай энэ түр хороогоороо ч гэсэн энэ асуудлуудаа оруулаад, Их Хурлаар хэлэлцүүлэх, дэмжүүлэх энэ ажлуудыг ер нь хийх нь зүйтэй гэж ингэж бодож байна.

Ж.Сүхбаатар: Э.Бат-Амгалан даргын асуултад хариулья.

Өчигдөр **“Шинэ сэргэлт-Улаанбаатар”** форумын арга хэмжээ зохион байгуулсан. Дотоод гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийнхний оролцоотойгоор бид Улаанбаатарын хөгжлийн асуудал дээр бүтээн байгуулалтад оролцох тухай төслүүдээ танилцуулсан.

Тэгэхээр энд Улаанбаатар хотын ерөнхий менежер оролцож байгаа.

Ер нь бид “Улаанбаатар-2040” хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх тооцооллыг урьдчилсан байдлаар гаргаад 142 их наяд төгрөг шаардлагатай гэдэг асуудал гарч ирчхээд байгаа юм. 2040 он хүртэл хөгжүүлэхэд. Том төслүүдийг хэрэгжүүлэхэд.

Гэтэл үүнийг одоо яг улсын төсвийн өнөөгийн хэлбэрээр ингээд явах юм бол 300 тэрбумыг өгөх үү, 400-г өгөх үү, ихийг өгчихлөө, багыг өгчихлөө гэдэг байдлаар энэ төслүүд хэрэгжих боломжгүй болж байгаа юм.

Гэтэл Улаанбаатар хотод яах вэ, бид Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, нэгжийн хуулиудаар ер нь суурь боломжуудыг нээгээд өгчихсөн байгаа юм.

Цаашлаад татварын болон бусад хэлбэрүүдээр боломжуудыг нь нээж өгөх шаардлага байгаа. Тэгж байж нэгжийн хууль, Улаанбаатар хотын хууль амилах гээд байгаа юм.

Тэгэхээр Улаанбаатар хот ямар асуудал ярьж байна вэ гэхээр төсвийн бус орлогынхоо эс үүсвэрийг улсын төсвөөс гадуур өөрсдөө бонд гэхээс гадна тэр орлого олдог өмч аж ахуйтай холбоотой асуудлуудаа явуулъя.

Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг ярих гэж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хууль ярих гэж байна. Энэ маш чухал байгаа.

Тэгэхээр Улаанбаатар хотод боломжтой бидэнд нүүрс л үнэ хүрээд байгаа. Улаанбадрахын нүүрсний талбай гээд Дорноговь дахь хайгуулын талбай гэх үү дээ. Тийм ээ. Эдийн засгийн эргэлтэд оруулъя. Энэ хүрэн нүүрс л дээ.

Нөгөө сайн чанарын коксжсон нүүрс биш.

Нүүрс чинь 2030 оноос хойш хэрэглээ нь багасах, үнэ нь буурах ийм нөхцөл байдалтай тооцооллууд байгаа.

Тэгэхээр Засгийн газрын хувьд ч гэсэн ер нь энэ нүүрснийхээ үнэтэй байгаа үед нүүрснийхээ төслүүдийг амжилттай хэрэгжүүлье гэж байгаатай нь уялдуулаад Улаанбаатар хот нүүрсний Улаанбадрахын талбайг ашиглаад тодорхой хэмжээнд мөнгө босгоод түгжрэлийн асуудлууд, бусад төслүүдийг хөдөлгөөд явбал бас улсын төсөвт ачаалал болохгүй байх, орон нутгийн төсвийн хэдхэн орлогодоо тулгуурлахгүй байх боломж бүрдэх гээд байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ ер нь Их Хуралд холбогдох шийдвэр гаргуулах үүднээс оруулж ирээд түр хороон дээр ярих шаардлага байгаа. Хүмүүс янз бүрийн байдлаар шийдвэр гаргахаас айдаг, болгоомжилдог болчихсон цаг үе байна.

Гэтэл асуудал, шийдэл маань хөрөнгө санхүүтэй холбоотой байгаад байдаг. Боломж нь байгаад байдаг.

Тэгэхээр шийдвэр гаргах эрх зүйн орчин, суурь нь тавигдчихсан байгаад байдаг.

Тэгэхээр энэ дээр зоригтой хөдлөөд, асуудлаа яриад ингээд явах юм бол бид хөрөнгө санхүүгийн хувьд боломжтой болчихвол энэ төслүүд хэрэгжих боломж байгаа. Манай түр хорооны хувьд ч гэсэн олон асуудлуудыг ярьж байсан. Өмнө нь. Зарим нь хэрэгжихгүй байгаа чинь ерөөсөө л энэ төсөв мөнгөтэй л холбоотой шүү дээ.

Энэ 420 тэрбум гэхэд л манайхан чинь авчихсан гэж ойлгоод байгаа шүү дээ.

Гэтэл өнгөрсөн жилийн олгосон гээд байгаа 420-ийг чинь гүйцэд аваагүй байгаа. Энэ жил хасчихсан байсан.

Харин сая Засгийн газар Улаанбаатар хотод өөрийнх нь эх үүсвэрээр, тэр 187 тэрбум яаралтай шаардлагатай байгаа эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийн гаргалгааг гаргаж өгч байгаа.

Энэ мэтээр таны түрүүний хэлдгээр энэ асуудлуудаа явуулна.

Мэдээж хэрэг хяналттай, ил тод байх зарчмыг бид баримталж байгаа. “Эрдэнэс Тавантолгой” дээр хүртэл бид нэлээн дэвшилттэй арга хэлбэрээр ажиллаж үр дүн гарч байгаа ч юм байна.

Тийм учраас төслүүдээс айх биш үүнийг явуулах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Э.Бат-Амгалан: Ж.Сүхбаатар сайдад баярлалаа.

Ерөнхийдөө яах вэ ингэж ойлголоо. Энэ түвшин түвшиндээ мэдээллүүдээ маш хурдтай солилцож, энэ нийслэл Улаанбаатар хотын өнөөгийн тулгамдаад байгаа түгжрэлийн асуудал, энэ төвлөрлийн асуудал дээр Та бүхэн минь өөрсдөө санаачилга гаргаж, ялангуяа хотын холбогдох удирдлагууд санаачилга гаргаж, Их Хурал дээр түр хороо байгааг Та бүхэн ашиглаж хурдтай ажиллах шаардлагатай байна.

Ж.Сүхбаатар сайдын хэлснээр би ингэж ойлголоо. Ойрын хугацаанд Улсын Их Хурал дахь Улаанбаатар хотын

хөгжлийн бодлого эрхэлсэн түр хороогоор энэ асуудлыг оруулах нь.

Эхний ээлжид хотын гишүүддээ танилцуулъя. Ингээд шаардлагатай бол Их Хурлын даргад танилцуулъя. Ингээд асуудлуудаа хурдтай явахгүй бол ерөөсөө бид нэг яриад байдаг, яриад байдаг. Тэгээд хэдэн тоотой, хэдэн цаастай, нэг судалгаатай, нэг зовлон ярьсан ийм л улсууд үлдэж байна шүү дээ.

Тэгэхээр мэдээж Улаанбаатар хот гэж Монгол Улсын 50 хувь нь амьдарч байгаа энэ том нийслэл хотод гадна дотнын зочид, жуулчид, төлөөлөгч, ер нь гаднын хүмүүсийн нүдийг хужирлах ганц газраа бид зоригтой шийдвэрүүд гаргаж, энэ дээр өчигдрийн тэр Улаанбаатар хотын Засаг даргын ярьж байгаа нэлээд гаргалгаатай шийдлүүд гаргаж байх шиг байсан.

Тийм учраас үүнийг түр хороогоор оруулж Их Хурал дээр тодорхой хэмжээнд хэлэлцэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Ж.Сүхбаатар дарга хариулах уу. 1 минут 45 секунд.

Ж.Сүхбаатар: Таны хэлсэнтэй санал нэг байгаа.

Ер нь хотын удирдлагаас асуудал тавьж байгаа. Би Үндэсний хороог даргалж байгаа учраас энэ асуудлыг явуулья гээд.

Тэгээд ер нь яригдаж байгаа гол асуудал нь ойлголцол, хууль зүйн орчинд яаж явуулах вэ гээд яригдаад явж байгаа юм бий. Ер нь төслийг хурдан явуулах үүднээс түргэтгэх шаардлага байгаа.

Тийм учраас таны хэлснээр түр хороонд оруулж ирэх талд нь ажиллая гэж бодож байна.

Тэгээд Улсын Их Хурлын дарга энэ асуудал дээр одоо бидний түр хороог дэмждэг. Тэгээд Улаанбаатар хотын асуудлууд дээр Их Хурлын даргын зүгээс түгжрэл бууруулах чиглэлд үүрэг даалгаврууд өгдөг.

Тэгээд би бас энэ тал дээр Улсын Их Хурлын дарга анхаараасай гэж бодож байна. Бидний зүгээс өөрсдийнхөө шалтгаалах зүйлүүдийг хийгээд, зүтгээд, хичээгээд явъя гэж хэлэх байна.

Г.Занданшатар: Ер нь Улаанбаатар хотын түгжрэлийн асуудал нийслэлийн хамгийн том тулгамдсан асуудал болсон.

Үүний алдагдсан боломжийн өртөг, цагийн үнэлгээ хэдэн их наяд төгрөгөөр хэмжигдэнэ.

Эрх зүйн орчны хувьд Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, нэгжийн хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн суурь хуулиудаар эрхийг нь нээгээд өгчихсөн гэж Ж.Сүхбаатар сайд сая хэллээ.

Одоо гагцхүү том даацтай бодлого, шийдвэрүүдийг зоригтой хэрэгжүүлж энэ түгжрэлийг бууруулах асуудлаар хөрөнгө, хүч зарцуулж ажиллах шаардлагатай.

Өнөөдөр даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн түр хороо, Э.Бат-Амгалан даргатай, энэ нийслэлийн түгжрэлийг бууруулах цогц асуудлаар цогц шийдэл гарч гэсэн хэлэлцүүлэг асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа.

Тэнд нь нийслэлийн дүүргийн дарга Ж.Алдаржавхлан энэ дүүргүүдийг хотод болох төвлөрлийг сааруулах, дистрикт болох. Саяын зөв эргэлт дистрикт, сургуулийн тойрог, эмнэлгийн тойргуудыг оновчтой хуваарилах, төрийн үйлчилгээг оновчтой хуваарилах тийм санал санаачилга танилцуулья гэж санаачилга гарсан. Үүнийг хэлэлцэнэ.

Энэ дээрээ саяын яриад байгаа тэр уул уурхайн эх үүсвэрийг ашиглаж Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах. Тэр Улаанбадрахын. 2030 оноос хүрэн нүүрс ашиглалтаас гарах гээд байна шүү дээ.

Тэгэхээр тэрийг амжиж ашигладаг юм уу. Ашиглаад, эргэлтэд оруулаад ингээд бүх бололцоог ашиглах.

Хууль эрх зүйн орчин Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар концессын ч тэр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн ч гэсэн бүх эрх зүй нээгдсэн байгаа. Ж.Сүхбаатар сайд аа. Тийм ээ.

Тэгээд үүнийгээ яриад шийдэл боломжтой. Корпорацын хэмжээнд ажиллана гэж байгаа шүү дээ.

Үндсэн хуулийн 58.1-ийн үзэл санаа ч гэсэн Б.Чимид гуай **“нийгэм, эдийн засгийн цогцолбор гэдэг бол “корпорац” гэдэг үгийг, “corporate body” гэдэг үгийг би алдаатай орчуулчихсан байна лээ**” гэж хэлж байсан.

Тэр нь засаг захиргааны нэгж бол эдийн засгийн цогцолбор байна. Тэр үед сум ч гэсэн сум, нэгдэл гэдэг корпорац, корпоратив шинж чанартай ийм нэгж, нутаг дэвсгэрийн нэгж, хотын зохион байгуулалт байсан.

Энэ нь одоо алдагдчихаад сум, орон нутаг, аймаг, нийслэл бүгдээрээ зүгээр ингээд нутаг дэвсгэрийн зохион байгуулалтаар ажиллаад байгаа болохоос биш корпорацын, эдийн засгийн нэгжийн утгаар ажиллаж байгаа юм хаягдсан.

Үүнийг л өөрчлөх гэж нэгжийн хууль хийсэн юм шүү дээ.

Тийм учраас одоо тэр гурав дахь өдрийн хэлэлцүүлгээрээ тэр хүрэн нүүрсний ордоо ашиглана уу, тэр Баянбогд, Ар Богд, энэ Улаанбаатар хот дундуураа ачааны юугаа явдаг улс, нийслэл дундуураа хэд байдаг юм. Үүнийг тойруулах.

Түүгээр нь хурдны зам, магистрал тавих, метро барих. Тэгээд даацтай шийдлүүдээ гаргахгүй бол одоо энэ 2026, 2027 оноос чинь бараг тэг зогсолт хийх юм байна лээ шүү дээ. Энэ улс чинь.

Хүн ам нь өсөөд байна. Улаанбаатартаа төвлөрөөд байна. Тэр алдагдсан боломж, эдийн засгийн өртөг ямар байна. Тэрийг дагаад нийгмийн бухимдал, стресс ямар байна. Хүний эрүүл мэндэд яаж нөлөөлж байна. Агаарын бохирдол.

Тэгээд энэ дээр зоригтой шийдэл, шийдвэр хэрэгтэй.

Тийм учраас үүнийгээ түр хорооны хурлаараа ирэх гурав дахь өдөр хэлэлцээд ингээд энэ бүх асуудлаа нэг цогцоор нь шийдэл хийгээд. Бас хариуцсан сайдтай болсноор, анхаардаг сайдтай болсноор ахиц дэвшил гарч байна гэж бодож байгаа.

Нэг хүн хүүе, хаая гээд яваад байдаг. Юмнуудыг уялдан зохицуулдаг. Тэгэхгүй бол тэнд боловсролын асуудал нэг тусдаа, энд эрүүл мэндийн асуудал

үйлчилгээ тусдаа, тэнд авто зам, тээврийн асуудал тусдаа.

Ингээд Улаанбаатарын түгжрэл, төвлөрөл чинь нэгдсэн цогц шийдэлгүй яваад байгаа байхгүй юу. Эднийг уялдуулж түр хороон дээр ярих хэрэгтэй.

Гурав дахь өдрийн хуралдаанаар хэлэлцэх чиглэл өгч байна.

Тамгын газар, Г.Агар-Эрдэнэ дарга хуваарьтаа гурав дахь өдөр оруулчихсан байгаа. Тийм ээ. Даргын дэргэдэх зөвлөлөөр.

Одоо Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа Засгийн газрын гишүүнээс асуулт асууна.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хурал удирдана.

С.Одонтуяа: Тэгэхээр иргэдээс хэдэн асуулт асуусныг би эхлээд танилцуулчихаад дараа нь өөрийнхөө асуултыг асууя.

Нэгдүгээрт, Бадрахын Ичинхорлоо, Увс аймгийн Давст сумаас.

Улаанбаатарт бүсчилсэн татвар тогтоох нийтийн тээврийг хүртээмжтэй болгох дээр яг ямар ажил хийж байна вэ?

Ёндонжамцын Энхтөр, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо.

Таны бодлоор дүүжин тээвэр, LRT, метро гурвын аль нь алсдаа Улаанбаатар хотод хэрэгтэй гэж үздэг вэ?

Улаанбаатар хотод бүсчилсэн татвар тогтоож, нийтийн тээврийг сайжруулан, төвийн бүсүүдэд машин

хэрэглэхийг бууруулж, түгжрэлийг багасгах арга замыг хэрэгжүүлэх нь хэр зохистой гэж үздэг вэ гэсэн ийм асуулт байна.

Түрүүний тэр Пэлжээгийн Туяа гэж хүний асуултыг Э.Бат-Амгалан дарга асуусан болохоор үүнийг нь орхичихъя.

Л.Мөнхбаатар: Ж.Сүхбаатар сайд хариулья.

Ж.Сүхбаатар: Увс аймгийн оршин суугч маань маш чухал асуудлыг тавьж байна.

Тэгээд ер нь энэ түгжрэлийн асуудлыг хариуцаад ирэнгүүт яг шийдлүүдээ харсан. Хотуудын зовлон, бэрхшээл, шийдлүүдийг харсан. Тэгээд хамгийн чухал арга нь эдийн засгийн үл үзэгдэгч гар гээд байдаг зохицуулалтын гол хэрэгсэл нь ерөөсөө төлбөрийн систем л байгаа юм л даа. Төлбөр хураамж авдаг.

Тэгэхээр яг түгжрэл дээр хэт ачаалалтай. Үнэхээр түгжрэлд орчихсон хот мөн юм бол яг хийж байгаа тэр улс орнууд ямар арга хэмжээ 20 жилийн өмнөөс авч байв гэхээр зэрэг яг л бүсчилсэн төлбөртэй хэсгийг бий болгочхож байгаа юм. Жишээлбэл, Лондоны тэр яриад байгаа **“Congestion Charge Zone”** гээд байгаа. Тэр нь **“түгжрэлийн төлбөртэй бүс”** гэж.

Тэгээд энэ аргаар Лондон, Стокхолм ч гэдэг юм уу, одоо Манила ч гэдэг юм уу, ингээд Сингапур ч гэдэг юм уу эд нар эдийн засгийн арга механизмаар. Амстердам ч гэдэг юм уу ингээд явсан юм байна.

Мэдээж эхний үед тогтооход хүнд байсан юм билээ. Энэ асуудал дээр. Шүүхэд хүн өргөдөл, гомдол гаргахаас

авхуулаад эсэргүүцсэн үйл ажиллагаа энэ тэр гээд.

Гэхдээ одоо бол яг тэр хотууд 15-аас 20 жилийн хугацаанд үүнийгээ хийгээд асуудлууд нэлээн амжилттай шийдээд.

Тухайн үедээ зорьж байсан түгжрэлийг 20 хувиар бууруулна гэж байсан бол 30 гаруй хувиар буурч байсан.

Одоо жишээлбэл Лондонд 18 хувийн нөлөөлөл үзүүлдэг гээд л статистик байх жишээтэй.

Тэгэхээр иргэн таны хэлж байгаа санал дээр бид хуулийн төсөл бэлтгэгдчихсэн байгаа.

Хамгийн гол нь илэн далангүй хэлэхэд хүмүүст ойлгуулах талд нь анхааръя гээд Засгийн газарт танилцуулахаас өмнө тодорхой хэмжээнд бид бага сага хүмүүст мэргэжлийн тодорхой хүрээ хүрээнд нь тайлбарлах ажлуудыг хийж байгаа.

Би Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд хоёрт Засгийн газрын бараг хуралдаан болгон дээр л үүнийг хэлж байгаа. Удахгүй оруулж ирнэ гээд.

Эхлээд Засгийн газрын босго давна гэдэг нэг том асуудал байгаа. Засгийн газар дээр мэдээж иргэдийн санал, шүүмжлэлийг харж байгаа.

Гэтэл өнөөдөр манай улсууд харж байна шүү дээ. Иргэн хүн өөрөө түгжрэлтэй бүсийн асуудлаар төлбөр хураамж авах нь зүйтэй гэдэг агуулгаар би асуудал тавьж байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ яах аргагүй бусад орнуудын хийдэг. Тэгэхгүй ямар нэгэн

захиргааны бусад аргууд хэтэрхий муйхар гэдэг юм уу, шүүмжлэлд их өртдөг. Эцсийн дүндээ шударга бус болчихоод байдаг юм билээ. Эцсийн дүндээ хотын төв хэсэг нь татвар төлбөрөөр л өндөр болоод л. Тэгээд л хотын зах хэсгүүд хөгждөг ийм номтой.

Түүнээс биш хотын төвөө ийм механизм хийхгүйгээр албадаад л, нүүлгээд л, хөөгөөд, туугаад, эсвэл хязгаарлаад энэ асуудлууд шийдэгддэггүй нь дэлхий дахины тогтсон зарчим юм билээ.

Тэгэхээр энэ чиглэлээр бэлэн төсөл өнгөрсөн хугацаанд бэлтгэгдчихсэн. Манай урд сууж байгаа ажлын хэсгийн нөхдүүд дотроос энэ дээр ажиллачихсан улсууд байж байна.

Одоо удахгүй би Хууль зүй, дотоод хэргийн сайдтай энэ асуудлаар эцсийн байдлаар зөвшилцчихвөл Эдийн засгийн хөгжлийн, Сангийн сайдын эд нарын тавьж байгаа асуудал дээр ойлголцох асуудал дотроо байгаа юм.

Түүнээс энэ жишиг, шийдлээс би ухрахгүй. Үндэсний хорооныхоо веб сайтад тэгж байгаад тавина.

Тэгээд Засгийн газрын босгыг давах, Их Хурлын босгыг давах, иргэдийнхээ санал шүүмжлэл дундуур, хэлэлцүүлэг дундуур явах асуудлууд байгаа.

Тийм учраас миний байр суурь энэ бол хамгийн зөв шийдлүүдийн нэг гэж үзэж байгаа.

Мэдээж зарим хүн амьдрал хэцүү байгаа үед төлбөр, хураамж авах гэлээ гэж байгаа. Гэхдээ ядаж тэгвэл эхний ээлжид нь нийслэлд нь тэр эрхийг нь л зүгээр өгчихье.

Хэзээ хэрэгжүүлэх нь тусдаа асуудал байж гэж тооцож байгаа. Түүнээс Засгийн газар үүнийг шууд шийдэхгүй. Нийслэлийн удирдлага шийднэ.

Хоёр дахь асуудал нь, дүүжин тээвэр, LRT, метро аль нь дээр вэ гэхээр Үндэсний хорооны даргын хувьд LRT буюу тэр хөнгөн галт тэрэгтэй холбоотой асуудлыг илүү хотын өөрийнх нь хариуцаад эх үүсвэр боломжоороо яваг.

LRT, метро хоёр маш өндөр үнэтэй, өртөгтэй төсөл. Метро нь хамгийн өндөр өртөгтэй төсөл байгаа.

Тэгэхээр хөрөнгийн боломжоор багаасаа их рүү гэдэг зарчмаар явъя гэж.

Би өөрөө Үндэсний хорооны даргын хувьд дүүжин тээвэр BRT төсөл дээр нь Засгийн газрын оролцоо гэдэг утгаараа илүү анхаарал тавьж энэ хоёр төсөл санхүүжилтийн хувьд ерөнхийдөө шийдэгдчихсэн. Хэрэгжих боломж, цаг хугацааны хувьд наана нь байх боломжтой учраас үүнийгээ хэрэгжүүлье.

Улс орнуудын дараалал ер нь тийм л дээ. Хамгийн боломжтойг эхлээд.

Тэгээд манай нийтийн тээврийн салбар уналтад орчихоод байгаа болохоор дараачийн. Эд нар чинь уг нь ер нь дараачийн арай дэвшилттэй хэлбэрүүд шүү дээ.

Тэгэхээр нөгөө нийтийн тээврийн салбар нь уналтад орчихсон болохоор чинь түүнтэйгээ л ноцолдох болчихоод байгаа байхгүй юу.

Түүнээс биш нийтийн тээвэр маань хэвийн байсан бол шууд LRT, метроны асуудал руу шууд орж болж байгаа.

Гэхдээ метрон дээр түрүүн Ч.Батзориг төслийн захирал хэлсэн. Хотын дарга иргэдийн санаа бодол, олон хүний санаа бодлыг үндэслээд энэ чиглэлээрх ажлаа метрон дээр шийдлүүдийн хөнгөн, хүнд гэдэг хэлбэрээрээ ангилаад ажлын хэсэг ингээд ажиллаж байгаа гэж байна.

Би Үндэсний хорооны даргын хувьд бүх асуудал руу нь хутгалдан орохгүй байх зарчим баримталж байгаа. Бас нийслэл гэдэг чинь өөрийн удирдлагатай айл учраас Засгийн газрын оролцоо ямар түвшинд, ямар хэмжээнд байх вэ гэдгээ бас тодорхойлж явж байгаа.

Л.Мөнхбаатар: Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр ер нь аливаа нэг асуудлыг шийдэх улс орны хөгжилд засгийн эрхийг барих, нийслэлийн эрх гээд. Энд улс төрийн нам л засагладаг байхгүй юу. Улс төрийн нам би ийм юм хийнэ гээд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлээд сонгуульдаа ялдаг.

Тэгээд 2016 онд “**Аз жаргалтай Улаанбаатар**” гээд сайхан тийм мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн.

Тэгээд 2016 оноос тэр төсөл, хөтөлбөр нь би бол хэрэгжээгүй л гэж хардаг юм. Тэгээд яаж 2020 онд ялчихсан юм.

Үнэхээр эсвэл одоо надаас бусад нь тийм аз жаргалтай байгаа юм уу?

2020 онд “**Түгжрэлгүй Улаанбаатар**” гээд төсөл яасан? Яах вэ Ж.Сүхбаатар сайд үүнийг шийдэх гээд л янз бүрээр ажиллаж л байна л даа.

Захаасаа тэр Зайсангийн уулзвар. Тэр үр дүн харагдаж л л байна.

Тэгэхдээ ер нь зүгээр нэг юмыг нэг цогцоор нь шийдэхгүй болохоор ингээд л бүх юман дээр. Ингээд л өнөөдөр бид энэ чуулганыхаа танхимд шалтаг яриад суугаад байгаа нь өөрсдөө их утгагүй асуудал л даа.

Иргэд бид нараас чинь шийдэл хүсээд байгаа байхгүй юу. Шийдэл хүсээд байгаа юм. Тэгж бүх юмыг нь эндээс гараад л бүгдээрээ буруу хийгээд л орж ирээд л дахиад л шийдлээ. Жишээлэхэд, одоо энэ том том орон сууцын хорооллуудыг бид сүүлийн хэдэн арван жил л ийм хороолол барихаа больё гээд л ярьж байгаа шүү дээ.

Сургуульгүй, цэцэрлэггүй. Тэгээд л хүүхдээ хол зөөнө. Үгүй тэгээд л баригдаад л байна шүү дээ. Одоо бүр “Авлигалын хороолол” гээд нэртэй хүртэл хорооллууд байж байна.

Манай “Алтай хотхон” 2500 өрхтэй. Нэг ч сургууль байхгүй. Тэгээд л хүүхдүүдээ зөөж байна гээд л бөөн түгжрээ. Гэх мэтчилэн.

Тэгэхээр би бол энэ нам өөрийнхөө хийсэн мөрийн хөтөлбөрийг биелүүлэхийн төлөө л зүтгэх ёстой гэж бодож байна.

Тэгээд би зүгээр жишээ хэлье л дээ. Бас дандаа юм бүтэхгүй байдаг юм биш. 2012-2016 онд Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр Японд төгссөн мэргэжилтнүүдийг авчраад ер нь Улаанбаатарын түгжрэлийг яг яаж бууруулах юм бэ гээд маш сонин концепцууд гаргасан.

Тэгээд ерөөсөө энэ хотыг аль болохоор сетклээд, дөрвөлжлөөд

“Гудамж төсөл” гэдэг юмыг хийгээд ерөөсөө л аль аль тийшээ нэвт гараад л байх юм бол энэ түгжрэл чинь багасна гээд л маш олон гудамжнуудыг сэтгэлсэн. Үр дүн гарч л байсан.

Энэ чинь шинээр зам тавих гээд, гүүр барих гээд байгаад биш. Одоо 1 дүгээр сургуулийн хажуугийн зам байна.

Баянгол дүүрэг дээр түгжрэлийг цогцоор нь шийдэж өгсөн шүү дээ. Манай Баянгол чинь маш их иргэд, хүн ам ихтэй. Ерөөсөө байнга түгжирч байдаг.

Гэтэл энэ 33 уулзварын 11 уулзварыг нь Баянгол дүүрэгт хийсэн. Тэгээд энэ уулзваруудын нэвтрэх чадвар сайжраад одоо тэр түгжрэл нь буурсан шүү дээ. Хэрвээ тэр 11 уулзварыг Н.Батбаяр сайд Чингис бондоос зоригтой мөнгө гаргаад л хийгээгүй бол өнөөдөр Баянгол дүүрэг зүгээр таг түгжирчихсэн л байж байгаа.

Тэгэхээр ийм туршлагауд бас байгаа шүү. Энэ хийж чадсан, болж байгаа зүйлүүдээ та нар бас аваад хийгээд байгаасай гэж Ж.Сүхбаатар сайдад хүсэж байна.

“Алтай хотхон” дээр түгжрэл гараад үүнийг шийдэх гэж оролдсон боловч иргэд нь эсэргүүцэл үзүүлээд манай “Алтай хотхон”, “Нарны хороолол” дээр ингээд нэлээд асуудал үүссэн.

Тэгэхээр үүнийг орхимгүй байна. Дахиад иргэдтэй нь шаардлагатай гэвэл та бид гишүүд нь очоод энэ хоёр хотхоныхонтой хамт сууж байгаад энэ хавийн түгжрэлийг бас шийдэх хэрэгтэй байна.

Түүрүүн маш олон хүн хэллээ. Та өөрөө хэллээ. Энэ нэг ийм софт аргыг хэрэглэе гэж. Жишээлэхэд, энэ түгжрэлийг үүсгээд байгаа чинь сургуулийн хүүхдүүд бас нэлээн хэсгийг үүсгэж байгаа.

Тэгэхээр одоо манай “Алтай хотхон” дээр би танд хэлсэн шүү дээ. 1, 2, 3 дугаар ангийн хүүхдүүд нэг л багш заадаг учраас хотхонд нь яамтай ярьж байгаад энэ бага ангийн сургалтуудыг нь аваад байж болдоггүй юм уу? Тэгвэл энэ хүүхдүүдийг чинь зөөдөг машин тэрэг, ээж, аав ингээд явахгүй.

Тэгэхээр үүнийгээ одоо тэр Боловсролын сайдтай яриад тэр судалгааг нь аваад хийж хэрэгжүүлэх тал дээр урагштай юм болж байна уу гэдгийг та нэг хариулаад өгөөч.

Бас нэг асуулт нь иргэд энэ скүүтер дугуйгаар их явмаар байх юм.

Тэгээд энэ зогсоолууд хэрэг болоод байна. Яагаад гэхээр зогсоолтой болохоор очоод түгжчихдэг юм байна л даа. Түгжихгүй болохоор л юмаа хулгайд алддаг.

Тэгэхээр скүүтер дугуйг очоод хүн байгууллагын гадаа ороод нэг цоожилчихдог ийм жижигхэн зогсоолуудыг аль болох хийх юм бол бид скүүтер унаад явж болж байна гэсэн ийм зүйл байна. Эхлээд хариултаа авах уу.

Л.Мөнхбаатар: Ж.Сүхбаатар сайд асуултад хариулъя.

Ж.Сүхбаатар: Манай улсууд маань дараа нь нэмж хариулаарай.

Тэгэхээр таны хэлдгээр яг л нөгөө шинээр барих замаасаа илүүтэй Ерөнхий сайд нэг зүйл дээр ач холбогдол өгсөн

байгаа. Манай Үндэсний хороо ч гэсэн саналаа танилцуулсан юм нь энэ холбоос зам буюу уулзвар, туслах замуудын асуудал дээр анхаарал хандуулж байгаа. Ер нь холбогддог байя.

Өнгөрсөн 2016-2021 онд жишээлбэл 300 гаруй километр зам баригдсан байгаа. Улаанбаатарт.

Гэтэл тэрний 10 хүрэхгүй орчим нь л яг түгжрэлд нөлөө үзүүлэхүйц замууд байгаад байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө харах юм бол дандаа олон газар манай замууд хоорондоо холбогдохгүй байдал үүсчхээд байгаа.

Тийм учраас 225 километр замыг холбоос зам дээр бид Засгийн газар анхаарч хандах ёстой юм байна гээд энэ 187 тэрбум төгрөгийн нэн шаардлагатай эх үүсвэрийг Улаанбаатар хот тэр нөхцөлийг бүрдүүлье гээд өнгөрсөн долоо хоногоос бид ажиллаж байна л даа.

Тэгээд энэ бол яг л нөгөө түрүүний гудамж, уулзвар гээд Н.Батбаяр сайдын үеийн хийж байсантай бодвол илүү өргөн хүрээтэй ийм юм хийгдэх юм.

Зүгээр тэр “Гудамж төсөл”-ийн хүрээнд хийгдсэн уулзварууд чухал ач холбогдолтой юу гэвэл чухал ач холбогдолтой байгаа. Зүгээр зарим нэг хэсгүүд нь яах вэ, манайдаа одоо нийцэхгүй гэдэг юм уу, сөрөг үр дагавар дагуулсан юм бол байгаа. Ерөнхий дүнгээрээ ач холбогдолтой болсон.

Гэхдээ Чингис бондын эх үүсвэрээр санхүүжүүлсэн. Тухайн үедээ буруу, зөв гэдэг асуудал тусдаа асуудал байгаа. Өндөр үнэтэй бондын юугаар хийгдсэн гэдэг асуудал байгаа. Мэдээж

түгжрэл дээр олон газарт эерэг үр дагавар дагуулсантай санал нэг байна.

Хоёрдугаарт, “Алтай хотхон”, “Нарны хороолол”-ын асуудал дээр иргэд нь ч надад асуудал тавьдаг. “Алтай хотхон”-оос. Та ч асуудал тавьдаг.

Тэгээд яах вэ манай хэд маань арай өргөн хүрээтэйгээр “Алтай хотхон”, “Нарны хороолол”-оос гадна төв замын ачааллыг бууруулахтай уялдуулаад ингээд арга хэмжээнүүд төлөвлөсөн байсан.

Үүнийгээ хийх эхний оролдлогыг манай хотын нөхдүүд маань хийгээд тэгээд яах вэ, иргэдийн.

Угаасаа л тэр нэлээн эсэргүүцэлтэй тулна л даа. Тэгээд яах вэ, тэр эсэргүүцэл дээр манайхан үндэслээд.

Би эсэргүүцэл гэж үзэхгүй байгаа юм бас. Эдний санаа бодлыг нь эхлээд сайн сонс оо. Хүслийг нь сонс оо. Бодлыг нь сонс оо. Юм аа тайлбарла аа. Тэгээд түр хойшлуулаад ингээд дараагийнхаа арга хэмжээг ав гэж.

Гэхдээ ер нь тэр дээр газар, замынх нь талаас нь заавал том хэмжээний өөрчлөлт хийхгүйгээр хийж болох юмнууд байгаа бас юм шиг байна лээ.

Тэгэхээр манай хэд энэ дээр тодруулаад нэмээд хэлээрэй.

Би таны хэлснээр чинь их олон удаа замын цагдаа, Замын хөдөлгөөн, удирдлагын төв, манай энэ төслийн захирал Ч.Батзориг эд нарт их олон удаа хэлсэн. “Алтай хотхон” дээр ажиллая гэж ярьсан байж байгаа.

Тэгэхээр энэ дээр та хэд маань бодож байгаа нөгөө төлөвлөсөн юмнуудаа хэлмээр байна. Тийм. Нөхцөл байдлыг.

Том, жижиг шийдлүүд байж байна шүү дээ. Нэг бол томоор шийдэх гэж сая бид хэд оролдсон. Одоо бусад аргуудыг хэрэглэж болно. Бүр болохгүй бол. Тийм.

Хэн нь эхлээд хариулах вэ. Тийм ээ. 81 юм байна. “Замын хөдөлгөөний удирдлагын төв”-ийн захирал.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Албан тушаалд нэрээ хэлээд гишүүний асуултад хариулаарай.

С.Адъяасүрэн: “Замын хөдөлгөөний удирдлагын төв”-ийн захирал С.Адъяасүрэн.

“Нарны хороолол”-ын талаар “Алтай хотхон” “Нарны хороолол” гэсэн хоёр том хороолол байгаа. Үүний хөдөлгөөн зохион байгуулалтыг зүүн болон буцаж эргэх эргэлтийг хязгаарлаж шийдвэрлэх ийм зорилготой байсан.

Бид 3 хоногийн хугацаанд ямар ч байсан туршилт хийсэн. Туршилтын үр дүнг товчхон танилцуулчихъя.

Ер нь уулзварын нэвтрүүлэх чадвар 3832 цагт байсан бол 5022 буюу 23.7 хувиар сайжирсан.

Тэнцвэртэй зорчилт буюу гэрлэн дохионы асах давтамж өдөрт 378 удаа байсан бол 532 удаа болж, 71 хувиар илүү зорчилт бий болгож сайжирсан.

“Өгөөж”-ийн уулзварт 9.4 хувийн эерэг үр дүн нэвтрүүлэх чадварыг нь сайжруулсан. Баруун 4 замын уулзварт 12.1 хувийн ийм эерэг нөлөө үзүүлсэн.

Тэгээд бид яг түр хугацаанд зогсоочоод байгаа. “Нарны хороолол” болон “Алтай хотхон” хоорондоо зорчих зорчилтын замыг нь гүүрэн доогуур нь нөхцөлийг нь сайжруулах. Шинээр баригдахаар зам төлөвлөчихсөн байгаа. Энэ замыг яаралтай барьж оруулах юм бол энэ ажлуудаа үргэлжлүүлээд явна гэсэн тооцоод байгаа.

Ер нь үүнийг хийхгүй бол Улаанбаатар хотын хамгийн их ачаалал авдаг уулзвар нь энэ “Механик, тээврийн сургууль” “Төв шуудан”-гаас илүү ачаалалтай ийм уулзвар байдаг юм.

Тэгээд үүнийг шийдэх юм бол бас тодорхой үр дүн гарна гэж тооцож байгаа. Өмнө нь Зайсангийн уулзвар, 120-ын уулзвар бас масс уулзвар, ачаалал авдаг уулзвар байсан. Одоо энэ асуудал нэлээн багасаад бусад уулзваруудтай адил хэмжээнд очсон байгаа.

Тэгэхээр нарны гүүрэн доогуур байгаа хөндлөн зам дээр эгнээ нэмэх, шинээр зам барих асуудал нь шийдэгдчих юм бол энэ ажил ахиад цаашдаа явна.

Ингэхгүй бол энэ намраас эхлээд машины тоо даацаасаа хэтрээд тэгээд Улаанбаатар хот тэг зогсолтод хүрэхэд тун ойрхон байгаа. Үүний гол шалтгааны нэг нь энэ “Механик, тээврийн сургуул”-ийн уулзварын асуудал өөрөө байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс нэмж хариулж болно. 82 уу? 82 дугаар микрофоныг өгье.

М.Баяраа: Улаанбаатар хотын ерөнхий менежер М.Баяраа гэж хүн байна.

Сүүлийн асуулт буюу тэр скүүтер болоод дугуйн зам, дугуйтай холбоотой зогсоол байгаа.

Шинээр баригдаж байгаа. Түрүүн Ж.Сүхбаатар сайдын танилцуулга дээр гарсан дугуйн зам дээрх тохижилтын асуудлыг Улаанбаатар хот цогцоор нь хийгээд явна. Камертай. Дугуйн болон скүүтрийн зогсоолыг шийдэхээр төлөвлөчихсөн цогц шийдэлтэй явж байгаа.

Яг томоохон дэлгүүр болоод супермаркетууд аж ахуйн нэгж дээр 50 метрийн орчны тохижилт үйлчилгээ гэдэг ажил өөрсдөд нь үүргээр өгөгдөөд хуулиараа ингээд явж байдаг.

Тэгэхээр энэ дээр бид хяналтаа тавиад явна гэж бодож байгаа. Тухайн үйлчилгээний байгууллагууд, төрийн байгууллагуудын гаднах тохижилтын асуудал дээр өмнө нь нэг их анзаардаггүй байсан. Үүнийг сайжруулаад явна.

Хуучин хийгдчихсэн байсан 72.5 километр дугуйн зам дээр нөхөж хийх асуудлуудыг хийнэ. Тийм.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс нэмж хариулья. 85 уу?

Г.Баярсайхан: Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Ганболдын Баярсайхан.

Салдангийн Одонтуяа гишүүний асуултад нэмээд хариулчихъя.

“Алтай хотхон”-оос баруун тийшээгээ далан дагаад нэг зам одоо эхэлчихсэн байгаа. Шороон даланг авто замаар хучих гээд нэг ажил эхэлчихсэн байгаа.

Дээрээс нь нэмээд зүүн талд нь Нарны гүүрийг буугаад буцаж эргэх Дема гээд эмнэлгээр буцаад гүүрэн доогуураа “Нарны хороолол” руу орох 2 зам зураг төсөл нь хийгдчихсэн. Ажил нь “Их Богд зам” гээд замын ажил нь эхэлчихсэн байгаа. Нөгөөдөх нь энэ жил ажлыг нь зарлах юм.

Л.Мөнхбаатар: Салдангийн Одонтуяа гишүүн нэмж асууя.

С.Одонтуяа: Тэгээд мэдээж хотын түгжрэл, энэ том асуудлыг цөөн минутад бүгдийг нь асууж мэдээж хариулж барахгүй.

Тэгэхээр ер нь ард иргэд сонгуулиар саналаа өгдөг. Ингээд ялсан нам нь мөрийн хөтөлбөрөө дэвшүүлдэг байгаа.

Тэгэхээр бид энэ мөрийн хөтөлбөр дээр түгжрэл 2020 онд 9 зүйл заалт байсан. Энэ 9 зүйл, заалтыг хэр биелүүлж байна. Улаанбаатар хотын иргэд энэ “**Аз жаргалтай Улаанбаатар**” төсөл нь хэр хэрэгжиж байна.

Хэдэн онд билээ. Метро тавина гээд баахан сониноор зарлачихсан байсан. Тэр метро нь хэзээ болох гэж байна гээд. Энэ амлалтуудыг л ард түмэн нэхнэ.

Тийм учраас энэ амласан амлалтаа биелүүлэхийн төлөө л ажиллах ёстой.

Өнөөдөр үнэхээр ард иргэдийн хамгийн бухимдаж байгаа, стресстүүлж байгаа асуудал яах аргагүй л түгжрэл байгаа.

Тийм учраас энэ түгжрэлийн асуудлыг одоо мэдээж яг бүр нэг зөв зүйтэй шийдье гээд тусгайлан сайд

хариуцаж авч байгаа учраас би үр дүн гарах болов уу гэж горьдож байна.

Тэгээд энэ дээр бүгдээрээ сайн ажиллах хэрэгтэй. Маш олон иргэд одоо бүр та нарын. Одоо ингээд та нар өөрсдөө.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: С.Одонтуяа дарга ерөнхийдөө дүгнээд үг хэлчихлээ.

Ингээд цаг болсон байна. Ингээд үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. /алх цохив/

Ж.Сүхбаатар сайд болон ажлын хэсэгт баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-д хууль тогтоолын төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авах үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Улсын

Их Хурлын гишүүн Гонгорын Дамдиннямаас 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Тогтоолын төсөл татан авах тухай Улсын Их Хурлын албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

“Тогтоолын төсөл татан авах тухай” коронавируст халдвар КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал арилж нийгэм, эдийн засаг сайжирсантай холбоотойгоор 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Корона вируст халдвар цар тахлын улмаас эдийн засагт үүссэн хүндрэл бэрхшээлийг бууруулах, бизнес эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах зорилгоор авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна гэсэн байна.

Тогтоолын төслийг татан авсанд тооцлоо. /алх цохив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 4 цаг 55 минут үргэлжилж, 15 цаг 54 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД